МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХ
15170 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Ж.Самбуугийн гудамж 18, Утас: 26 15 44,
И-мэйл: info@supremecourt.mn

2024.11.01 № 01/5220
танай ____________-ны №____________-т

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД
О.АЛТАНГЭРЭЛ ТАНАА

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай
хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах
тухай хуулийн төслийн талаар

Таны 2024 оны 1/1332 дугаартай албан бичгээр санал авахаар ирүүлсэн "Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" хуулийн төслийг Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж, гаргасан саналыг нэгтгэн Шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.3 дахь заалтад заасны дагуу хавсралтаар хүргүүлэв.

Хавсралт 22 хуудастай.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ Д.ГАНЗОРИГ

D/Тоот 24
151701801161

Монгол Улсын дээд шүүхийн
Нийт шүүгчийн хуралдааны
2024 оны 10 дугаар сарын 30-ны
өдрийн 28 дугаар тогтоолын хавсралт

## ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ӨГӨХ САНАЛ

**2024.10.30** **Улаанбаатар хот**

| Д/д | ЭХХШтХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн холбогдох зүйл, хэсэг, заалт | УДШ-ийн Нийт шүүгчийн хуралдаанаас гаргасан санал | Тайлбар |
|---|---|---|---|
| **1 дүгээр зүйл.** Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг, заалт нэмсүгэй: | | | |
| 1/ | **5.1 дүгээр зүйлийн 2.7 дахь заалт:**<br>“2.7. Энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу хуулбарлан авах зорилгоор зураг, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн болон бусад техник хэрэгсэл ашиглах.” | Саналгүй. | |
| 2/ | **5.1 дүгээр зүйлийн 2.11 дэх заалт:**<br>“2.11.цахим хавтаст хэргийн мэдээллийн системд нэвтэрч хэргийн материалтай танилцах, хуулбарлан авах.” | Саналгүй. | |
| 3/ | **7.3 дугаар зүйлийн 5 дахь хэсэг:**<br>“5.Мөрдөн байцаалт дууссан бол хэргийн бүх материалтай биечлэн, эсхүл цахимаар танилцаж, төр, байгууллага, хувь хүний нууцад хамаарахаас бусад нотлох баримтыг | Саналгүй. | |

| | | | |
|---|---|---|---|
| | хуулбарлаж, хувилж авах эрхтэй." | | |
| 4/ | **11.11 дүгээр зүйлийн 7 дахь хэсэг:**<br>"7.Хавтаст хэргийг цахимжуулах, шүүх, прокурор, мөрдөн шалгах эрх бүхий байгууллагуудын нэгдсэн системд холбох журмыг Шүүхийн ерөнхий зөвлөл, Улсын ерөнхий прокурор, хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална." | Саналгүй. | |
| 5/ | **12.1 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг:**<br>"9.Мөрдөгч нь хэргийн оролцогчийн хүсэлтээр төрийн байгууллага, албан тушаалтны албаны цахим шуудан, албан бичиг солилцооны дундын систем, мэдэгдэл хүргэх систем, мөн иргэний төрийн үйлчилгээний нэгдсэн систем, мэдэгдэл хүргэх системд иргэний үүсгэсэн, бүртгүүлсэн цахим шуудан, тухайн этгээдийг таньж, баталгаажуулах боломжтой бусад цахим системд бүртгүүлэн холбогдсон хаягийг ашиглаж дуудаж, прокурорын мэдэгдэх хуудсыг хүргүүлж болно." | Саналгүй. | |
| 6/ | **14.10 дугаар зүйлийн 5 дахь хэсэг:**<br>"5.Мөрдөн шалгах ажиллагааны явцад гэмт хэрэг үйлдэж, яллагдагчаар татагдан цагдан хоригдсон бол цагдан хорих хугацааг шинээр тоолно." | Саналгүй. | |
| 7/ | **14.10 дугаар зүйлийн 14 дэх хэсэг:**<br>"14.Хоригдолд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авсан үед хорих ялын хугацаа дуусахаар бол энэ зүйлийн 7-д заасан журмын дагуу цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах эсэхийг шүүх шийдвэрлэнэ." | Санал: | Төслийн заалттай холбогдуулан ЭХХШТХ-ийн 14.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, мөн хуулийн 3.1 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт нэмэлт өөрчлөлт оруулах:<br><br>Цагдан хорих хугацааг сунгах журмыг зохицуулсан ЭХХШТХ-ийн 14.10 дугаар зүйлийн 2 дах хэсэгт "Шүүх энэ хуулийн 14.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан…" гэснийг |

| | | | |
|---|---|---|---|
| | | | “Шүүх энэ хуулийн 14.9 дүгээр зүйлд заасан…” гэж өөрчлөх,<br><br>Мөн ЭХХШТХ-ийн 3.1 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт “Шүүх энэ хуулийн 14.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.3, 1.5 дахь заалт, 31.5 дугаар зүйлд заасан асуудлыг хянан шийдвэрлэх ажиллагааг хуанлийн өдөр бүр шөнийн цагаас бусад цагт тасралтгүй хэрэгжүүлнэ.” гэсэн заалтад 31.4 заалтыг нэмэх шаардлагатай. |
| 8/ | **14.13 дугаар зүйлийн 13-14 дэх хэсэг:**<br>“13.Таслан сэргийлэх арга хэмжээний талаар талуудаас шүүхэд гаргасан санал, хүсэлт, тэдгээртэй холбоотой нотлох баримтыг эрүүгийн хэрэгт хавсаргана.<br><br>14.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч үед энэ хуулийн 14.1 дүгээр зүйлийн 1.2, 1.3, 1.5-д заасан таслан сэргийлэх арга хэмжээ авах, өөрчлөх, хүчингүй болгох, хүсэлт болон хугацааг сунгасан шүүхийн шийдвэрийг мөрдөгч, прокурорт мэдэгдэх бөгөөд шүүхийн шийдвэрийг цахим мэдээллийн сүлжээгээр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад даруй хүргүүлнэ.” | Саналгүй. | |
| 9/ | **15.7 дугаар зүйлийн 5 дахь хэсэг:**<br>“5.Дээд шатны прокурорын газар нь хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзсан, хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан, хэргийг хэрэгсэхгүй болгосон шийдвэрийг эс зөвшөөрч гаргасан гомдлыг хянаж шийдвэрлэнэ.” | Саналгүй. | |

16.3. 12 дахь хэсэг

| | | | |
|---|---|---|---|
| 10/ | **16.3 дугаар зүйлийн 10-11 дэх хэсэг:**<br>“10.Гэрчээр мэдүүлэг авч байх үед гэмт хэрэгт сэжиглэх үндэслэл илэрвэл мэдүүлэг авах ажиллагааг зогсоож, сэжигтнээр мэдүүлэг авах ажиллагааг энэ хуульд заасны дагуу явуулна.<br><br>11.Дүрс харж ярих боломжтой технологи, мэдээллийн хэрэгсэл ашиглан мэдүүлгийг авч болно. Энэ тохиолдолд өмгөөлөгч, хууль ёсны төлөөлөгч, асран хамгаалагчийн оролцоог хангаж дуу-дүрсний бичлэгээр бэхжүүлж, хавтаст хэрэгт хавсаргана.” | + Санал: | Гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүнийг гэрчээр дуудаж болохгүй талаар нэмж тусгах |
| 11/ | **16.14 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг:**<br><br>“5.Мөрдөн шалгах ажиллагааны явцад гэрч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, шинжээч, сэжигтэн, яллагдагчаас мэдүүлэг авахад бэхжүүлсэн дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн хувийг хавтаст хэргийн хамт хадгална.” | Санал: | Төслийн заалтыг Монгол Улсын дээд шүүхийн Нийт шүүгчийн хуралдааны 2023 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг зөв хэрэглэх тухай” 31 дүгээр тогтоолын 6 дахь хэсэгт заасан цахим баримтыг бэхжүүлэх, хадгалах, шилжүүлэх, цахим баримтын аюулгүй байдлыг хамгаалахтай холбоотой заалтад нийцүүлэх. |
| 12/ | **31.3 дугаар зүйлийн 6 дахь хэсэг:**<br>“6.Сэжигтэн эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолтой танилцах, гарын үсэг зурах, гардан авахаас татгалзсан нь мөрдөн шалгах ажиллагаа явуулахад саад болохгүй.” | Саналгүй. | |
| 13/ | **31.14 дүгээр зүйлийн 1.4 дэх заалт:**<br>“1.4.гадаад улсад эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх хүсэлт хүргүүлсэн бол.” | Саналгүй. | |

| | | | |
|---|---|---|---|
| 14/ | **32.9 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг:**<br>“3.Яллагдагчаар татах тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулж, яллагдагчаар татах тогтоолд оруулсан өөрчлөлтийг яллагдагчид танилцуулж, хувийг гардуулна.” | Саналгүй. | |
| 15/ | **32.10 дугаар зүйлийн 9 дэх хэсэг:**<br>“9.Төрийн нууцад хамаарах хэргийн яллах дүгнэлтийг танилцуулж, төрийн нууц мэдээлэл агуулсан хэсгийг хассан хувийг гардуулан өгнө.” | Саналгүй. | |
| 16/ | **33.3 дугаар зүйлийн 1.4 дэх заалт:**<br>“1.4.энэ хуулийн 32.1 дүгээр зүйлд заасан ажиллагааг бүрэн хийгээгүй.” | Саналгүй. | |

| | | | |
|---|---|---|---|
| 17/ | **34.9 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг:**<br>“5.Шүүгдэгч энэ хуулийн 35.9 дүгээр зүйлд заасны дагуу шүүх хуралдаанд оролцож, шүүхийн хэлэлцүүлэгт мэдүүлэг өгөх эсэх эрхээ эдэлсний дараа хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр шүүх хуралдааныг орхин явж, шүүх хуралдаанд оролцохоос санаатай зайлсхийсэн бол шүүх түүний эзгүйд шүүх хуралдааныг үргэлжлүүлэн явуулж, шүүгдэгч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай эсэхийг эцэслэн шийдвэрлэж болно. Шүүгдэгчийн эзгүйд шүүх хуралдааныг үргэлжлүүлэн явуулахад шүүгдэгчийн өмгөөлөгчийг оролцуулна.” | Санал:<br><br>Энэхүү заалт нь ЭХХШТХ-ийн 34.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Анхан шатны журмаар хэргийг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд шүүгдэгчийг оролцуулна. Шүүгдэгч ирээгүй нь шүүх хуралдааныг хойшлуулах үндэслэл болно.” гэсэн заалттай зөрчилдөж байх тул:<br><br>1.Уг заалтыг 2002 оны ЭБШХ-ийн 240 дүгээр зүйлийн 240.2 дахь хэсэгт заасан агуулгаар өөрчлөн найруулах,<br><br>2.2002 оны Эрүүгийн хуулийн 261 дүгээр зүйлийг сэргээн хуульчлах. | 2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 240 дүгээр зүйл. **Шүүгдэгч шүүх хуралдааны ажиллагаанд оролцох**<br><br>240.2.Шүүгдэгч нь Монгол Улсын хилийн гадна байгаа бөгөөд шүүхэд хүрэлцэн ирэхээс зайлсхийсэн бол хэргийг түүний байхгүйд хэлэлцэж болно.<br><br>2002 оны Эрүүгийн хуулийн 261 дүгээр зүйл. **Прокурорын хяналт, шүүх, цагдан хорих, хорих ангиас оргох**<br><br>261.1.Таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан прокурорын хяналт, шүүх, цагдан хорих, хорих ангиас оргосон, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүн таслах ажиллагаанаас зориуд зайлсхийсэн бол гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. |

| | | | |
|---|---|---|---|
| 18/ | **34.13 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:**<br>“2.Улсын яллагч, шүүгдэгч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч нь гэрч, шинжээч оролцуулах хүсэлтээсээ татгалзаагүй тохиолдолд шүүх талуудын хүсэлтийг харгалзан шүүх хуралдааныг хойшлуулах эсэхийг шийдвэрлэнэ.” | Санал:<br><br>Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан зохицуулалттай агуулга нь давхардаж байх тул хасах. | **34.13 дугаар зүйл.Шүүх хуралдаанд хохирогч, гэрч, шинжээч хүрэлцэн ирээгүйн холбогдол**<br>1.Шүүх хуралдаанд хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, түүний хууль ёсны төлөөлөгч, гэрч, шинжээч хүрэлцэн ирээгүй бол шүүх хуралдаан даргалагч түүнийг оролцуулахгүйгээр хэрэг хэлэлцэж болох эсэхийг улсын яллагч, шүүгдэгч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчөөс асууж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үргэлжлүүлэх, эсхүл хойшлуулах тухай асуудлыг шийдвэрлэнэ. |
| 19/ | **34.16 дугаар зүйлийн 6 дахь хэсэг:**<br>“6.Прокурор энэ хуулийн 5 дахь хэсэгт заасан ажиллагааг шүүхээс тогтоосон хугацаанд биелүүлэх боломжгүй бол шүүх хуралдааныг 30 хүртэл хоногоор хойшлуулж болно.” | Санал:<br><br>Шүүх хуралдааныг хойшлуулсан хугацаанд прокурор даалгасан ажиллагаар бүрэн биелүүлээгүй бол хэргийг прокурорт буцаана гэсэн агуулгаар өөрчлөх. | |
| 20/ | **34.16 дугаар зүйлийн 9 дэх хэсэг:**<br>“9.Шүүгдэгчийн сонгож авсан өмгөөлөгч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй, эсхүл шүүгдэгч өмгөөлөгчөөс татгалзсан тохиолдолд энэ хуулийн 5.2 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт заасны дагуу шүүх хуралдаанд өөр өмгөөлөгчийг томилж оролцуулна.“ | Саналгүй. | |

| | | | |
|---|---|---|---|
| 21/ | **34.19 дүгээр зүйлийн 1.9 дэх заалт:**<br>“1.9.нэмэлт нотлох баримтыг цуглуулах бүхий л ажиллагааг хийсэн боловч шүүгдэгч гэмт хэрэг үйлдсэн болох нь нотлогдоогүй.” | Саналгүй. | |
| 22/ | **35.7 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:**<br>“3.Шүүх хэд хэдэн шүүгдэгчид холбогдох хэрэгт энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу шүүхийн хэлэлцүүлэг явуулах дарааллыг тогтоохдоо өөрийнх нь хууль ёсны ашиг, сонирхол хөндөгдөхгүй шүүхийн хэлэлцүүлэг явагдах үед шүүх хуралдааны танхимд байлцахгүй байх талаар оролцогчийн гаргасан хүсэлтийг талуудын саналыг харгалзан шийдвэрлэж болно. Шүүх хүсэлтийг хангаж шийдвэрлэсэн бол энэ тухай шүүх хуралдааны тэмдэглэлд тусгаж, шүүх хуралдаанд үргэлжлүүлэн оролцох товыг оролцогчид мэдэгдэнэ.” | Саналгүй. | |
| 23/ | **36.13 дугаар зүйлийн 5, 6 дахь хэсэг:**<br>“5.Төрийн нууцад хамаарах мэдээлэл агуулсан шүүхийн шийдвэрийн нууц агуулаагүй “Удиртгал” болон “Тогтоох” хэсгийг нууцын тэмдэглэлээ, дардас дарахгүйгээр прокурор, оролцогчид гардуулж, нууц мэдээлэл агуулсан “Тодорхойлох” хэсгийг гардуулахгүйгээр, шүүхийн шийдвэрийг бүрэн бодитой танилцуулах арга хэмжээ авна.<br><br>6.Шүүхийн шийдвэрийн “Удиртгал” болон “Тогтоох” хэсэгт төрийн нууцад хамаарах мэдээлэл агуулагдсан бол тэр хэсгийг хасч хэвлэн, прокурор, оролцогчид гардуулна.” | Дэмжихгүй.<br><br>Төрийн нууцад хамаарах мэдээлэл агуулсан шүүхийн шийдвэрийг прокурор, оролцогчдод бүрэн эхээр нь гардуулж өгөх агуулгаар саналын томьёоллыг өөрчлөх саналтай. | Монгол Улсын нэгдэж орсон Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 14 дүгээр зүйлийн 1, 3 (а), 5 дахь заалт болон Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14 дэх хэсэг, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай 2024 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн хуулийн үзэл баримтлалд нийцэхгүй байна.<br><br>Энэ асуудлыг Төрийн нууц мэдээлэл агуулсан шүүхийн шийдвэрийг боловсруулах аргачлал, журмын талаар Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2021 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн 29 дүгээр тогтоолоор баталсан анхан, давж заалдах шатны шүүхийн |

| | | | |
|---|---|---|---|
| | | | шийдвэр боловсруулах аргачлал, журамд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэх боломжтой. |
| 24/ | **39.1 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг:**<br>“9.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэл нь иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагчийн гаргасан давж заалдах гомдлыг хянан шийдвэрлэхэд хамаарахгүй.” | Саналгүй. | |
| **2 дугаар зүйл.** Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн ..... нэмсүгэй. | | | |
| 1/ | Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.4 дүгээр зүйлийн 1.20 дахь заалт (*"талууд" гэж шүүх хуралдааны мэтгэлцээнд тэгш эрхтэй оролцож, яллах, өмгөөлөх чиг үүргийг хэрэгжүүлэгчийг)*-ын “гэж” гэсний дараа “шүүхийн хэлэлцүүлэг, шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг,” гэж,<br><br>мөн заалтын “оролцож,” гэсний дараа “санал, хүсэлтийнхээ үндэслэлийг тайлбарлах, танилцуулах оролцогч эсхүл” гэж, | Саналгүй. | |

| | | | |
|---|---|---|---|
| 2/ | 5.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг *(Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагчийн эрх, хууль ёсны сонирхлыг хамгаалах, хууль зүйн туслалцаа авах эрхээр хангах зорилгоор эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгчийг оролцуулна.)*-ийн “хохирогч,” гэсний дараа “гэрч,” гэж, | Дэмжихгүй. | ЭХХШТХ-ийн 9.6 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт зааснаар гэрч нь өмгөөлөгчтэй мэдүүлэг өгөх эрхтэй. Харин гэрчээс мэдүүлэг авахдаа заавал өмгөөлөгчөөр хангахыг мөрдөгчид үүрэг болгож болохгүй. Учир гэрч нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эрх ашиг нь хөндөгдсөн оролцогч биш. |
| | мөн зүйлийн 2.4 дэх заалт *(хууль зүйн туслалцаа үзүүлэхэд шаардлагатай эд зүйл, баримт бичиг, мэдээлэл, бусад баримтыг мөрдөгч, прокурорт гаргаж өгөх, түүнийг хавтаст хэрэгт бэхжүүлж тусгуулах, мөрдөн шалгах ажиллагаа явуулах хүсэлт гаргах, энэ хуульд заасан журмын дагуу оролцох)*-ын “тусгуулах” гэсний дараа “хэрэгт ач холбогдол бүхий бусад байдлыг шалгуулах,” гэж, | Саналгүй. | |
| | мөн зүйлийн 2.5 дахь заалт (*өмгөөлж байгаа сэжигтэн, хохирогч, яллагдагч, шүүгдэгч, ялтны, эсхүл өөрийнхөө хүсэлтээр хийгдэж байгаа мөрдөн шалгах ажиллагаанд байлцаж, аль ч үед асуулт тавих, хүсэлт гаргах)*-ын “асуулт тавих,” гэсний дараа “хариулт авах,” гэж, | Саналгүй. | |
| | мөн зүйлийн 2.12 дахь заалт *(сэжигтнийг баривчлах, яллагдагч, шүүгдэгчийг цагдан хорих, бусад таслан сэргийлэх арга хэмжээтэй холбоотой асуудлыг шийдвэрлэхэд оролцох)*-ын “оролцох” гэсний дараа “таслан сэргийлэх арга хэмжээ авах үндэслэл болсон мөрдөгч, прокурорын санал, шийдвэрийн үндэслэлд хамаарах баримт, мэдээлэлтэй танилцах” гэж, | Саналгүй. | |

| | | | |
|---|---|---|---|
| 3/ | 10.8 дугаар зүйлийн 3 дахь хэсэг (*Өмгөөлөгч энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэлээр татгалзаагүй бол тухайн ажиллагаанд оролцож байгаа сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, бусад өмгөөлөгч, прокурорын хүсэлтээр өмгөөлөгчийг татгалзан гаргах асуудлыг шүүх шийдвэрлэнэ.*)-ийн “оролцож байгаа” гэсний дараа “хохирогч,” гэж, | Саналгүй. | |
| 4/ | 7.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэг (*Яллагдагчаар татсан, таслан сэргийлэх арга хэмжээ авсан шийдвэртэй танилцах эрхтэй.*)-ийн “танилцах,” гэсний дараа “шийдвэрийн хувийг авах” гэж, | Саналгүй. | |
| 5/ | 14.13 дугаар зүйлийн 2 дахь хэсэг (*Шүүх энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан санал, хүсэлтийг хүлээн авснаас хойш 24 цагийн дотор асуудлыг хэлэлцэх шүүхийн хэлэлцүүлгийн товыг прокурор, өмгөөлөгчид мэдэгдэнэ.*)-ийн “прокурор,” гэсний дараа “яллагдагч, түүний хууль ёсны төлөөлөгч,” гэж, | Саналгүй. | |
| 6/ | 16.10 дугаар зүйлийн 4 дэх хэсэг (*Шүүх, прокурор, мөрдөгч энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан хүсэлт нь хэргийг тал бүрээс нь бүрэн бодитой тогтоохад ач холбогдолтой бол бүрэн, эсхүл хэсэгчлэн хангах, эсхүл хангахаас татгалзах тухай шийдвэр гаргана.*)- ийн гаргана .” гэсний дараа “Хүсэлтийг хэсэгчлэн хангасан эсхүл хангахаас татгалзсан үндэслэлийг шийдвэртээ тодорхой тусгана.” гэж, | Саналгүй. | |
| 7/ | 30.7 дугаар зүйлийн 1.3 дахь заалт (*хохирогч, гэрчээс мэдүүлэг авах*)-ын “гэрч,” гэсний дараа “сэжигтнээс” гэж, | Саналгүй. | |

| | | | |
|---|---|---|---|
| 8/ | 32.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг (*Мөрдөн шалгах ажиллагаа дууссаныг мэдэгдсэний дараа яллагдагч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, тэдний өмгөөлөгчид хавтаст хэргийн материалыг танилцуулах ба энэ тухай тэмдэглэл үйлдэнэ.*)-ийн “хэргийн материалыг” гэсний дараа “эх хувиар нь, эсхүл цахим хэлбэрээр” гэж, | Саналгүй. | |
| 9/ | 33.1 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг (*Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн товыг прокурор, өмгөөлөгчийн саналыг харгалзан шүүх тогтоож, урьдчилсан хэлэлцүүлэг явуулахаас 3-аас доошгүй хоногийн өмнө оролцогчид мэдэгдэнэ.*)-ийн “мэдэгдэнэ.” гэсний дараа “Прокурор, оролцогч ирээгүй нь шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг хойшлуулах үндэслэл болохгүй.” гэж, | Саналгүй. | |
| 10/ | 34.1 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг (*Энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан үндэслэлээр шүүх хуралдаан завсарлах тохиолдолд завсарлах хугацаа ажлын 5 өдрөөс хэтэрч болохгүй.*)- ийн болохгүй“.” гэсний дараа “Шүүгдэгч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй нь шүүх хуралдаан хойшлуулах үндэслэл болохгүй.” гэж, | Дэмжихгүй.<br><br>Хуулийн төслийн 34.9 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгтэй холбогдуулж өгсөн тайлбарыг үзэх. | |
| 11/ | 34.16 дугаар зүйлийн 2 дахь хэсэг (*Шүүх хуралдааныг хойшлуулахад талуудын санал, хүсэлтийг харгалзан дараагийн шүүх хуралдааны товыг тогтоож, хуралдааны бэлтгэл хангах арга хэмжээг авна.*)-ийн “авна.” гэсний дараа “Шүүх хуралдааныг хойшлуулахад хүндэтгэн үзэх шалтгаанаас бусад тохиолдолд энэ хуулийн 33.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасныг баримтална.” гэж тус тус нэмсүгэй. | Саналгүй. | |

| | | | |
|---|---|---|---|
| **3 дугаар зүйл.** Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн дараах зүйл, хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай: | | | |
| 1/ | **5.1 дүгээр зүйлийн 2.6 дахь заалт:**<br>- *"өөрийн оролцсон мөрдөн шалгах ажиллагаа, шүүхийн хэлэлцүүлэг, шүүх хуралдааны тэмдэглэлтэй танилцаж, засвар оруулах тухай хүсэлт гаргах;"* гэснийг<br>"2.6.мөрдөн шалгах ажиллагаа, шүүхийн хэлэлцүүлэг, шүүх хуралдааны үед хийгдсэн дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг болон тэмдэглэлтэй хэргийн материалтай танилцах үед хуулбарлан авах, тэмдэглэлд засвар оруулах тухай хүсэлт гаргах;" гэж, | Саналгүй.<br><br>Санал: | Хуулийн 7.3 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасантай уялдуулан Төр, байгууллага, хувь хүний нууцад хамаарахаас бусад нотлох баримтыг хуулбарлаж, хувилж авах эрхтэй гэсэн агуулгаар өөрчлөн найруулах |
| 2/ | **7.5 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт:**<br>- *"Яллагдагч шинжээч томилсон тогтоол, шинжээчийн дүгнэлт, мөрдөн байцаалт дууссаны дараа хавтаст хэргийн материалтай танилцах эрхтэй."* гэснийг<br>"4.Яллагдагч шинжээч томилсон тогтоол, шинжээчийн дүгнэлттэй танилцах, мөрдөн байцаалт дууссаны дараа хавтаст хэргийн материалтай танилцаж, төр, байгууллага, хувь хүний нууцад хамаарахаас бусад нотлох баримтыг дууны, дүрсний болон бусад техник хэрэгсэл ашиглан өөрийн зардлаар хуулбарлаж, хувилж авах эрхтэй." гэж, | Саналгүй. | |

| | | | |
|---|---|---|---|
| 3/ | **14.13 дугаар зүйлийн 5 дахь хэсэг:**<br>- *Прокурор“, яллагдагч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч гаргасан санал, хүсэлтийнхээ хууль зүйн үндэслэл, түүний нотлох баримтыг шүүх, шүүхийн хэлэлцүүлэгт оролцогчид танилцуулна.”* гэснийг<br><br>“5.Прокурор, яллагдагч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн гаргасан санал, хүсэлтийн үндэслэлд хамаарах баримт, мэдээллийг шүүх хэргийн оролцогчид танилцуулж, тэдгээрт тайлбар хийх, холбогдох баримт, мэдээллийг гаргаж өгөх боломжоор хангана. Талуудад танилцуулагдаагүй баримт, мэдээлэл нь шүүхийн шийдвэрийн үндэслэл болохгүй.” гэж, | Саналгүй. | |
| 4/ | **31.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:**<br>- *“Мөрдөгч эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолыг прокуророос хүлээн авсан даруй дуудан ирүүлсэн сэжигтэнд танилцуулна.”* гэснийг<br><br>“1.Мөрдөгч эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолыг прокуророос хүлээн авсан даруй дуудан ирүүлсэн сэжигтэнд танилцуулж, хувийг гардуулан өгнө. Төрийн нууцад хамаарах хэргийн яллагдагчаар татах тогтоолыг яллагдагч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчид гардуулахгүйгээр танилцуулна.” гэж, | Саналгүй. | |

| | | | |
|---|---|---|---|
| 5/ | **32.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг:**<br>- *“Хэргийн материалтай энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан оролцогч мөрдөгчөөс тогтоосон хугацаанд танилцах ба мөрдөгч хэргийн материалтай танилцах боломж, нөхцөлийг бүрдүүлнэ.”* гэснийг<br><br>“3.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан оролцогч хэргийн материалтай 14 хүртэл хоногийн хугацаанд танилцах ба мөрдөгч хэргийн материалтай танилцах боломж, нөхцөлийг бүрдүүлнэ. Хавтаст хэргийн тоо, хэргийн оролцогчдын тооноос хамааран хэргийн материалтай танилцах хугацааг мөрдөгч 14 хүртэл хоногоор сунгаж болно.” гэж, | Саналгүй. | |
| 6/ | **32.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:**<br>- *“Мөрдөгч мөрдөн шалгах ажиллагаа явуулж дууссаны дараа холбогдох саналыг хавтаст хэргийн хамт 3 хоногийн дотор прокурорт шилжүүлнэ.”* гэснийг<br><br>“1.Энэ хуулийн 32.1 дүгээр зүйлд заасан ажиллагаа бүрэн хийгдэж дууссаны дараа мөрдөгч холбогдох саналыг хавтаст хэргийн хамт 3 хоногийн дотор прокурорт шилжүүлнэ.“ гэж, | Саналгүй. | |

| | | | |
|---|---|---|---|
| 7/ | **32.10 дугаар зүйлийн 6 дахь хэсэг:**<br>- *"Прокурор яллах дүгнэлтийн хувийг яллагдагчид гардуулж, хавтаст хэргийг харьяалах шүүхэд шилжүүлсэн тухай яллагдагч, эсхүл түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчид мэдэгдэнэ."* гэснийг<br><br>"6.Прокурор хэргийг шүүхэд шилжүүлэхээс ажлын 3-аас доошгүй хоногийн өмнө яллах дүгнэлтийг яллагдагчид гардуулж, энэ талаар түүний хууль ёсны төлөөлөгч, хохирогч, өмгөөлөгчид мэдэгдэнэ." гэж, | Саналгүй. | |
| 8/ | **32.10 дугаар зүйлийн 8 дахь хэсэг:**<br>- *"Яллах дүгнэлт гардуулсны дараа хэргийн талаар гаргасан хүсэлт, гомдлыг шүүхэд шилжүүлнэ."* гэснийг<br><br>"8.Өмгөөлөгч хэргийг шүүхэд шилжүүлэхээс өмнө энэ хуулийн 32.1 дүгээр зүйлийн 6 дахь хэсэгт заасан яллагдагчийг шүүхэд шилжүүлэхтэй холбоотой санал, хүсэлтийг бичгээр гаргаж, хэрэгт хавсаргуулна." гэж, | Саналгүй. | |

| | | | |
|---|---|---|---|
| 9/ | **34.8 дугаар зүйлийн 1-2 дахь хэсэг:**<br>- *"1.Анхан шатны журмаар хэргийг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд оролцох тухай бичгээр хүсэлт гаргасан нөхцөлд хохирогчийг оролцуулна."* гэснийг<br><br>"1.Хохирогч бичгээр хүсэлт гаргасан, эсхүл улсын яллагч, яллагдагч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч хүсэлт гаргасан бол анхан шатны журмаар хэргийг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд хохирогчийг оролцуулна." гэж,<br><br>- *"Хохирогч ирээгүй нь шүүх хуралдааныг хойшлуулах үндэслэл болохгүй."* гэснийг<br><br>"2.Хохирогчийг шүүх хуралдаанд оролцуулахаар шүүх шийдвэрлэсэн бол хохирогч ирээгүй нь шүүх хуралдааныг хойшлуулах үндэслэл болно." гэж, | Саналгүй.<br><br><br><br><br><br><br><br><br><br><br><br>Саналгүй. | |
| **4 дүгээр зүйл.** Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн ..... өөрчилсүгэй. | | | |
| 1/ | Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 5.1 дүгээр зүйлийн 2.4 дэх заалт (*хууль зүйн туслалцаа үзүүлэхэд шаардлагатай эд зүйл, баримт бичиг, мэдээлэл, бусад баримтыг мөрдөгч, <u>прокурорт</u> гаргаж өгөх, түүнийг хавтаст хэрэгт бэхжүүлж тусгуулах, мөрдөн шалгах ажиллагаа явуулах хүсэлт гаргах, энэ хуульд заасан журмын дагуу оролцох*)-ын "прокурорт" гэснийг "прокурор, шүүхэд" гэж,<br><br>" мөн зүйлийн2.7-2.9" дэх заалтын дугаарыг "2.8-2.10" гэж, | Саналгүй. | |

| | | | |
|---|---|---|---|
| | "2.10-2.15" дахь заалтын дугаарыг "2.12-2.17" гэж, | | |
| 2/ | 9.6 дугаар зүйлийн 6 дахь хэсэг *(Гэрч өөрийнх нь эсрэг, түүнийг гэмт хэрэг үйлдсэн, гэм буруутай байдлаар мэдүүлэг авч байна гэж үзвэл энэ тухай тэмдэглэлд тусгуулан мэдүүлэг өгөхөөс татгалзаж, өмгөөлөгчтэй мэдүүлэг өгөх эрхтэй.)*-ийн "мэдүүлэг өгөхөөс татгалзаж, өмгөөлөгчтэй мэдүүлэг өгөх эрхтэй." гэснийг "мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхтэй." гэж,<br>14.10 " дугаар зүйлийн5-12" дахь хэсгийн дугаарыг "6-13" гэж, | Саналгүй. | |
| 3/ | 15.7 дугаар зүйлийн 2 дахь хэсэг (*Гомдлыг хүлээн авсан прокурор 14 хоногийн дотор, нэмэлт материал шалгах, эсхүл бусад арга хэмжээ авах бол 21 хоногийн дотор хянаж шийдвэрлэнэ.)*-ийн "21" гэснийг "30" гэж, | Саналгүй. | |
| 4/ | 21.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг *(Шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болох хүртэл, эсхүл эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолыг хүчингүй болгох, эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгосон шийдвэрт гомдол гаргах, давж заалдах хугацаа дуустал хураан авсан хөрөнгө, орлого, эд мөрийн баримтыг тусгай байранд хадгалж, энэ тухай баримтыг хавтаст хэрэгт хавсаргана.)*-ийн "эд мөрийн баримтыг" гэснийг "энэ хуулийн 16.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан баримтат мэдээллийг" гэж, | Саналгүй. | |

| | | | |
|---|---|---|---|
| 5/ | 31.2 дугаар зүйлийн гарчгийг “Сэжигтнийг дуудан ирүүлэх ажиллагаа” гэж,<br><br>мөн зүйлийн 1 дэх хэсэг *(Энэ хуульд заасны дагуу баривчлагдсан, эсхүл яллагдагчаар татах тогтоолтой танилцуулахаар мэдэгдэх хуудсаар дуудагдсан хүнийг сэжигтэн гэнэ.)*-ийн “дуудагдсан хүнийг” гэснийг “дуудагдсан, гэрчийн мэдүүлэг авах үед гэмт хэрэгт сэжиглэх үндэслэл тогтоогдсон хүнийг” гэж, | Саналгүй.<br><br>Саналгүй. | |
| 6/ | 32.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг *(Мөрдөн шалгах ажиллагаа дууссаныг мэдэгдсэний дараа яллагдагч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, тэдний өмгөөлөгчид хавтаст хэргийн материалыг танилцуулах ба энэ тухай тэмдэглэл үйлдэнэ.)*-ийн “тэдний өмгөөлөгчид” гэснийг “тэдний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчид” гэж,<br><br>мөн зүйлийн 9 дэх хэсэг (*Нэмэлт мөрдөн байцаалт явуулсан бол нэмж хийсэн ажиллагааны материалыг тухайн ажиллагаанд холбогдох оролцогчид танилцуулна.)*-ийн “тухайн ажиллагаанд холбогдох оролцогчид танилцуулна.” гэснийг “энэ зүйлд заасан журмын дагуу оролцогчид танилцуулна.” гэж, | Саналгүй.<br><br>Саналгүй. | |
| 7/ | 34.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэг (*Шүүгдэгчийг хэд хэдэн өмгөөлөгч өмгөөлж байгаа бол шүүх хуралдаанд тодорхой асуудлаар мэтгэлцэхэд нэг өмгөөлөгч бусдыгаа төлөөлж болно.)*-ийн “төлөөлж болно.” гэснийг “төлөөлнө.” гэж, | Саналгүй. | |

| | | | |
|---|---|---|---|
| 8/ | 34.12 дугаар зүйлийн 3 дахь хэсэг (*Улсын яллагч, өмгөөлөгч, иргэдийн төлөөлөгч шүүх хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй нь хариуцлага хүлээлгэх үндэслэл болно.)*-ийн “болно.” гэснийг “болох ба энэ талаарх мэдээллийг харьялах прокурорын байгууллага, Монголын Өмгөөлөгчдийн холбоонд даруй хүргүүлнэ.” гэж, | Санал: | Шүүх хуралдааны дэг болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн оролцогчид хариуцлага хүлээлгэх асуудлыг зохицуулсан Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн холбогдох заалтад өөрчлөлт оруулах талаар УДШ-ээс 2024 оны 4 дүгээр сарын 25-нд хууль санаачлагчид хүргүүлсэн саналыг хуулийн төсөлд нэмж тусгах |
| 9/ | 34.16 “ дугаар зүйлийн6-7” дахь хэсгийн дугаарыг “7-8” гэж, | Саналгүй. | |
| 10/ | 34.19 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “1.1-д” гэснийг “1.9-д” гэж тус тус өөрчилсүгэй. | Саналгүй. | |
| | **5 дугаар зүйл.** Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн ..... хассугай. | | |
| | Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 5.3 дугаар зүйл (*Дараах сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч оролцох эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг өмгөөлөгчгүйгээр явуулж болохгүй)-ийн* 1.6 дахь заалтын “төлбөрийн чадваргүйн улмаас” гэснийг, | Саналгүй. | |
| | 16.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэг (*Эрүү шүүлт тулгаж, бусад хэлбэрээр хүнлэг бус, хэрцгий харьцаж мэдүүлэг авсан нь тогтоогдвол авсан мэдүүлгийг энэ хуулийн 16.11 дүгээр зүйлд заасан журмаар нотлох баримтаар тооцохгүй.)*-ийн “энэ хуулийн 16.11 дүгээр зүйлд заасан журмаар” гэснийг, | Саналгүй. | |

| | | | |
|---|---|---|---|
| | 32.9 дүгээр зүйлийн гарчиг (*Прокурор яллах дүгнэлт үйлдэх үед яллагдагчаар татах тогтоолд өөрчлөлт оруулах*),<br>мөн зүйлийн 1 дэх хэсэг (*Прокурор яллах дүгнэлт үйлдэх үед яллагдагчийг буруутгаж байгаа Эрүүгийн хуулийн зүйл, хэсэг, заалтыг өөрчлөх, нэмэлт оруулах бол яллагдагчаар татах тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулж, яллагдагчаар татах тогтоолд оруулсан өөрчлөлтийг яллагдагчид танилцуулахыг мөрдөгчид даалгана.*)-ийн "яллах дүгнэлт үйлдэх үед" гэснийг, | Саналгүй. | |
| | 34.16 дугаар зүйлийн 3 дахь хэсэг (*Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэл нь хоёр ба түүнээс дээш удаа давтагдаж эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд санаатай саад учруулах нөхцөл болж байвал шүүх хуралдааныг хойшлуулахгүй байж болно.*)-ийн "хоёр ба түүнээс дээш удаа давтагдаж" гэснийг,<br><br>мөн зүйлийн 5 дахь хэсэг (*Шүүх хуралдааны явцад нотлох баримтаар тогтоогдсон хэргийн нөхцөл байдлыг үндэслэн шүүгдэгчид холбогдох хэргийн зүйлчлэлийг хүндрүүлэхээр бол, эсхүл энэ хуулийн 33.1 дүгээр зүйлийн 6.13, 6.14-т заасан гомдлыг шийдвэрлэх зорилгоор шүүх хэргийг хянан хэлэлцэхийг нэг удаа 60 хүртэл хоногоор хойшлуулна.*)-ийн "нэг удаа" гэснийг тус тус хассугай. | Саналгүй. | |
| **6 дугаар зүйл.** Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн ... хүчингүй болсонд тооцсугай. | | | |

| | | | |
|---|---|---|---|
| | Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 32.1 дүгээр зүйлийн 10 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай. | Саналгүй. | |
| **7 дугаар зүйл.** Энэ хуулийн 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө. | | | |

**МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХ**

МОНГОЛ УЛСЫН
ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ
КОМИСС

Засгийн газрын 12 дугаар байр, Барилгачдын талбай-2,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170
Утас: (+976) 7000 0222, (+976-51) 26 29 31
Цахим шуудан : info@nhrcm.gov.mn
Цахим хуудас : www.nhrcm.gov.mn

2024. 11. 11 № 01/1761

танай ____________-ны № ____________-т

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗРЫН ГИШҮҮН, ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД
О.АЛТАНГЭРЭЛ ТАНАА

Хариу хүргүүлэх тухай

Танай яамнаас боловсруулан ирүүлсэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зарчмын хувьд дэмжиж байгаа бөгөөд дараах саналыг тусгуулахаар хүргүүлж байна. Үүнд:

1. Хуулийн төслийн 14.10 дугаар зүйлийн 5 дахь хэсгийг хасах, ерөнхий зохицуулалтаар буюу одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулийн заалтаар шийдвэрлэх;

2. Шүүхийн шатанд шүүгдэгчид цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авч хоригдсон хугацааг нийт цагдан хорьсон хугацаанд оруулан тооцохгүй байгаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.10 дугаар зүйлийн 12 дахь хэсгийг хасах.

ДАРГА Д.СҮНЖИД

150022110

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗАР

Хуульчдын гудамж 15/1, Бага тойруу,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160-0027
Утас: 26 08 55, Факс: (976-51) 26 37 39,
Цахим шуудан: gpo@prokuror.mn,
Цахим хуудас: www.prokuror.mn

2024.11.08 № 1/7283

танай ____________-ны №____________-т

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД
О.АЛТАНГЭРЭЛ ТАНАА

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй танилцаад, саналыг хавсралтаар хүргүүлэв.

Хавсралт 26 хуудастай.

УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН
ОРЛОГЧ, ТӨРИЙН ХУУЛЬ ЦААЗЫН
ШАДАР ЗӨВЛӨХ М.ЧИНБАТ

15010411277

*Улсын ерөнхий прокурорын газрын*
*2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн*
*1/7283 дугаартай албан бичгийн хавсралт*

**ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ГАРГАСАН САНАЛ**

2024.11.08 Улаанбаатар хот

| № | Зүйл, хэсэг, заалт | Гаргасан санал | | | Саналын үндэслэл, хэрэгцээ, шаардлага |
|---|---|---|---|---|---|
| | | Өөрчлөх | Нэмэх | Хасах | |
| *0* | *1* | *2* | *3* | *4* | *5* |
| 1 | **Хуулийн төслийн 1 дүгээр зүйл.** **4/11.11 дүгээр зүйлийн 7 дахь хэсэг:** 7.Хавтаст хэргийг цахимжуулах, шүүх, прокурор, мөрдөн шалгах эрх бүхий байгууллагуудын нэгдсэн системд холбох журмыг Шүүхийн ерөнхий зөвлөл, Улсын ерөнхий прокурор, хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална” | | “...нэгдсэн системд холбох” гэсний дараа “ашиглах” гэж нэмэх. | | Хавтаст хэргийг цахимжуулах, шүүх, прокурор, мөрдөн шалгах эрх бүхий байгууллагуудын нэгдсэн системд холбохоос гадна уг системийг ашиглах асуудлыг журамд тусгах шаардлагатай. |
| 2 | **Хуулийн төслийн 1 дүгээр зүйл.** **7/14.10 дугаар зүйлийн 14 дэх хэсэг:** Хоригдолд цагдан хорих | “14.Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах тухай шүүгчийн захирамжийн дагуу | | | ШШГТХ-ийн 212 дугаар зүйлийн 2-т “Энэ хуулийн 212.1-д заасны дагуу шилжүүлэх тохиолдолд хоригдлыг яллагдагчид цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах тухай шүүгчийн захирамжийг үндэслэн |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | таслан сэргийлэх арга хэмжээ авсан үед хорих ялын хугацаа дуусахаар бол энэ зүйлийн 7-д заасан журмын дагуу цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах эсэхийг шүүх шийдвэрлэнэ. | хоригдлыг цагдан хорих байранд хүлээн авсан өдрөөс эхлэн цагдан хорих хугацааг тоолж, энэ зүйлд заасан журмын дагуу цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг сунгах эсэхийг шүүх шийдвэрлэнэ." гэж өөрчлөх. | | | шилжүүлэн авсан албан тушаалтан цагдан хорих төв, эсхүл цагдан хорих байранд хүргэх бөгөөд уг хугацааг ял эдэлсэн хугацаанд тооцно" гэж заасан.<br>Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авсан шүүгчийн захирамж гарч, тус шийдвэрийг биелүүлэх зорилгоор хоригдлыг хорих ангиас очиж авах, шүүгчийн захирамжид заасан цагдан хорих төв, байранд хүргэх, цагдан хорих төв байр нь хоригдлыг шүүгчийн захирамжийн хамт зохих журмын дагуу хүлээн авснаар хоригдол нь яллагдагчийн эрхийг эдэлнэ.<br>Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах тухай шүүгчийн захирамж гарсан хэдий ч тус захирамж биелээгүй буюу цагдан хорих төв, байр яллагдагчийг хүлээн аваагүй тохиолдолд яллагдагчаар цагдан хоригдсон гэж үзэх үндэслэлгүй юм. Өөрөөр хэлбэл, хорих ангиас цагдан хорих төв, байр хүртэлх зам хоногийг хорих ял эдэлсэн хугацаанд оруулан тооцох тухай ойлголт юм.<br>Ийнхүү цагдан хорих төв, байранд хүргэгдэн, өмнөх, эсхүл дахин гэмт хэрэгт холбогдож, яллагдагчаар цагдан хоригдсон үеэс тасалбар болгон хорих ял биечлэн эдэлсэн хугацааг зогсоох буюу хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолын биелэлтийг түр зогсоох нь зүйтэй. Учир нь хоригдол, |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | | яллагдагчийн эрх зүйн байдал, дэглэм журам харилцан адилгүй юм.<br>Түүнчлэн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолоор хорих ял эдэлж буй ялтан шүүхийн шийтгэх тогтоол гарахаас өмнө, эсхүл ял эдэлж байх хугацаандаа гэмт хэрэг үйлдсэн гэх хангалттай үндэслэл тогтоогдсон бол прокуророос ЭХХШТХ-д заасан үндэслэл журмын дагуу түүнд эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татах тухай шийдвэр гаргаж, улмаар эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг шуурхай явуулж, шийдвэрлэх нь ЭХХШТХ-ийн "гэмт хэргийг шуурхай, бүрэн илрүүлэх, гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоон шударгаар ял оногдуулах, хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх" зорилтод бүрэн нийцнэ.<br>ЭХХШТХ-ийн 14.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Яллагдагч, шүүгдэгчид энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу дараах таслан сэргийлэх арга хэмжээ авна" гэж заасны дагуу яллагдагчийн холбогдсон гэмт хэргийн шинж, байдал, нийгмийн хор аюул, хувийн байдал зэргийг харгалзан хуульд заасан 6 төрлийн таслан сэргийлэх арга хэмжээнээс сонгож авах үндэслэл, журмыг тогтоосон ба хүчин төгөлдөр шийтгэх тогтоолоор хорих ял эдэлж буй ялтанд цагдан хорихоос өөр төрлийн таслан сэргийлэх арга хэмжээ авах |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | | боломжгүй юм.<br>Мөн ЭХХШТХ-д заасан яллагдагчийн "мөрдөн шалгах ажиллагаанд биечлэн оролцох, өмгөөлөгчтэйгөө уулзах, гомдол хүсэлт гаргах, мэдээлэл авах, шүүхийн хэлэлцүүлэгт оролцох" зэрэг эрхийг хангах, хэргийн мөрдөн шалгах ажиллагааг шуурхай явуулж, хүний эрхийг шуурхай сэргээн тогтоох зэрэг хэрэгцээ шаардлага үүсдэг<br>Хорих ял эдэлж буй хоригдлын ял эдэлж буй хорих ангийн дэглэм, журмаас хамаарч хоригдлын эрх, эрх чөлөө, хүлээх үүрэгт тодорхой хязгаарлалт, дэглэм журам үйлчлэх бөгөөд энэ нь ЭХХШТХ болон ШШГТХ-иар зохицуулсан процесс ажиллагаа, журамд нийцэхгүй буюу тохирохгүй, мөн яллагдагчийн эрх, үүргийн хэрэгжилт хангагдах боломжгүй байдалд хүргэнэ.<br>Ийм учраас ШШГТХ-ийн 212 дугаар зүйлийн 212.1-д "Хоригдол шүүхийн шийтгэх тогтоол гарахаас өмнө, эсхүл ял эдэлж байх хугацаандаа гэмт хэрэг үйлдсэн гэх хангалттай үндэслэл тогтоогдсон бол прокурорын зөвшөөрлийг үндэслэн хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллагад шилжүүлж болно" гэж, Прокурорын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1-д "Хуульд заасан тохиолдолд прокурор зөрчил шалган шийдвэрлэх, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагааны явцад зөвшөөрөл өгнө" гэж, мөн хорих ял |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | | эдэлж буй хүнд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах үндэслэлийг ЭХХШТХ-д 2024 оны 01 дүгээр сарын17-ны өдөр нэмэлт, өөрчлөлт оруулсан.<br>Хоригдолд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах нь түүний хорих ял эдэлж буй гэмт хэрэгтэй хамааралгүй бөгөөд түүнийг шүүхээс гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцсон тохиолдолд цагдан хоригдсон хугацааг эдлэх ялд нь оруулан тооцох талаар ЭХХШТХ-д, мөн хэд хэдэн шийтгэх тогтоолоор оногдуулсан ялыг нэмж нэгтгэх талаар Эрүүгийн хуулийн 6.9-д тодорхой зохицуулсан. |
| 3 | **Хуулийн төслийн 1 дүгээр зүйл.**<br>**18/34.13 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:**<br>2.Улсын яллагч, шүүгдэгч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч нь гэрч, шинжээч оролцуулах хүсэлтээсээ татгалзаагүй тохиолдолд шүүх талуудын хүсэлтийг харгалзан шүүх хуралдааны хойшлуулах эсэхийг шийдвэрлэнэ. | “2.Гэрч, шинжээч оролцуулах тухай хүсэлтийг хангаж, шүүх хуралдааныг хойшлуулсан боловч шүүх хуралдаанд хүрэлцэн ирээгүй, улсын яллагч, шүүгдэгч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч уг хүсэлтээсээ татгалзаагүй тохиолдолд шүүх талуудын | | | ЭХХШТХ-ийн 34.13 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зохицуулалттай ижил агуулгатай буюу зохицуулалтын давхардал үүсэж байх тул найруулгыг өөрчлөх нь зүйтэй байна. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | хүсэлтийг харгалзан шүүх хуралдааны хойшлуулах эсэхийг шийдвэрлэнэ.” гэж өөрчлөх. | | | |
| 4 | **Хуулийн төслийн 1 дүгээр зүйл. 19/34.16 дугаар зүйлийн 6 дахь хэсэг:** “6.Прокурор энэ хуулийн 5 дахь хэсэгт заасан ажиллагааг шүүхээс тогтоосон хугацаанд биелүүлэх боломжгүй бол шүүх хуралдааныг 30 хүртэл хоногоор хойшлуулж болно” | “6.Прокурор энэ зүйлийн 5 дахь хэсэгт заасан ажиллагааг шүүхээс тогтоосон хугацаанд биелүүлэх боломжгүй бол шүүх хуралдааныг нэг удаа 30 хүртэл хоногоор хойшлуулж болно” гэж өөрчлөх. | | | Хуулийн төслийн энэ хэсэгт “хуулийн” гэснийг “зүйлийн” гэж өөрчлөх. Мөн шүүх хуралдааныг 30 хүртэл хоногоор хойшлуулж болно гэж заасан нь хэдэн ч удаа хойшлуулж болохоор зохицуулалт байна. Энэ нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчдыг чирэгдүүлэх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа удаашрах үр дагавар үүсгэхээр байх тул нэг удаа 30 хүртэл хоногоор хойшлуулах нь зүйтэй. |
| 5 | **Хуулийн төслийн 1 дүгээр зүйл. 23/36.13 дугаар зүйлийн 5, 6 дахь хэсэг**: “5.Төрийн нууц мэдээлэл агуулсан шүүхийн шийдвэрийн нууц агуулаагүй “Удиртгал” болон “Тогтоох” хэсгийг нууцын тэмдэглэлээ, дардас дарахгүйгээр прокурор, оролцогчид гардуулж, нууц мэдээлэл агуулсан “Тодорхойлох” | | | 5, 6 дахь заалтаас “прокурор” гэснийг тус тус хасах. | Прокурорын тухай хуулийн 25 дугаар зүйлд заасны дагуу Улсын ерөнхий прокурор, түүний тусгайлан эрх олгосон прокурор мөрдөн шалгах нууц ажиллагаа, гүйцэтгэх ажилд хяналт тавьж ажилладаг бөгөөд нууц мөрдөн шалгах ажиллагаа явуулах, түүнтэй прокурор танилцах, хяналт тавих, нууцыг хамгаалахтай холбоотой харилцааг холбогдох хууль, журмаар зохицуулдаг. Түүнчлэн төрийн нууцад хамаарах мэдээлэл агуулсан эрүүгийн хэргийн |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | хэсгийг гардуулахгүйгээр, шүүхийн шийдвэрийг бүрэн бодитой танилцуулах арга хэмжээ авна"<br>"6.Шүүхийн шийдвэрийн "Удиртгал" болон "Тогтоох" хэсэгт төрийн нууцад хамаарах мэдээлэл агуулагдсан бол тэр хэсгийг хасаж хэвлэн, прокурор, оролцогчид гардуулна" | | | | мөрдөн шалгах ажиллагаанд тухайн хэрэгтэй танилцах, хянах, нууц мэдээллийг хадгалах үүрэг бүхий тусгай эрх олгогдсон прокурор хяналт тавьж ажиллан шүүхэд шилжүүлж шийдвэрлүүлсэн байхад тухайн прокурорт шүүхийн шийтгэх тогтоолын холбогдох хэсгийг нууцлан танилцуулах, гардуулах нь өрөөсгөл бөгөөд агуулгын хувьд алдаатай байна.<br>Харин тухайн хэргийн оролцогчид танилцуулах, гардуулах ажиллагаатай холбоотой харилцааг ийнхүү зохицуулж, хуульд нэмэлт өөрчлөлт оруулах нь зүйтэй юм. |
| 6 | **Хуулийн төслийн 2 дугаар зүйл.**<br>**5.1 дүгээр зүйлийн 2.5 дахь заалт:**<br>"асуулт тавих" гэсний дараа "хариулт авах" | | | Хасах | Өмгөөлөгчөөс асуусан асуултад хариулт заавал өгөхөөр зохицуулалт тусгасан нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нийцээгүй байна. Тухайлбал, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 7.4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт "яллагдагчийг өөрийнх нь эсрэг мэдүүлэг авахаар албадахыг хориглоно" гэж заасан. |
| 7 | **Хуулийн төслийн 2 дугаар зүйл.**<br>**5.1 дүгээр зүйлийн 2.12 дахь заалт:**<br>"оролцох" гэсний дараа "таслан сэргийлэх арга хэмжээ авах үндэслэл болсон мөрдөгч, прокурорын санал, | "таслан сэргийлэх арга хэмжээ авах үндэслэл болсон мөрдөгч, прокурорын санал, шийдвэрийн үндэслэл, түүний нотлох баримттай | | | ЭХХШТХ-ийн 14.13 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасантай нийцүүлэн таслан сэргийлэх арга хэмжээ авах үндэслэл болсон мөрдөгч, прокурорын санал, шийдвэрийн үндэслэл, түүний нотлох баримттай танилцах эрхтэй гэж тусгах нь зүйтэй байна. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | шийдвэрийн үндэслэлд хамаарах баримт, мэдээлэлтэй танилцах” | танилцах” гэж өөрчлөх. | | | |
| 8 | **Хуулийн төслийн 3 дугаар зүйл.**<br>**1/5.1 дүгээр зүйлийн 2.6 дахь заалт:**<br>2.6.Мөрдөн шалгах ажиллагаа, шүүхийн хэлэлцүүлэг, шүүх хуралдааны үед хийгдсэн дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг болон тэмдэглэлтэй хэргийн материалтай танилцах үед хуулбарлан авах, тэмдэглэлд засвар оруулах тухай хүсэлт гаргах. | | | “...хэргийн материалтай” гэснийг хасах. | Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 32.1 дүгээр зүйлд “мөрдөгч мөрдөн шалгах бүх ажиллагааг хийж дууссан, хэргийн бодит байдлыг бүрэн нотолж тогтоосон гэж үзвэл яллагдагч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, тэдний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчид хавтаст хэргийн материалтай танилцуулж, хэрэгт тусгагдсан эд мөрийн баримт, мөрдөн шалгах ажиллагааны тэмдэглэлд тусгагдсан дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгтэй танилцах тухай оролцогчийн хүсэлтийг хангах арга хэмжээ авах. Оролцогч хүсэлт гаргавал хавтаст хэргийн материалаас шүүхээр хэлэлцүүлэх төрийн нууцад хамаарахаас бусад нотлох баримтыг өөрийн зардлаар хуулбарлаж, хувилж авах боломжоор хангах”,<br><br>Мөн 5.1 дүгээр зүйлд өмгөөлөгч нь “өмгөөлж байгаа сэжигтэн, хохирогч, яллагдагч, шүүгдэгч, ялтны, эсхүл өөрийнхөө хүсэлтээр хийгдэж байгаа мөрдөн шалгах ажиллагаанд байлцаж, аль ч үед асуулт тавих, хүсэлт гаргах; өөрийн оролцсон мөрдөн шалгах ажиллагаа, шүүхийн хэлэлцүүлэг, шүүх хуралдааны |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | | тэмдэглэлтэй танилцаж, засвар оруулах тухай хүсэлт гаргах;" эрхийг хуульчилсан. |
| 9 | **Хуулийн төслийн 3 дугаар зүйл.** **3/14.13 дугаар зүйлийн 5 дахь хэсэг:** 5.Прокурор, яллагдагч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн гаргасан санал, хүсэлтийн үндэслэлд хамаарах баримт, мэдээллийг шүүх хэргийн оролцогчид танилцуулж, тэдгээрт тайлбар хийх, холбогдох баримт, мэдээллийг гаргаж өгөх боломжоор хангана. Талуудад танилцуулагдаагүй баримт, мэдээлэл нь шүүхийн шийдвэрийн үндэслэл болохгүй. | | | Хасах | Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.13 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт "Прокурор, яллагдагч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч гаргасан санал, хүсэлтийнхээ үндэслэлийг шүүхэд танилцуулна" гэж заасан ба сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид холбогдох хэсгийг танилцуулах зохицуулалт байхгүй.<br>Мөн хуулийн 32.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар мөрдөн шалгах ажиллагаа дууссаны дараа хэргийн материалтай танилцах, өөрийн зардлаар хуулбарлан авах тухай зохицуулалт тусгагдсан. Мөрдөн шалгах ажиллагаа дуусаагүй байх үед өмгөөлөгчид нотлох баримттай танилцуулах нь мөрдөн шалгах ажиллагааны нууцлал, үр дүнд хамаарна. |
| 10 | **Хуулийн төслийн 3 дугаар зүйл.** **7/32.10 дугаар зүйлийн 6 дахь хэсэг:** 6.Прокурор хэргийг шүүхэд шилжүүлэхээс ажлын 3-аас доошгүй хоногийн өмнө яллах дүгнэлтийг яллагдагчид гардуулж, энэ талаар түүний хууль ёсны төлөөлөгч, хохирогч, | "6.Прокурор яллах дүгнэлтийг хувийг яллагдагчид гардуулж, хавтаст хэргийн материалыг ажлын 3 хоногийн дараа харьяалах шүүхэд шилжүүлэх тухай яллагдагч, түүний | | | Утга найруулгыг засах шаардлагатай. Учир нь прокурор хэргийг хянаад шүүхэд шилжүүлэх үндэслэлтэй гэж үзвэл яллах дүгнэлт үйлдэх ба ийнхүү үйлдсэн яллах дүгнэлтээ яллагдагчид гардуулж, улмаар хэргийг шүүхэд шилжүүлдэг. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | өмгөөлөгчид мэдэгдэнэ. | хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчид мэдэгдэнэ" гэж өөрчлөх. | | | |
| 11 | **Хуулийн төслийн 4 дүгээр зүйл.**<br>**5.1 дүгээр зүйлийн 2.4 дэх заалт:**<br>прокурорт гэснийг "прокурор, шүүхэд" | | | Хасах | Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "нотлох баримтыг тал бүрээс нь бүрэн бодитойгоор шалгаж хянасны үндсэн дээр хэргийн бодит байдлыг тогтоох" үүргийг, 16.4 дүгээр зүйлд энэ хуульд заасан мөрдөн шалгах ажиллагаа явуулах замаар нотлох баримт цуглуулж бэхжүүлэх ажиллагаа явуулахыг мөрдөгчид даалгасан зохицуулалттай нийцэхгүй байна.<br>Энэ зохицуулалтыг одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 5.1 дүгээр зүйлд заасан "хууль зүйн туслалцаа үзүүлэхэд шаардлагатай эд зүйл, баримт бичиг, мэдээлэл, бусад баримтыг мөрдөгч, прокурорт гаргаж өгөх, хавтаст хэрэгт бэхжүүлж тусгуулах, мөрдөн шалгах ажиллагаа явуулах хүсэлт гаргах; энэ хуульд заасан журмын дагуу оролцох, өмгөөлж байгаа сэжигтэн, хохирогч, яллагдагч, шүүгдэгч, ялтны, эсхүл өөрийнхөө хүсэлтээр хийгдэж байгаа мөрдөн шалгах ажиллагаанд байлцаж, аль ч үед асуулт тавих, |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | | хүсэлт гаргах; өөрийн оролцсон мөрдөн шалгах ажиллагаа, шүүхийн хэлэлцүүлэг, шүүх хуралдааны тэмдэглэлтэй танилцаж, засвар оруулах тухай хүсэлт гаргах; өөрсдийнх нь зөвшөөрснөөр хүн, хуулийн этгээдээс хэрэгт ач холбогдол бүхий тайлбар, баримт бичиг, лавлагаа, тодорхойлолт гаргуулж авах эрхийн хүрээнд хэрэгжүүлэх боломжтой юм. |
| 12 | **Хуулийн төслийн 4 дүгээр зүйл.**<br>**21.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг:**<br>"эд мөрийн баримтыг" гэснийг "энэ хуулийн 16.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан "баримтат мэдээллийг" | | | Хасах | ЭХХШТХ-ийн 16.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "Баримтат мэдээлэл нь гэрч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн мэдүүлэг, эд мөрийн баримт, баримт бичиг, шинжээчийн дүгнэлт, мэдүүлэг, мөрдөгчийн магадалгаа, энэ хуульд заасны дагуу бэхжүүлсэн кино ба гэрэл зураг, зураглал, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг, эрх бүхий байгууллагын цахим мэдээллийн сангаас цахим гарын үсгээр баталгаажуулж авсан лавлагаа, тодорхойлолт, ул мөрөөс авсан хэв, мөрдөн шалгах ажиллагааны болон шүүх хуралдааны тэмдэглэл, хүн, хуулийн этгээд, албан тушаалтнаас ирүүлсэн гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл болон энэ хуульд заасан бусад баримтаар тогтоогдоно" гэж заасан.<br>ЭХХШТХ-ийн 21.1 дүгээр зүйлд |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | | эрүүгийн хэрэгт хураан авсан хөрөнгө, орлого, эд мөрийн баримтыг хадгалахтай холбоотой харилцааг зохицуулсан бөгөөд тус зүйлийн 2 дахь хэсэгт шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болох хүртэл, эсхүл яллагдагчаар татах тогтоолыг хүчингүй болгох, хэргийг хэрэгсэхгүй болгох шийдвэрт давж заалдах хугацаа дуустал хураан авсан хөрөнгө, орлого, эд мөрийн баримтыг тусгай байранд хадгалахтай холбоотой зохицуулалтыг тусгасан.<br>Гэтэл эрүүгийн хэрэгт хураан авсан хөрөнгө, орлого, эд мөрийн баримтыг тухайн хэргийг шийдвэрлэсэн прокурор, шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болох хүртэл хугацаанд тодорхой орчин, нөхцөл бүхий тусгай байранд /хавтаст хэргээс тусад нь/ хадгалах тухай зохицуулалтад эрүүгийн хэргийн нотлох баримт буюу "баримтат мэдээлэл"-ийг бүхэлд нь хамааруулсан нь ойлгомжгүй, алдаатай байна.<br>Өөрөөр хэлбэл, хавтаст хэрэгт авагдсан баримтат мэдээллийг эд мөрийн баримт, хураан авсан эд зүйл, хөрөнгө, орлогын хамт тусгай орчин нөхцөл бүхий байранд хадгалах тухай ойлголт байх тул бүхэлд нь хасах үндэслэлтэй байна. |
| 13 | **ЭХХШТХ-ийн 43 дугаар** | | "43.7 дугаар зүйл. Гэмт хэрэг үйлдсэн | | Прокурорын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2-т "Улсын ерөнхий |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | **бүлэг:**<br><br>гэмт хэрэг үйлдсэн хүнийг гадаад улсад эрэн сурвалжлах зохицуулалтыг тусгах. | | хүнийг гадаад улсад эрэн сурвалжлах.<br>1.Улсын ерөнхий прокурор өөрийн санаачилгаар, эсхүл мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллагын саналыг үндэслэн гэмт хэрэг үйлдсэн хүнийг гадаад улсад эрэн сурвалжлах шийдвэр гаргана.<br>2.Мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага прокурорын шийдвэрийн дагуу гэмт хэрэг үйлдсэн хүнийг гадаад улсад эрэн сурвалжлах ажлыг зохион байгуулж, үр дүнг прокуророос тогтоосон хугацаанд танилцуулна." гэж нэмэх. | | прокурор нь өөрийн санаачилгаар, эсхүл холбогдох байгууллагын саналыг үндэслэн гэмт хэрэг үйлдсэн хүнийг гадаад улсад эрэн сурвалжлах шийдвэр гаргана." гэж заасан.<br>Харин Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд гэмт хэрэг үйлдсэн хүнийг гадаад улсад эрэн сурвалжлах зохицуулалт байхгүй тул энэ талаар хуульд нэмж тусгах нь зүйтэй байна. |
| 14 | **Хуулийн төслийн 1 дүгээр зүйл.**<br>**7/14.13 дугаар зүйлийн 14 дэх заалт:**<br>14.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч үед энэ хуулийн 14.1 дүгээр зүйлийн 1.2, 1.3, 1.5- | "14. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч үед энэ хуулийн 14.1 дүгээр зүйлийн 1.2, 1.3, 1.5-д заасан таслан сэргийлэх | | | Шүүхийн шийдвэрийг мөрдөгч, прокурорт мэдэгдэх хугацаа болон шүүхийн шийдвэрийг хүргүүлэх хугацааг "даруй" болгож тодорхой тусгах. Мөн таслан сэргийлэх арга хэмжээний төрлөөс хамааран шүүхийн шийдвэрийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | д заасан таслан сэргийлэх арга хэмжээ авах, өөрчлөх, хүчингүй болгох, хүсэлт болон хугацааг сунгасан шүүхийн шийдвэрийг мөрдөгч, прокурорт мэдэгдэх бөгөөд шүүхийн шийдвэрийг цахим мэдээллийн сүлжээгээр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад даруй хүргүүлнэ." | арга хэмжээ авах, өөрчлөх, хүчингүй болгох, хугацаа сунгах санал, хүсэлт болон хугацаа сунгасан шүүхийн шийдвэрийг даруй мөрдөгч, прокурорт мэдэгдэж, шүүхийн шийдвэрийг цахим мэдээллийн сүлжээгээр эрх бүхий байгууллагад хүргүүлнэ." гэж өөрчлөх. | | | гадна бусад эрх бүхий байгууллагад хүргүүлэхээр байх тул "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад" гэснийг эрх бүхий байгууллагад гэж өөрчлөх нь зүйтэй байна. |
| 15 | **Хуулийн төслийн 2 дугаар зүйл.**<br>**33.1 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг:**<br>"мэдэгдэнэ" гэсний дараа "Прокурор, оролцогч ирээгүй нь шүүхийн урьдчилан хэлэлцүүлгийг хойшлуулах үндэслэл болохгүй." | | | Хасах | ЭХХШТХ-ийн 33.1 дүгээр зүйлийн 6 дахь хэсэгт заасны шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгээр мөн зүйлийн 6.1-6.17 дахь хэсэгт заасан асуудлуудыг хэлэлцэх тул талуудыг оролцуулахгүйгээр урьдчилсан хэлэлцүүлэг хийх боломжгүй.<br>Урьдчилсан хэлэлцүүлэг нь талуудын оролцоотойгоор шүүх хуралдааны бэлтгэл хангах үйл ажиллагаа юм. Иймд прокурор, оролцогчийг оролцуулан урьдчилсан хэлэлцүүлэг хийх нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилт, зарчимд нийцнэ. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 16 | **ЭХХШТХ-ийн 11.8 дугаар зүйлийн 2 дахь хэсэг**:<br>2.Шүүх хуралдаанд оролцогч, бусад оролцогч, прокурор шүүх хуралдааны тэмдэглэлийг танилцуулснаас хойш 5 хоногийн дотор засвар оруулах санал, хүсэлт гаргах эрхтэй. | | "гаргах" гэсний дараа "хуулбарлан авах" гэж нэмэх. | | Хуулийн төслийн 5.1 дүгээр зүйлийн 2.6 дахь заалтад өмгөөлөгч шүүх хуралдааны тэмдэглэл болон дуу-дүрсний бичлэгийг хуулбарлан авах эрхийг тусгасан атлаа мэтгэлцэгч нөгөө тал болох прокурорт энэ эрхийг олгохгүй, орхигдуулсан байна.<br>Хуулийн төсөлд өмгөөлөгчийн эрхтэй холбоотой зохицуулалтууд нэмж тусгахдаа шүүх хуралдааны мэтгэлцээнд тэгш эрхтэй оролцогч нэг тал болох прокурор шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад эдлэх эрх, үүргийг орхигдуулсан байгааг анхаарах шаардлагатай байна. |
| 17 | **ЭХХШТХ-ийн 11.8 дугаар зүйлийн 5 дахь хэсэг:**<br>5.Оролцогчийн хүсэлтээр шүүх хуралдааны явцыг баталгаажуулсан дууны, дуу-дүрсний бичлэгийг түүнд танилцуулна. | | "Шүүх хуралдааны явцыг баталгаажуулсан дууны, дуу-дүрсний бичлэгийг прокурор хуулбарлан авах" зохицуулалтыг нэмэх. | | |
| 18 | **ЭХХШТХ-ийн 7 дугаар бүлэг:**<br>Яллагдагч | | "7.10 дугаар зүйл. Яллагдагчийн хүүхдийг харгалзан дэмжих, эд хөрөнгийг хамгаалах<br><br>1.Мөрдөгч, прокурор, шүүх яллагдагчийн харгалзах хүнгүй үлдэж буй бага насны болон насанд хүрээгүй хүүхдийг харгалзан дэмжих, эд хөрөнгийг хамгаалах талаар дор дурдсан үүрэг хүлээнэ: | | Мөрдөн шалгах ажиллагааны явцад сэжигтэн, яллагдагчийн үйлдсэн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хор уршгаас шалтгаалж сэжигтнийг баривчлах, яллагдагчийг цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах үндэслэл бий болдог. Энэ үед тэдний бага насны хүүхэд болон бусад асруулагчид зайлшгүй хамгаалалт тогтоох, эд хөрөнгийг хамгаалах шаардлага үүсдэг.<br>Ялангуяа, бага насны хүүхэд хараа хяналтгүй үлдэх, үүнээс үүдэн хүүхдийн эрх ашигт хохирол учирч болзошгүй нөхцөл байдал бий болдог бөгөөд энэ тохиолдолд хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа байгууллага болон прокурор, шүүх |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | 1.1.Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан яллагдагчийн асрах хүнгүй бага насны болон насанд хүрээгүй хүүхэд, өндөр настай эцэг, эх болон бусад асруулагчийг харгалзан дэмжүүлэхээр төрөл садны буюу бусад хүмүүст, эсхүл зохих байгууллагад мөрдөгч, прокурор, шүүхийн шийдвэрээр шилжүүлэн өгөх;<br>1.2.Цагдан хоригдсон яллагдагчийн эд хөрөнгийг хамгаалуулах арга хэмжээ авах;<br>2.Энэ хуулийн 1 дэх хэсэгт заасан арга хэмжээ авсан талаар яллагдагчид мэдэгдэнэ." гэж нэмэх. | | тухай бүр яллагдагчийн хүүхдийг харгалзан дэмжих болон эд хөрөнгийг хамгаалах арга хэмжээг авч байх шаардлага тулгардаг. |
| 19 | **ЭХХШТХ-ийн 34.19 дүгээр зүйл.**<br>3.Энэ зүйлийн 1.1-д заасны дагуу шүүх хэрэгсэхгүй болгосон хэргийг хэрэг | "3.Энэ зүйлийн 1.1, 1.9-д заасны дагуу шүүх хэрэгсэхгүй | | | Хуулийн төслийн 34.19 дүгээр зүйлийн 1.9 дэх заалтад "нэмэлт нотлох баримтыг цуглуулах бүхий ажиллагааг хийсэн боловч шүүгдэгч гэмт хэрэг үйлдсэн болох нь |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | бүртгэлтэд буцаана. | болгосон хэргийг хэрэг бүртгэлтэд буцааж болно.” гэж өөрчлөх. | | | нотлогдоогүй.” гэсэн нэмэлт өөрчлөлттэй холбогдуулан энэхүү өөрчлөлтийг төсөлд нэмж тусгах шаардлагатай.<br>Гэмт хэрэг үйлдэгдсэн боловч тухайн хүн үйлдсэн болох нь нотлогдоогүй бол түүнд холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгох нь зүйн хэрэг боловч энэ нь үйлдэгдсэн гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдал биш юм.<br>Энэ нь тухайн гэмт хэргийг үйлдсэн этгээдэд ял завших боломж олгож, хохирогчийн зөрчигдсөн эрхийг сэргээх боломжгүй байдалд хүргэх эрсдэлтэй.<br>Мөн гэмт хэргийн шинжгүй болон нэмэлт нотлох баримтыг цуглуулсан боловч гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдоогүй үндэслэлээр шүүгдэгчид холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгосон боловч нэмэлт хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулах боломжгүй, шаардлагагүй тохиолдлууд үүснэ. Иймд “буцааж болно” гэх байдлаар өөрчлөх нь зүйтэй юм. |
| 20 | **ЭХХШТХ-ийн 1.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:**<br>1.3.яллагдагч, шүүгдэгч нас барсан; | “1.3.яллагдагчаар татагдвал зохих этгээд, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч нас барсан” гэж өөрчлөх. | | | Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг шалгах, мөн хэрэг бүртгэлтийн хэрэгт мөрдөн шалгах ажиллагаагаар яллагдагчаар татагдвал зохих этгээд нь тодорхой боловч нас барсан бол түүнд холбогдуулан эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тухай шийдвэр гаргах боломжгүй, эсхүл прокуророос эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | | татах тухай шийдвэр гарч, дуудагдсан сэжигтэн нас барсан тохиолдолд холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгох үндэслэл байхгүй тул хуулийг төсөөтэй хэрэглэн ЭХХШТХ-ийн 1.5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.3-ийг баримталж шийдвэрлэж байна.<br>Иймд хуулийг нэг мөр хэрэгжүүлэх үүднээс уг хийдлийг засах шаардлагатай. |
| 21 | **ЭХХШТХ-ийн 1.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:**<br>1.4.тухайн хэргийг урьд нь хэрэгсэхгүй болгосон тогтоол, магадлал хүчинтэй байгаа; | “1.4.тухайн гомдол, хэргийг шийдвэрлэсэн прокурор, шүүхийн шийдвэр хүчинтэй байгаа” гэж өөрчлөх. | | | Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд “хэргийг”, “хэрэгсэхгүй болгосон тогтоол” гэж заасан нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан “...нэг нэр томьёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх, хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих” шаардлагад нийцэхгүй байна.<br>Учир нь гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авахаас татгалзах, хэрэг бүртгэлтийн хэргийг хаах зэрэг шийдвэрүүд хүчин төгөлдөр байгаа буюу эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж болохгүй тохиолдолд хамаарах нөхцөл байдал тогтоогдсон боловч тус үндэслэлээр гомдол, хэргийг шийдвэрлэх боломжгүй, энэ тохиолдолд ЭХХШТХ-ийн 1.5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.4-ийг төсөөтэй хэрэглэж байна.<br>Иймд тухайлсан нэр томьёогоор бус өргөн агуулга, еренхий нэр томьёогоор, эсхүл шийдвэр тус бүрийг нэг бүрчлэн тоочин бичих |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | | шаардлагатай. |
| 22 | **ЭХХШТХ-ийн 3.1 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг:** Шүүх энэ хуулийн 14.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.3, 1.5 дахь заалт, 31.5 дугаар зүйлд заасан асуудлыг хянан шийдвэрлэх ажиллагааг хуанлийн өдөр бүр шөнийн цагаас бусад цагт тасралтгүй хэрэгжүүлнэ. | 5."1.5 дахь заалт гэсний дараа 31.4" гэж нэмэх. | | | ЭХХШТХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар тус зүйл хэсгийг орхигдуулсан байх тул нэмэлт оруулах шаардлагатай.<br>Ингэснээр хүнийг баривчлах, цагдан хорих асуудлыг шүүхийн зөвшөөрлийн үндсэн дээр явуулдаг байх тухай хуулийн төслийн үзэл баримтлал, олон улсын байгууллагын дүгнэлт, зөвлөмжид нийцнэ. |
| 23 | **ЭХХШТХ-ийн 30.14 дүгээр зүйл**.<br>Хэрэг бүртгэлтийн хэргийг хаах | | "Хэрэг бүртгэлтийн хэргийг хаах саналтай прокурорт шилжүүлсэн хэргийн материалыг прокурор 14 хоногийн дотор хянах ба зайлшгүй тохиолдолд зохих дээд шатны прокурор энэ хугацааг тухай бүр 14 хүртэл хоногоор сунгаж болно" гэсэн заалт шинээр нэмэх. | | ЭХХШТХ-ийн 30.14 дүгээр зүйлд хэрэг бүртгэлтийн хэргийг хаах саналтай шилжүүлсэн тохиолдолд прокуророос хянах, шийдвэрлэх хугацааг тодорхой заагаагүй тул хэргийг хянах хугацааг хуульд тусгах шаардлагатай. Мөн түүнчлэн олон хавтастай, олон хохирогчтой, ээдрээ төвөгтэй хэргийг хянах хугацааг сунгаж болох зохицуулалтыг нэмж тусгах шаардлагатай байна. |
| 24 | **ЭХХШТХ-ийн 30 дугаар бүлэгт** | | **"30.18.Хэрэг бүртгэлтийг түдгэлзүүлэх, сэргээх**<br>1.Мөрдөгч хэрэг бүртгэлтийн хэрэгт гэмт хэрэг үйлдсэн хүнийг олж илрүүлэх бүхий л арга | | ЭХХШТХ-ийн 30.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Хэрэг бүртгэлтийн үндсэн хугацаа нь хэрэг бүртгэлтийн хэрэг нээснээс хойш 1 сар байна.", 3 дахь хэсэгт "Хэрэг бүртгэлтийн хугацааг прокурор тухай бүр 3 сар хүртэл хугацаагаар сунгаж болно." гэж заасны дагуу гэмт хэрэг үйлдсэн хүн тогтоогдоогүй хэрэгт хэрэг |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | хэмжээг авах үүрэгтэй. 2.Хэрэг бүртгэлтийн хэрэгт хийгдвэл зохих ажиллагааг хийж шалгасан боловч 6 сарын хугацаанд яллагдагчаар татагдвал зохих этгээд нь тогтоогдоогүй бол мөрдөгч хэрэг бүртгэлтийн хэргийг түдгэлзүүлэх тухай саналыг прокурорт гаргана.<br>3.Прокурор энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан үндэслэл тогтоогдвол хэрэг бүртгэлтийг түдгэлзүүлнэ.<br>4.Хэрэг бүртгэлтийг түдгэлзүүлэх тухай тогтоолд дараах зүйлийг тусгана:<br>4.1.прокурорын нэр, албан тушаал;<br>4.2.түдгэлзүүлсэн он, сар, өдөр;<br>4.3.хэргийн дугаар, хэргийн утга;<br>4.4.хэрэг бүртгэлтийг түдгэлзүүлэх үндэслэл; | | бүртгэлтийн хугацааг ихэвчлэн тухай бүр 1 сараар сунган, мөрдөн шалгах ажиллагаа явуулж байна.<br>Гэмт хэрэг үйлдсэн хүнийг эрэн сурвалжлахын тулд мөрдөгч харьяаллын бус мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллагад даалгавар бичих, байгаа газар нь мэдэгдэхгүй байгаа сэжигтнийг эрэн сурвалжлуулах ажиллагааг прокурорын даалгавраар явуулж, эрх бүхий байгууллага прокурорын шийдвэрийн дагуу эрэн сурвалжлах ажлыг зохион байгуулан, үр дүнг прокуророос тогтоосон хугацаанд танилцуулан ажиллаж байна.<br>Улсын хэмжээнд 2024 оны III улирлын байдлаар хэрэг бүртгэлтийн нийт 62,309 хэрэг шалгагдсаны 33,178 буюу 53.2 хувь нь 2024 онд шинээр нээсэн, 29,131 буюу 46.8 хувь нь өмнөх онуудад хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн хэргүүд байна.<br>Хэрэг бүртгэлтийн ажиллагаанд 41,547 хэрэг шалгагдаж байгаагийн 2,846 буюу 6.8 хувь нь гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээд тодорхой, 11,342 буюу 27.2 хувь нь гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээдийг илрүүлэх боломжтой, 27,359 буюу 65.8 хувь нь гэмт хэрэг үйлдсэн хүн нь тодорхойгүй хэргүүд байна.<br>Мөрдөгч нарын ажлын ачаалал өндөр байгаа нь мөрдөн шалгах ажиллагаа явуулж буй хэрэг нэг бүрд хүрч ажиллах боломжгүй байдалд хүргэж байна. Нөгөөтэйгөөр, гэмт хэрэг |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | 5.Мөрдөгч түдгэлзүүлсэн хэрэгт гэмт хэрэг үйлдсэн хүнийг олж тогтоохоор явуулсан эрэн сурвалжлах ажиллагааны үр дүнг прокуророос тогтоосон хугацаанд танилцуулна.<br>6.Энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан нөхцөл арилсан, эсхүл нэмэлт мөрдөн шалгах ажиллагаа явуулах шаардлагатай бол хэрэг бүртгэлтийг сэргээх тухай прокурор тогтоол гаргана.<br>7.Хэрэг бүртгэлтийг сэргээх тухай тогтоолд дараахь зүйлийг тусгана:<br>7.1.хэрэг бүртгэлтийг сэргээсэн прокурорын нэр, албан тушаал;<br>7.2.хэрэг бүртгэлтийг сэргээсэн үндэслэл;<br>7.3.хэрэг бүртгэлтийн хугацааг сунгуулахыг даалгах" гэж нэмэх. | | үйлдсэн этгээд хэн болох нь тодорхойгүй хэрэгт хэрэг бүртгэлтийн хугацааг ач холбогдолгүй сунгах, хэрэг нэг бүрд ажиллагаа хийсэн байх шаардлагыг хангахын тулд гэрч, хохирогчийг нэг асуудлаар удаа дараа дуудаж мэдүүлэг авч чирэгдэл учруулах зэргээр мөрдөн шалгах ажиллагааг үр дүн муутай явуулж байгаа нь эргээд ажлын бүтээмж, чанар үр нөлөөнд сөргөөр нөлөөлж байна. Үүнээс шалтгаалан бусад эзэнтэй хэрэг нэг бүрд хүрч ажиллаж чадахгүй, мөрдөгч нар хэт их ажлын ачааллаас хамаарч ажлаас халшрах хам шинжид өртөж байгаа асуудал ихээр яригдаж байна.<br>Иймд гэмт хэрэг үйлдсэн этгээд хэн болох нь тодорхойгүй хэрэг бүртгэлтийн хэргийн хугацааг сунган шалгаад, гэмт хэрэг үйлдсэн хүн нь тогтоогдоогүй тохиолдолд хэрэг бүртгэлтийг түдгэлзүүлдэг байх. Прокурор хэргийг түдгэлзүүлэх шийдвэр гаргахдаа эрэн сурвалжлах тогтоол үйлдэж, тогтоосон хугацаанд биелэлт, үр дүнг тооцдог байх. Эрэн сурвалжлах ажиллагаагаар сэжигтнийг тогтоосны үндсэн дээр хэргийг сэргээж, шалгадаг зохицуулалтыг тусгах нь мөрдөгч, прокурорын ажлын бүтээмжид эерэг нөлөө үзүүлэхээр байна. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 25 | **ЭХХШТХ-ийн 14.10 дугаар зүйлийн 5 дахь хэсэг:** 5.Баривчлагдсан хугацааг цагдан хорих хугацаанд оруулж тооцно. Баривчлагдсан 24 цаг хүртэл хугацааг цагдан хоригдсон 1 хоногоор тооцно. | “5.Баривчлагдсан хугацааг цагдан хорих хугацаанд оруулан тооцох ба энэ зүйлийн 1-д заасан цагдан хорих үндсэн хугацаанаас хасаж тооцно.<br>Баривчлагдсан 24 цаг хүртэл хугацааг цагдан хоригдсон 1 хоногоор тооцно” гэж өөрчлөн найруулах. | | | ЭХХШТХ-д баривчлагдсан хугацааг цагдан хорих хугацаанд оруулан тооцох талаар заасан боловч яллагдагчаар цагдан хорих эсэх асуудлыг шийдвэрлэхдээ, эсхүл шүүгдэгчид ял оногдуулахдаа тус хугацааг цагдан хоригдсон нийт хугацаанд оруулан тооцох эсэх нь тодорхой бус байдгаас хууль нэг мөр хэрэгжихгүй байна.<br>Тухайлбал, яллагдагчид цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах тухай шүүгчийн захирамжид яллагдагчийг “...-ээс эхлэн 1 сарын хугацаагаар” гэж, эсхүл “2024.08.05-ны өдрөөс эхлэн 2024.09.05 хүртэл 1 сарын хугацаагаар” гэж цагдан хорих хугацааг тогтоож, мөн шүүгчийн захирамжийн тогтоох хэсэгт “баривчлагдсан хугацааг цагдан хорих хугацаанд оруулан тооцсугай” гэж тусад нь заалт болгон бичдэг. Өөрөөр хэлбэл, цагдан хоригдсон хугацааг 1 сараар, улмаар тус хугацааг сунгах захирамжид цагдан хорих хугацааны сүүлийн хоногоос тооцон дуусах хугацааг тус тус зааж бичиж байгаагаас ЭХХШТХ-ийн 14.10 дугаар зүйлд заасан цагдан хорих нийт хугацааг сэжигтнээр баривчлагдсан хугацаагаар хэтрүүлэн яллагдагчийн эрхийг зөрчиж болзошгүй байдал үүсэж |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | | хэтрүүлэн яллагдагчийн эрхийг зөрчиж болзошгүй байдал үүсэж байна. Иймд сэжигтнээр баривчлагдсан хүнийг үргэлжлүүлэн яллагдагчаар цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах тухай саналыг шүүх шийдвэрлэхдээ баривчлагдсан хугацааг оруулан тооцох талаар тусгахаас гадна, сэжигтний баривчлагдсан хугацааг тухайн захирамжаар тогтоох хугацаанаас хасаж тооцон хугацаа дуусах сүүлчийн өдрийг захирамжид заах шаардлагатай байна. |
| 26 | **ЭХХШТХ-ийн 30.15 дугаар зүйлд 3 дахь заалт нэмэх** | | “3.Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан шийдвэр гаргах хугацааг зайлшгүй тохиолдолд дээд шатны прокурор 14 хүртэл хоногоор нэмж сунгаж болно.” гэж нэмэх. | | Практикт олон холбогдогчтой, олон үйлдэлтэй, олон хавтастай хэргийг ажлын 3 хоногийн дотор бүрэн хянаж, шийдвэр гаргахад хүндрэл учирдаг.<br>Энэхүү зохицуулалтыг нэмснээр мөрдөгчийн саналын дагуу прокурор хэргийг бүрэн хянаж, хууль зүйн үндэслэлтэй шийдвэр гаргах нөхцөлийг бүрдүүлнэ. |
| 27 | **ЭХХШТХ-ийн 8.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:**<br>1.8.хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан, мөрдөн байцаалт дууссан бол хавтаст хэргээс өөрт хамааралтай хэсэгтэй танилцах, нэмэлт ажиллагаа хийлгэх тухай | “1.8.хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан, мөрдөн байцаалт дууссан бол хавтаст хэргээс өөрт хамааралтай хэсэгтэй биечлэн, эсхүл цахимаар танилцаж, төр, | | | ЭХХШТХ-ийн 8.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.8-д хохирогч нь хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан, мөрдөн байцаалт дууссан хэрэгтэй танилцаж, нэмэлт ажиллагаа хийлгэх хүсэлт гаргах эрхийг хуульчилсан.<br>Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд талууд тэгш эрхтэй оролцох зарчимтай.<br>Хуулийн төсөлд яллагдагч хавтаст хэрэгтэй биечлэн болон цахимаар |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | хүсэлт гаргах; | байгууллага, хувь хүний нууцад хамаарахаас бусад нотлох баримтыг хуулбарлаж, хувилж авах эрхтэй;" гэж өөрчлөн найруулах. | | | танилцах, нотлох баримт хуулбарлан авах болон бусад эрхийг хангах зохицуулалтууд тусгагдсан байна. Иймд хохирогч цахимаар хэргийн материал танилцах, нотлох баримт хуулбарлан авах эрхийг тусгах нь зүйтэй байна. |
| 28 | **ЭХХШТХ-ийн 15.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:**<br>1.Прокурор, оролцогч энэ хуулийн 12.3, 13.1, 13.2, 13.5, 13.7, 14.4, 14.5, 14.13, 19.2, 19.3 дугаар зүйл, 21.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 21.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан шүүхийн шийдвэрийг эс зөвшөөрвөл 3 хоногийн дотор гомдол гаргаж болно. | | "1.эс зөвшөөрвөл гэсний дараа ажлын" гэж нэмэх. | | Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд заасан олон хоногоор амрах баярын өдрүүдтэй давхцах тохиолдолд гомдол гаргах хугацаа хэтэрч болзошгүй тул "ажлын" өдрөөр тооцох шаардлагатай. |
| 29 | **ЭХХШТХ-ийн 34.18 дугаар зүйл**:<br>Хэргийг тусгаарлаж хэлэлцэх | | Хэргийг тусгаарлах процессыг нэмж тусгах. | | Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.18 дугаар зүйлд хэргийг тусгаарлах тохиолдлыг тусгасан атлаа тусгаарлах процессыг хуульчлаагүй байна. Үүнээс шалтгаалан хэргийн дугаарыг хэрхэн олгох, хэргийг прокурорт хүргүүлэх эсэх, давж заалдах болон хяналтын шатны шүүхээс зарим шүүгдэгчид холбогдох заалтыг хүчингүй болгосон тохиолдолд анхан шатны шүүх ямар ажиллагаа хийх зэргийг тодорхой болгох нь зүйтэй байна. |
| 30 | **ЭХХШТХ-ийн 39.9 дугээр** | | 39.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт: | | 2022 оны 06 дугаар сарын 03-ны өдөр ЭХХШТХ-д орсон нэмэлт, |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | **зүйл**. Давж заалдах шатны шүүхийн шийдвэр<br><br>**ЭХХШТХ-ийн 40.8 дугаар зүйл**. Хяналтын шатны шүүхийн шийдвэр | | "анхан шатны шүүхийн шийдвэрийг бүхэлд нь хүчингүй болгож, гэм буруугийн шүүх хуралдаанаар дахин хэлэлцүүлэх"<br>40.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт:<br>"анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, гэм буруугийн шүүх хуралдаанаар дахин хэлэлцүүлэх" гэж тус тус нэмэх. | | өөрчлөлтийн үзэл баримтлалд нийцүүлэн хэргийг прокурорт буцаахгүйгээр, мөн хуулийн 34.16 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт зааснаар шүүх хуралдааныг 60 хүртэл хоногоор хойшлуулж, нэмэлт ажиллагаа хийхийг прокурорт даалгах нь зүйтэй. Давж заалдах болон хяналтын шатны шүүхээс анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгосон тохиолдолд хэргийг хэрхэх нь тодорхойгүй, урьдчилсан хэлэлцүүлэг, эсхүл прокурорт буцааж болохгүй, хориглосон хэм хэмжээг зөрчихөд хүргэж байна. Шүүхийн практикт давах, хяналтын шатны шүүх шийдвэрийг хүчингүй болгохдоо шийдвэрийнхээ тодорхойлох хэсэгт тусгасан хэлбэрээр шүүх өөрсдөө шийдэх, эсхүл шууд урьдчилсан хэлэлцүүлэг зарлан прокурорт буцааж байна. Өөрөөр хэлбэл, давж заалдах болон хяналтын шатны шүүхээс анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгохоор шийдвэрийнхээ тогтоох хэсэгт бичиж байгаа боловч анхан шатны шүүх хэргийг хүлээн аваад шууд урьдчилсан хэлэлцүүлэг хийснээр ЭХХШТХ-ийн 33.1 дүгээр зүйлийн 12 дахь заалтыг зөрчих, эсхүл албан бичгээр хэргийг прокурорт буцаах тохиолдол гарч байна. |
| 31 | **ЭХХШТХ-ийн 25.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:**<br>2.Арван найман насанд хүрээгүй гэрчээс мэдүүлэг | | "2.сурган хүмүүжүүлэгчийг гэсний дараа "шаардлагатай бол | | ЭХХШТХ-ийн 35.15 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт шүүх хуралдаанд арван найман насанд хүрээгүй гэрчийн мэдүүлгийг сонсохдоо сэтгэл зүйчийг |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | авахад түүний хууль ёсны төлөөлөгч, эсхүл төрөл, садангийн хүн, сурган хүмүүжүүлэгчийг оролцуулах бөгөөд тэдэнд эрх, үүргийг нь тайлбарлан өгч, энэ тухай тэмдэглэлд тусгана. | | сэтгэл зүйчийг...” гэж нэмэх. | | оролцуулж болохоор хуульчилсан. Мөрдөн шалгах ажиллагааны явцад арван найман насанд хүрээгүй хүнээс мэдүүлэг авахдаа шаардлагатай тохиолдолд сэтгэл зүйч оролцуулах нь зүйтэй байна. |
| 32 | **ЭХХШТХ-ийн 12.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг:**<br>2.Мөрдөгч нь гэрч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, шинжээч, яллагдагчаас мэдүүлэг авах, шийдвэр танилцуулах, мөрдөн шалгах ажиллагаанд оролцуулах зайлшгүй шаардлагатай бол прокурорын мэдэгдэх хуудсаар дуудан ирүүлнэ.<br>**ЭХХШТХ-ийн 12.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:**<br>3.Гэрч, хохирогч, иргэний хариуцагч, шинжээч, яллагдагч, шүүгдэгч мэдэгдэх хуудсыг хүлээн авахаас зайлсхийсэн бол түүний өмгөөлөгч, эсхүл гэр бүлийн арван найман насанд хүрсэн гишүүнд хүргүүлнэ. | | ”шинжээч” гэсний дараа “сэжигтэн” гэж тус тус нэмэх. | | ЭХХШТХ-ийн 31.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Тогтоол танилцуулахаар сэжигтнийг дуудан ирүүлэхдээ 12.1 дүгээр зүйлд заасан журмыг баримтална.” гэж заасан.<br>Мөн хуулийн 12.1 дүгээр зүйлийн 2, 12.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт сэжигтнийг прокурорын мэдэгдэх хуудсаар дуудан ирүүлэх болон мэдэгдэх хуудсыг хүлээн авахаас зайлсхийсэн бол хэрхэх талаар тусгаагүй байна. |

---oOo---

МОНГОЛ УЛС
**АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР**

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41, Утас: 7011 0251, Факс: (976) 7011 0251
И-мэйл: comcor@iaac.mn, Вэб сайт: http://iaac.mn

2024.10.30 № 03/17554
танай 2024.10.17 -ны № 1/1332. -т

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН,
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД
О.АЛТАНГЭРЭЛ ТАНАА

Таны 2024 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 1/1332 дугаартай албан бичгээр ирүүлсэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй танилцан, төсөлд тусгуулах саналыг хавсралтаар хүргүүлэв.

Хүлээн авч, танилцана уу.

Хавсралт .2... хуудастай.

Хүндэтгэсэн,

ТАМГЫН ХЭЛТСИЙН ДАРГА,
ЭРХЭЛСЭН КОМИССАР З.БААСАННЯМ

УХА0422 5120829

14240300 2984

Авлигатай тэмцэх газрын
2024 оны 10 дугаар сарын 30-ны
өдрийн 03/1754 дугаартай албан
бичгийн хавсралт

## ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ТУСГУУЛАХ САНАЛ

1 дүгээр зүйл.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, зүйл, заалт нэмсүгэй:

"5.Мөрдөн байцаалт дууссан бол хэргийн бүх материалтай биечлэн, эсхүл цахимаар танилцаж, ~~төр, байгууллага, хувь хүний нууцад~~ хамаарахаас бусад нотлох баримтыг хуулбарлаж, хувилж авах эрхтэй."

5/12.1 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг:

"Э.Мөрдөгч нь хэргийн оролцогчийн хүсэлтээр төрийн байгууллага, албан тушаалтны албаны цахим шуудан, албан бичиг солилцооны дундын систем, мэдэгдэл хүргэх систем, мөн иргэний төрийн үйлчилгээний нэгдсэн систем, мэдэгдэл хүргэх системд иргэний үүсгэсэн, бүртгүүлсэн цахим шуудан, тухайн этгээдийг таньж, баталгаажуулах боломжтой бусад цахим системд бүртгүүлэн холбогдсон хаягийг ~~ашиглаж дуудаж~~, прокурорын мэдэгдэх хуудсыг хүргүүлж болно."

8/14.13 дугаар зүйлийн 14 дэх хэсэг:

14.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч үед энэ хуулийн 14.1 дүгээр зүйлийн 1.2, 1.3, 1.5-д заасан таслан сэргийлэх арга хэмжээ авах, өөрчлөх, хүчингүй болгох, хүсэлт болон хугацааг сунгасан шүүхийн шийдвэрийг мөрдөгч, прокурорт мэдэгдэх бөгөөд шүүхийн шийдвэрийг цахим мэдээллийн сүлжээгээр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад даруй хүргүүлнэ."

10/16.3 дугаар зүйлийн 10-11 дэх хэсэг:

"10.Гэрчээр мэдүүлэг авч байх үед гэмт хэрэгт сэжиглэх үндэслэл илэрвэл мэдүүлэг авах ажиллагааг зогсоож, сэжигтнээр мэдүүлэг авах ажиллагааг энэ хуульд заасны дагуу явуулна.

11. Дүрс харж ярих боломжтой технологи, ~~мэдээллийн хэрэгсэл~~ ашиглан мэдүүлгийг авч болно. Энэ тохиолдолд өмгөөлөгч, хууль ёсны төлөөлөгч, асран хамгаалагчийн оролцоог ханган дуу-дүрсний бичлэгээр бэхжүүлж, хавтаст хэрэгт хавсаргана."

11/16.14 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг:

"5.Мөрдөн шалгах ажиллагааны явцад гэрч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, шинжээч, сэжигтэн, яллагдагчаас мэдүүлэг авахад бэхжүүлсэн дууны, дүрсний, дуу-дүрсний ~~бичлэгийн хувийг хавтаст хэргийн хамт~~ хадгална."

14/ 32.9 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг:

~~"3.Яллагдагчаар татах тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулж, яллагдагчаар татах тогтоолд оруулсан өөрчлөлтийг яллагдагчид танилцуулж, хувийг гардуулна."~~

2 дугаар зүйл.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн дараах зүйл, хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

2/7.5 дугаар зүйлийн 4 дэх хэсэг:

"4.Яллагдагч шинжээч томилсон тогтоол, шинжээчийн дүгнэлттэй танилцах,

**Commented [OP1]:** Төрийн болон албаны нууцын тухай хууль, Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль батлагдан мөрдөгдөж байгаа тул нэр томьёог нэг мөр болгох шаардлагаар "төрийн болон албаны нууц, байгууллагын нууц, хувь хүний эмзэг мэдээлэлд" гэж өөрчлөх;

**Commented [OP2]:** Хууль тогтоомжийн тухай хуулийн 30.1.3-т заасныг баримтлан "ашиглан дуудаж" гэж өөрчлөх

**Commented [OP3]:** "сүлжээг ашиглан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад болон холбогдох төрийн байгууллага, хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтанд" гэж өөрчлөх;

**Commented [OP4]:** "31.2 дугаар зүйл.Эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоол үйлдсэний дараа хийгдэх ажиллагаа
1.Энэ хуульд заасны дагуу баривчлагдсан, эсхүл яллагдагчаар татах тогтоолтой танилцуулахаар мэдэгдэх хуудсаар дуудагдсан хүнийг сэжигтэн гэнэ." гэж заасан.
16.3 дугаар зүйлийн 10-т ийнхүү өөрчлөлт оруулахаар бол дээр дурьдсан 31.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зохих өөрчлөлт оруулах шаардлагатай болно. Тухайлбал,
"31.2 дугаар зүйл.Эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоол үйлдсэний дараа хийгдэх ажиллагаа
"1. Энэ хуульд заасны дагуу баривчлагдсан, эсхүл яллагдагчаар татах тогтоолтой танилцуулахаар мэдэгдэх хуудсаар дуудагдсан, эсхүл энэ хуулийн 16.3.10 дахь хэсэгт заасан үндэслэлээр сэжигтнээр мэдүүлэг өгөх хүнийг сэжигтэн гэнэ." гэж өөрчлөн найруулах;

**Commented [OP5]:** Олон түмнийг нийтлэл, нэвтрүүлгийн тусламжтайгаар үнэн бодитой мэдээллээр шуурхай, тогтмол хангах зорилго бүхий тогтмол хэвлэл, радио, телевиз, мэдээллийн агентлаг, баримтат кино, цахим хэвлэл зэрэг мэдээллийн сувгийг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл гэж нэрлэдэг.
Иймд "мэдээллийн хэрэгсэл" гэснийг "цахим харилцаа холбооны хэрэгсэл" гэж өөрчлөх;

**Commented [OP6]:** Мэдүүлэг бүрийн бичлэгийг хэрэгт хадгалах боломжгүй тул "...бичлэгийн хувийг хавтаст хэргийн хамт хадгална." гэснийг "бичлэгийн хувийг хэргийг шийдвэрлэх хугацаанд мөрдөх байгууллагад хадгална" гэж өөрчлөх.

**Commented [OP7]:** Хасах

мөрдөн байцаалт дууссаны дараа хавтаст хэргийн материалтай танилцаж, ~~төр, байгууллага, хувь хүний нууцад~~ хамаарахаас бусад нотлох баримтыг дууны, дүрсний болон бусад техник хэрэгсэл ашиглан өөрийн зардлаар хуулбарлаж, хувилж авах эрхтэй."

3/14.13 дугаар зүйлийн 5 дахь хэсэг:

"5.~~Прокурор, яллагдагч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн гаргасан санал, хүсэлтийн үндэслэлд хамаарах баримт, мэдээллийг шүүх хэргийн оролцогчид танилцуулж, тэдгээрт тайлбар хийх, холбогдох баримт, мэдээллийг гаргаж өгөх боломжоор хангана.~~ Талуудад танилцуулагдаагүй баримт, мэдээлэл нь шүүхийн шийдвэрийн үндэслэл болохгүй."

4/31.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

"1.~~Мөрдөгч эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолыг прокуророос хүлээн авсан даруй дуудан ирүүлсэн сэжигтэнд танилцуулж, хувийг гардуулан өгнө. Төрийн нууцад хамаарах хэргийн яллагдагчаар татах тогтоолыг яллагдагч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчид гардуулахгүйгээр танилцуулна."~~

5/32.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг:

~~"3.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан оролцогч хэргийн материалтай 14 хүртэл хоногийн хугацаанд танилцах ба мөрдөгч хэргийн материалтай танилцах боломж, нөхцөлийг бүрдүүлнэ. Хавтаст хэргийн тоо, хэргийн оролцогчдын тооноос хамааран хэргийн материалтай танилцах хугацааг мөрдөгч 14 хүртэл хоногоор сунгаж болно."~~

7/ 32.10 дугаар зүйлийн 6 дахь хэсэг:

"6.Прокурор хэргийг шүүхэд шилжүүлэхээс ажлын 3-аас доошгүй хоногийн өмнө яллах дүгнэлтийг яллагдагчид гардуулж, энэ талаар түүний хууль ёсны төлөөлөгч, хохирогч, өмгөөлөгчид мэдэгдэнэ."

3 дугээр зүйл.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай ~~32.1 дүгээр зүйлийн 9 дэх хэсгийн "тухайн ажиллагаанд холбогдох оролцогчид танилцуулна." гэснийг "энэ зүйлд заасан журмын дагуу оролцогчид танилцуулна." гэж, ....өөрчилсүгэй.~~

**Хоёр**. Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31.14 дүгээр зүйл (Мөрдөн байцаалтыг түдгэлзүүлэх, сэргээх)-д дараах агуулга бүхий 1.5 дахь заалт нэмэх;

"1.5 Шаардлагатай гэрч, хохирогч, сэжигтэн, яллагдагч Монгол улсын хилээр гарсан нь эрх бүхий байгууллагын лавлагаа, мэдээллээр тогтоогдсон бол."

**Гурав.** Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн "6.2 дугаар зүйл (Мөрдөгч)-ийн 2 дахь хэсэг (Мөрдөгч дараахь эрхтэй)-ийн "2.11 прокурорын даалгавраар мөрдөн шалгах ажиллагаа явуулах, даалгаврыг эс зөвшөөрвөл хүлээн авснаас хойш ажлын 3 өдрийн дотор саналаа бичгээр тухайн прокурорын газрын дээд шатны прокурорт нэг удаа гаргах; */Энэ заалтад 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./*" гэснийг дараах байдлаар өөрчлөн найруулах:

"2.11 прокурорын даалгавраар мөрдөн шалгах ажиллагаа явуулах, даалгаврыг эс зөвшөөрвөл хүлээн авснаас хойш ажлын 3 өдрийн дотор тухайн прокурорын газрын дээд шатны прокурорт, тухайн прокурорын газрын дээд шатны прокурорын шийдвэрийг эс зөвшөөрвөл дээ шатны прокурорт саналаа тус тус бичгээр нэг удаа гаргах;"

---000---

**Commented [OP8]:** Төрийн болон албаны нууцын тухай хууль, Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль батлагдан мөрдөгдөж байгаа тул нэр томьёог нэг мөр болгох шаардлагаар "төрийн болон албаны нууц, байгууллаганы нууц, хувь хүний эмзэг мэдээлэлд" гэж өөрчлөх;

**Commented [OP9]:** Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн 14.13 дугаар зүйлийн "5. Прокурор, яллагдагч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч гаргасан санал, хүсэлтийнхээ хууль зүйн үндэслэл, түүний нотлох баримтыг шүүх, шүүхийн хэлэлцүүлэгт оролцогчид танилцуулна." гэснийг хэвээр үлдээж өөрчлөлт оруулах саналын нэг дэх өгүүлбэрийг хасах;

**Commented [OP10]:** Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн
"31 3 дугаар зүйл Эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоол танилцуулах
1 Мөрдөгч эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолыг прокуророос хүлээн авсан даруй дуудан ирүүлсэн сэжигтэнд танилцуулна " гэснийг хэвээр үлдээх,

**Commented [OP11]:** Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн
"32.1 дүгээр зүйл.Хавтаст хэргийн материал танилцуулах
3.Хэргийн материалтай энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан оролцогч мөрдөгчөөс тогтоосон хугацаанд танилцах ба мөрдөгч хэргийн материалтай танилцах боломж, нөхцөлийг бүрдүүлнэ." гэснийг хэвээр үлдээх;

**Commented [OP12]:** "өдрийн" гэж өөрчлөх

**Commented [OP13]:**
Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн
"32.1 дүгээр зүйл.Хавтаст хэргийн материал танилцуулах
9.Нэмэлт мөрдөн байцаалт явуулсан бол нэмж хийсэн ажиллагааны материалыг тухайн ажиллагаанд холбогдох оролцогчид танилцуулна." гэснийг хэвээр үлдээх;

МОНГОЛЫН ӨМГӨӨЛӨГЧДИЙН
ХОЛБОО

16050 Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 2 дугаар хороо,
Энхтайваны өргөн чөлөө 46, Гранд Плаза 15 давхар,
РД: 1626124, Утас/Факс: (+976) 7012-6861,
И-мэйл: holboo@ama.org.mn, Вэбсайт: www.ama.org.mn

2024.11.27 № 01/1225

танай 2024.10.17-ны № 1/1332 -т

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД
О.АЛТАНГЭРЭЛ ТАНАА

Монголын Өмгөөлөгчдийн Холбоонд санал авахаар ирүүлсэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбоотой саналыг нэгтгэн хүргүүлж байна.

Хавсралт 16. хуудастай.

ЕРӨНХИЙЛӨГЧ Л.ДАНЗАННОРОВ

Монголын Өмгөөлөгчдийн Холбооны
01/224 дугаартай албан бичгийн хавсралт

# МОНГОЛЫН ӨМГӨӨЛӨГЧДИЙН ХОЛБООНООС ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ТУСГУУЛАХААР ХҮРГҮҮЛЖ БУЙ САНАЛ

| | Санал | Үндэслэл<br>(тайлбар, статистик тоон мэдээлэл, холбогдох судалгаа байгаа бол хавсаргах) | Хуулийн төслийн томьёолол |
|---|---|---|---|
| **Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг зүйл заалтыг нэмсүгэй** | | | |
| 1 | 5.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн **“хохирогч,”** гэсний дараа **“гэрч,”** гэж нэмэх | Хүнийг гэмт хэрэгт сэжиглэх үндэслэл байгаа бол түүнийг гэрчээр дуудах, эсхүл түүнээс гэрчийн мэдүүлэг авахгүй байх, гэрчийн мэдүүлэг авах үед түүнийг гэмт хэрэгт сэжиглэх үндэслэл илэрсэн бол гэрчийн мэдүүлэг авахыг даруй зогсоох зохицуулалтыг тусгах<br>Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2020 оны 11 сарын 4-ний өдрийн “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 9.6 дугаар зүйлийн зарим зүйл хэсэг Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай” 10 дугаартай дүгнэлтийн 3-т “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажсан хүний эрхийг үндэслэлгүй хязгаарласан шинжгүй, хууль зүйн процессын суурь зарчмуудад нийцсэн байх ёстой. Энэ утгаараа хуульд гэмт хэрэгт сэрдэгдэж байгаа этгээдийн эрх зүйн байдлыг дээрх хуулиар | **5.1 дүгээр зүйл.Өмгөөлөгчийн эрх, үүрэг**<br>1.Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан, хохирогч, **гэрч,** иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, хууль зүйн туслалцаа авах эрхээр хангах зорилгоор эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгчийг оролцуулна. |
| 2 | 9.6 дугаар зүйлд 9 дэх хэсэг нэмэх | | **9.6 дугаар зүйл. Гэрч**<br>**9. Хүнийг гэмт хэрэгт сэжиглэх үндэслэл байгаа бол түүнийг гэрчээр дуудах, түүнээс гэрчийн мэдүүлэг авахыг хориглоно.** |
| 3 | 16.3 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт 4.7 дахь заалт нэмэх | | **16.3 дугаар зүйл. Мэдүүлэг.**<br>4. Дараах хүнээс гэрчийн мэдүүлэг авч болохгүй;<br>**4.7.гэмт хэрэгт буруутгах илэрхий үндэслэл байгаа хүн.** |

| | | | |
|---|---|---|---|
| 4 | 16.3 дугаар зүйлд 10 дахь хэсэг нэмэх | нарийвчлан зохицуулж өгөөгүйн улмаас тухайн этгээдээс гэрчийн мэдүүлэг авч, түүний эрхийг хөндөх байдал гаргахаар байгааг хууль тогтоогч анхаарч, хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлага байна...” гэж дүгнэсэн. | **16.3 дугаар зүйл. Мэдүүлэг**<br>**10.Гэрчийн мэдүүлэг авах үед түүнийг гэмт хэрэгт сэжиглэх үндэслэл илэрсэн бол мэдүүлэг авах ажиллагааг даруй зогсооно.** |
| 5 | 5.3 дугаар зүйлд 4 дэх хэсэг нэмэх | Илтэд сэжиглэх үндэслэл бүрдсэн байтал түүнд худал мэдүүлбэл хүлээлгэх ял хариуцлагын талаар урьдчилан сануулж, мөн мэдүүлэг өгөхөөс татгалзах, зайлсхийсэн тохиолдолд Зөрчлийн хуулийн 15.7 дахь хэсэгт заасныар хариуцлага хүлээх талаар мөрдөн шалгах ажиллагаанд урьдчилан сануулж мэдүүлэг авах, энэ нь гэрчийн мэдүүлгийн маягт загварт тусгагдсан байдаг нь хүн өөрийгөө өмгөөлөх, өөрийн эсрэг мэдүүлэг өгөхийг албадуулахгүй байх, мөн мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхэд шууд харшилж байгаа болно. Монгол Улсын нэгдэн орсон НҮБ-аас 1966 онд баталсан Иргэний болон улс төрийн эрхийн тухай пактын 14/3/ g-д “өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, гэм буруутан гэж хүлээхийг албадуулахгүй байх” эрхийг баталгаажуулсан ба 1969 онд батлагдсан Хүний эрхийн тухай Америкийн конвенцийн 8.2 /g/-д “хүн бүр өөрийнхөө эсрэг гэрчлэх буюу гэм буруутан гэж хүлээхийг албадуулахгүй байх эрхтэй” гэж заасан ба 8.3-т “Яллагдагч өөрийгөө гэм буруутан гэж хүлээх нь ямар нэг албадлага хэрэглээгүй тохиолдолд хүчин төгөлдөр байна” гэснээр улам баталгаажсан байна. Илт сэжиглэгдэх үндэслэл байсаар атал гэрчээр мэдүүлэг авах нь Үндсэн хуулиар баталгаажсан “өөрийгөө өмгөөлөх”, “Өөрөө өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхийг шаардах, мэдүүлэг гаргуулахаар шахалт үзүүлэх, хүч хэрэглэхийг хориглоно” гэсэнд харшилсан шинжтэй байгаа тул хуульд өөрчлөлт оруулах замаар уг зөрчлийг арилгах нь зүйтэй. | **5.3 дугаар зүйл. Өмгөөлөгч оролцуулах**<br>**4. Сэжигтэн яллагдпагч, шүүгдэгч өөрийгөө өмгөөлөх хүсэлт гаргаснаас бусад тохиолдолд мөрдөн шалгах ажиллагааг өмгөөлөгчийн оролцоотойгоор явуулна.** |

| | | | |
|---|---|---|---|
| 6 | 16.1 дүгээр зүйлийн 14 дэх хэсгийн "**үндэслэл байвал**" гэсний дараа "**,эсхүл Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хууль зөрчиж цуглуулсан нь тогтоогдсон бол**" гэж нэмэх | Хүний халдашгүй байх, өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах эрхийг хангах хүрээнд мөрдөн байцаалтыг өмгөөлөгчийг байлцуулахгүйгээр явуулахгүй байх, хэрвээ өмгөөлөгчийг байлцуулахгүйгээр мөрдөн байцаалт явуулж нотлох баримт цуглуулсан, хэрэг хүлээлгэсэн тохиолдолд тухайн мэдүүлэг, нотлох баримтыг үнэлэхгүй байх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох<br>Үндсэн хуульд заасан "хууль зүйн туслалцаа авах" эрхийг хангаж, мэргэжлийн туслалцаа үзүүлэх үүргийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүхий л үе шатанд тасралтгүй хэрэгжүүлэх нь хүний эрхийг хангах, хамгаалахад үр нөлөөтэй бөгөөд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хууль ёсны зарчмыг хэрэгжүүлэх гол нөхцөл болно. Практикт хойшлуулшгүй ажиллагааны хүрээнд мэдүүлэг авах ажиллагааг өмгөөлөгчгүйгээр явуулж, хууль бусаар хэрэг хүлээлгэх, өөрийнх нь эсрэг мэдүүлэг авах тохиолдлууд цөөнгүй гарч байгаатай холбоотойгоор сэжигтнийг хойшлуулшгүйгээр баривчилсан тохиолдолд өмгөөлөгч заавал оролцуулах асуудлыг хуулиар баталгаажуулах шаардлагатай болно. ОХУ-ын Эрүүгийн процессын хуулийн 51 дүгээр зүйлд өмгөөлөгч заавал оролцуулах тохиолдлуудыг зохицуулсан бөгөөд 51 дүгээр зүйл, 1 дэх хэсэг: Дараах Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгч заавал оролцоно: 1. Сэжигтэн яллагдагч энэхүү хуулийн 52 дугаар зүйлд зааснаар өмгөөлөгчөөсөө татгалзаагүй бол; гэж зааснаас харахад аливаа хүн Эрүүгийн хэрэгт өмгөөлөгч сонгон авсан л бол бүхий л ажиллагаа өмгөөлөгчийн оролцоотой явагддаг байна. Өмгөөлөгч бүх хэрэг хянан шийдвэрлэх | **16.1 дүгээр зүйл. Нотлох баримт**<br>14.Нотлох баримтыг шинжлэн судлах явцад хэрэгт ач холбогдолтой, хамааралтай эсэхэд эргэлзэх үндэслэл байвал, **эсхүл Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хууль зөрчиж цуглуулсан нь тогтоогдсон бол** тухайн нотлох баримтыг шүүх, прокурорын шийдвэрийн үндэслэл болгохгүй. |
| 7 | 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт 1.7 дахь заалт нэмэх | | **5.3 дугаар зүйл.Өмгөөлөгч оролцуулах**<br>1.Дараахь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч оролцох эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг өмгөөлөгчгүйгэ5.1эр явуулж болохгүй:<br>**1.7.сэжигтнийг хойшлуулшгүйгээр баривчилсан.** |
| 8 | 1.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт 1.38 дахь заалт нэмэх | | **1.4 дүгээр зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт**<br>1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:<br>1.38.**"нотлох баримт хуулбарлаж, хувилж авах" гэж хуульд заасан үндэслэл, журмын дагуу төр, байгууллага, хувь хүний нууцад хамаарахаас бусад нотлох баримтыг хувилах, зураг авах боломжтой техник хэрэгсэл ашиглан хуулбарлаж, хувилж авахыг;** |
| 9 | 5.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.4 дэх заалтын "**хууль зүйн туслалцаа үзүүлэхэд**" гэснийг "**хэргийн бодит байдлыг тогтооход**" гэж өөрчлөх,<br>Мөн заалтад "**прокурор,**" гэсний дараа "**шүүх**" гэж, "**тусгуулах,**" | | 2.4.**хэргийн бодит байдлыг тогтооход** шаардлагатай эд зүйл, баримт бичиг, мэдээлэл, бусад баримтыг мөрдөгч, прокурор, **шүүхэд** гаргаж өгөх, түүнийг хавтаст хэрэгт бэхжүүлж тусгуулах, **хэрэгт ач холбогдол бүхий бусад байдлыг шалгуулах,** мөрдөн шалгах ажиллагаа |

| | | | |
|---|---|---|---|
| | гэсний дараа "**хэрэгт ач холбогдол бүхий бусад байдлыг шалгуулах,**" гэж тус тус нэмэх | ажиллагаанд оролцох нь хянан шийдвэрлэх ажиллагаанд хүний эрхийг хангахад чухал үр нөлөөтэй болно. | явуулах хүсэлт гаргах, энэ хуульд заасан журмын дагуу оролцох; |
| 10 | 5.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.5 дахь заалтад "**асуулт тавих,**" гэсний дараа "**хариулт авах,**" гэж нэмэх | | 2.5.өмгөөлж байгаа сэжигтэн, хохирогч, яллагдагч, шүүгдэгч, ялтны, эсхүл өөрийнхөө хүсэлтээр хийгдэж байгаа мөрдөн шалгах ажиллагаанд байлцаж, аль ч үед асуулт тавих, **хариулт авах,** хүсэлт гаргах; |
| 11 | 5.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.6 дахь заалтын "**өөрийн оролцсон**" гэснийг хасах,<br>Мөн заалтад "**хийгдсэн**" гэсний дараа "**дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг,**" гэж, "**танилцаж,**" гэсний дараа "**хуулбарлан авах, тэмдэглэлд**" гэж тус тус нэмэх | Өмгөөллийн тухай хуульд заасан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох өмгөөлөгчийн эрх, үүргийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмж тусгах<br>Өмгөөллийн үйл ажиллагаанд эдлэх эрх, үүргийг холбогдох хэрэг хянан шийдвэрлэх хуулиудаас гадна өмгөөлөгчийн бүрэн эрхийн заалт Өмгөөллийн тухай Монгол Улсын хуульд тусгалаа олсон. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шууд хамаарах Өмгөөллийн тухай хуульд заагдсан зарим эрх процессын хуульд тодорхой тусгагдаагүйгээс мөрдөн шалгах ажиллагааг хэрэгжүүлэгчдийн зүгээс хуулийн зохицуулалтыг зөрүүтэй ойлгох, хэрэг хувилж хуулбарлан авахтай холбоотой эрх болон хууль зүйн туслалцаа үзүүлэх үүргээ хэрэгжүүлэхэд хүндрэл үүсэх, хэргийн бодит байдлыг тогтооход чухал ач холбогдол бүхий баримтыг шүүхэд гарган өгөх боломжгүй болох тохиолдлууд байна. Түүнчлэн хуулийн 2.4-т заасан эрхийг зөвхөн хууль | 2.6.мөрдөн шалгах ажиллагаа, шүүхийн хэлэлцүүлэг, шүүх хуралдааны үед хийгдсэн **дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг** болон тэмдэглэлтэй танилцаж, **хуулбарлан авах, тэмдэглэлд** засвар оруулах тухай хүсэлт гаргах; |
| 12 | 5.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.12 дахь заалтад "**оролцох**" гэснийг дараа "**, холбогдох нотлох баримтуудтай танилцах, өөрийн зардлаар хуулбарлан авах**" гэж нэмэх | | 2.12 "сэжигтнийг баривчлах, яллагдагч, шүүгдэгчийг цагдан хорих, бусад таслан сэргийлэх арга хэмжээтэй холбоотой асуудлыг шийдвэрлэхэд оролцох, **холбогдох нотлох баримтуудтай танилцах, өөрийн зардлаар хуулбарлан авах;** |
| 13 | 5.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт 2.15 гэсэн заалт нэмэх | | 2.15. үйлчлүүлэгч болон бусад этгээдийн хууль бус шаардлагыг биелүүлэхээс татгалзах; |

| | | | |
|---|---|---|---|
| 14 | 14.13 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “**прокурор,**” гэсний дараа “**яллагдагч, түүний хууль ёсны төлөөлөгч,**” гэж нэмэх | зүйн туслалцаа үзүүлэхэд шаардлагатай гэж явцуурууулсаныг хэргийн бодит байдлыг тогтоох зарчмыг хэрэгжүүлэх, нөхцөл байдлыг эргэлзээгүй тогтоох хүрээнд өргөжүүлэн авч үзэх нь зүйтэй.<br>Түүнчлэн мөрдөн шалгах ажиллагааны үед хийгдсэн дууны, дүрсний, дуу дүрсний бичлэгийг өмгөөлөгч хуулбарлан авах боломжийг хуулиар нээх нь эрх тэгш мэтгэлцээний нөхцлийг хангах, мөн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хүний эрхийг зөрчихөөс урьдчилан сэргийлэх, хэргийн бодит байдлыг тогтоох, шүүн таслах ажиллагааг хуулийн дагуу цуглуулж бэхжүүлсэн нотлох баримтад үндэслэн явуулахад ач холбогдолтой гэж үзэж байна. Мэдүүлгийн тэмдэглэлүүд дууны болон дуу-дүрсний бичлэгээс зөрөх тохиолдлууд гарч байгаа бөгөөд бодит бус, мөн мэдүүлэг авахдаа оролцогчийн эрхийг зөрчиж авсан тохиолдлуудад шүүх хууль бус нотлох баримтад үндэслэн хэргийг шийдвэрлэх эрсдэлтэй болно. ЭХХШтХ-ийн 16.7 дугаар зүйлийн 2-т “Мөрдөн шалгах ажиллагаа, прокурорын хянан шалгах ажиллагаа, шүүх хуралдааны тэмдэглэлд тусгагдсан нөхцөл байдал нь дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгээс зөрсөн тохиолдолд шүүх, прокурор дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийг нотлох баримтаар тооцно” гэж заасан бөгөөд энэ заалтыг бодитойгоор хэрэгжүүлэх үүднээс өмгөөлөгч тухайн бичлэгийг хуулбарлан авах эрхтэй байхаар зохицуулах шаардлагатай болно. | **14.13 дугаар зүйл. Яллагдагчид таслан сэргийлэх арга хэмжээ авах шүүхийн хэлэлцүүлэг**<br>2.Шүүх энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан санал, хүсэлтийг хүлээн авснаас хойш 24 цагийн дотор асуудлыг хэлэлцэх шүүхийн хэлэлцүүлгийн товыг прокурор, **яллагдагч, түүний хууль ёсны төлөөлөгч,** өмгөөлөгчид мэдэгдэнэ. |
| 15 | 14.13 дугаар зүйлд 13 дахь хэсэг нэмэх | | **13.Таслан сэргийлэх арга хэмжээний талаар талуудаас шүүхэд гаргасан санал, хүсэлт, тэдгээртэй холбоотой нотлох баримтыг эрүүгийн хэрэгт хавсаргана.** |
| 16 | 1.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.20 дахь заалтад “**гэж**” дараа “**шүүхийн хэлэлжүүлэг**” гэж нэмэх<br><br>Мөн хэсэгт 1.39 дэх заалт нэмэх | | **1.4 дүгээр зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт**<br>1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:<br>1.20."талууд" гэж **шүүхийн хэлэлцүүлэг,** шүүх хуралдааны мэтгэлцээнд тэгш эрхтэй оролцож, яллах, өмгөөлөх чиг үүргийг хэрэгжүүлэгчийг;<br>**1.39.“эрүүгийн хариуцлагын талаархи тохиролцоо” гэж хэргээ хялбаршуулсан журмаар шийдвэрлүүлэх хүсэлт гаргасан яллагдагчид оногдуулах эрүүгийн хариуцлагын талаар талуудын хийсэн тохиролцоог;** |
| 17 | 33.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт 1.4 гэсэн заалт нэмэх | | **33.3 дугаар зүйл.Хэргийг прокурорт буцаах** |

| | | | |
|---|---|---|---|
| | | | 1.Урьдчилсан хэлэлцүүлгийн үед дараахь үндэслэлээр шүүх өөрийн санаачилгаар, эсхүл хэргийг буцаах тухай прокурорын санал, яллагдагч, хохирогч, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн хүсэлтийг харгалзан хэргийг прокурорт буцаахаар шийдвэрлэнэ:<br>**1.4.энэ хуулийн 32.1 дүгээр зүйлд заасан ажиллагааг бүрэн хийгээгүй.** |
| 18 | Гучин дөрөвдүгээр бүлэгт $34.11^{1}$ дүгээр зүйл нэмэх | Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа талуудын эрх тэгш мэтгэлцээний үндсэн дээр явагдах бөгөөд энэхүү нөхцөлийг шүүх хангахаар зохицуулагдсан.<br>Яллагдагчид таслан сэргийлэх арга хэмжээ авах шүүхийн хэлэлцүүлгийн товыг өмгөөлөгчид хэт тулгуу хугацаатай мэдэгддэг, өмгөөлөлд бэлтгэх хангалттай хугацаа олгодоггүй, тухайн таслан сэргийлэх арга хэмжээ авах үндэслэл болгож буй баримтуудтай танилцуулалгүйгээр тухайн асуудлыг шийдвэрлэж байгаа нь эрх тэгш мэтгэлцэх боломжийг хязгаарлаж байгаа явдал болно. Өмгөөлөгчид шүүхийн хэлэлцүүлэгт ямар баримт, нотолгооны эсрэг мэтгэлцэх нь тодорхойгүйгээр "таамаглаж" үндэслэл, байр сууриа илэрхийлэхэд хүрч байна. Иймд таслан сэргийлэх арга хэмжээтэй холбоотой хэлэлцүүлгийн товыг тодорхой хугацааны өмнө мэдэгдэх нь ИБУТЭтОУ-ын пактын 14-3 b-д зааснаар "өөрийн сонгож авсан өмгөөлөгчтэй уулзаж, өмгөөлүүлэхэд бэлтгэхэд хүрэлцэхүйц цаг хугацаа, бодит боломжтой байх" эрхийг хэрэгжүүлэх боломжийг хангах бөгөөд энэ нь шударгаар шүүлгэх болон талуудын эрх тэгш байдлын баталгаа болно. Энэ эрх нь ИБУТЭТОУ пактаас гадна Хүний эрхийн тухай Америкийн конвенцийн 8-2 с-д болон Хүний эрхийн тухай | **$34.11^{1}$ дүгээр зүйл.Гэрч, шинжээч шүүх хуралдаанд оролцох**<br>**1.Улсын яллагч, яллагдагч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч хүсэлт гаргасан бол анхан шатны журмаар хэргийг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд гэрч, шинжээчийг оролцуулна.**<br>**2.Шүүхээс дуудсан гэрч, шинжээч шүүх хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй нь хариуцлага хүлээлгэх үндэслэл болно.** |
| 19 | 34.13 дугаар зүйлд 2 дахь хэсэг нэмэх | | **34.13 дугаар зүйл.Шүүх хуралдаанд хохирогч, гэрч, шинжээч хүрэлцэн ирээгүйн холбогдол**<br>**2.Улсын яллагч, яллагдагч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн нь гэрч, шинжээч оролцуулах хүсэлтээсээ татгалзаагүй тохиолдолд шүүх хуралдааныг хойшлуулна.** |
| 20 | 39.1 дүгээр зүйлд 9 дэх хэсэг нэмэх | | **39.1 дүгээр зүйл.Давж заалдах шатны шүүхийн эрх хэмжээ**<br>**9.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэл нь иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагчийн гаргасан давж заалдах гомдлыг хянан шийдвэрлэхэд хамаарахгүй.** |

| | | | |
|---|---|---|---|
| 21 | зүйлд 9 дэх хэсэг нэмэх<br>34.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "**Энэ нь өмгөөлөх талаас шүүхэд шинээр нотлох баримт гаргах эрхийг хязгаарлах үндэслэл болохгүй**." гэсэн өгүүлбэр нэмэх | Европын конвенцийн 6-3 b-д дээрхтэй адил агуулгаар тусгагдсан байна. Пактын 14 дүгээр зүйлийн талаар гаргасан 13 дугаар Ерөнхий тайлбарт "хүрэлцэхүйц хугацаа" гэдгийг тухайн хэргийн нөхцөл байдлаас шалтгаална гээд, "бололцоо" гэдгийг өмгөөлөхөд шаардлагатай баримт бичиг болон бусад нотлох баримттай танилцах болон өмгөөлөгчтэй холбоо барьж харилцах боломжийг олгоно гэж заажээ.<br>Мөн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд, тэр тусмаа эрхийн хязгаарлалт тогтоож байгаа таслан сэргийлэх арга хэмжээ авах эсэх асуудлыг шийдвэрлэх шүүхийн хэлэлцүүлэгт яллагдагчийг аливаа хүсэлт гаргахгүйгээр оролцох боломжийг нээж ЭХХШтХ-ийн 14.13 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт өөрчлөлт оруулах шаардлагатай байна. | **34.14 дүгээр зүйл.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хэмжээ хязгаар**<br>1.Анхан шатны журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь тухайн шүүгдэгчийн хувьд прокуророос шүүхэд шилжүүлсэн эрүүгийн хэргийн хүрээнд явагдана. **Энэ нь өмгөөлөх талаас шүүхэд шинээр нотлох баримт гаргах эрхийг хязгаарлах үндэслэл болохгүй**. |
| 22 | 7.3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "танилцах" гэсний дараа ", "хувийг авах" гэж нэмэх | Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд яллах, өмгөөлөх талын эрх тэгш мэтгэлцэх зарчмыг хэрэгжүүлэхтэй холбогдсон зохицуулалтыг сайжруулах, хэргийн оролцогчийн эрхийг хангаснаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дараагийн шатанд хэргийг шилжүүлдэг зохицуулалтыг тусгах<br>Хэргийн бодит байдлыг мэтгэлцээний үндсэн дээр явуулна. Мэтгэлцээн нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүхий л үе шатанд хэрэгжих тул шүүх хуралдаан болон мөрдөн шалгах ажиллагааны явц дахь шүүхийн хэлэлцүүлгүүдэд ч мөн хамаатай болно. Иймд ЭХХШтХ-ийн 1.4 дүгээр зүйлийн 1.20-д заасан "талууд" гэсэн нэр томъёоны тодорхойлолтод өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзэж байна. Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлүүлэх асуудлын хамгийн гол зүйл нь талуудын хийсэн тохиролцоо бөгөөд үүнийг хэрхэн | **7.3 дугаар зүйл.Ямар хэрэгт яллагдаж байгаагаа мэдэх**<br>2.Яллагдагчаар татсан, таслан сэргийлэх арга хэмжээ авсан шийдвэртэй танилцах, **хувийг авах эрхтэй.** |
| 23 | 7.3 дугаар зүйлд 5 дахь хэсэг нэмэх | | **5.Хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан, мөрдөн байцаалт дууссан бол хэргийн бүх материалтай танилцаж, төр, байгууллага, хувь хүний нууцад хамаарахаас бусад нотлох баримтыг өөрийн зардлаар хуулбарлаж, хувилж авах эрхтэй.** |
| 24 | 31.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "танилцуулна." гэснийг "танилцуулж, хувийг гардуулан өгнө" гэж өөрчлөх<br>31.3 дугаар зүйлд 6 дахь хэсэг нэмэх | | **31.3 дугаар зүйл.Эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоол танилцуулах, гардуулан өгөх**<br>1.Мөрдөгч эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолыг прокуророос хүлээн авсан даруй дуудан ирүүлсэн |

| | | | |
|---|---|---|---|
| | | ойлгох, ямар субъектүүдийн хооронд энэ нь хэрэгжихийг тодорхой болгох үүднээс нэр томъёоны тодорхойлолтод энэ ойлголтыг оруулан тайлбарлах нь зүйтэй.<br>Мөн ИБУТЭтОУ-ын пактын 14-3 b-д зааснаар "өөрийн сонгож авсан өмгөөлөгчтэй уулзаж, өмгөөлүүлэхэд бэлтгэхэд хүрэлцэхүйц цаг | сэжигтэнд танилцуулж, **хувийг гардуулан өгнө.**<br>**6.Сэжигтэн эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоотой танилцах, гардан авахаас татгалзсан нь мөрдөн шалгах ажиллагаа явуулахад саад болохгүй.** |
| 25 | 16.10 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт "**Хэргийн оролцогчоос гаргасан хүсэлтийг бүрэн хангаагүй, эсхүл хангахаас татгалзсан үндэслэлээ шийдвэртээ тодорхой тусгана.**" гэсэн өгүүлбэр нэмэх | хугацаа, бодит боломжтой байх" эрхийг хэрэгжүүлэх боломжийг хангах үүднээс хэрэг танилцуулах боломжит хугацааг хуулиар тухайлан заах шаардлагатай бөгөөд бодит байдал дээр мөрдөн байцаалтыг дуусган, хэрэг танилцах хангалттай боломж хугацаа олгохгүйгээр дараагийн шатанд шилжүүлэх нь түгээмэл байна. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа бүхэлдээ прокурорын удирдлага, хяналтад явдаг, яллах өмгөөлөх талын эрх тэнцвэргүй, цагаатгах талын баримтуудыг цуглуулах, бэхжүүлэх ажиллагаа хангалттай хийгддэггүй, өмгөөлөгчийн зүгээс гаргадаг нэмэлт нотлох баримт цуглуулахтай | **16.10 дугаар зүйл.Нотлох баримт гаргаж өгөх, нотлох баримт шалгуулах, мөрдөн шалгах ажиллагаа явуулах хүсэлтийг шийдвэрлэх**<br>4. Шүүх, прокурор, мөрдөгч энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан хүсэлт нь хэргийг тал бүрээс нь бүрэн бодитой тогтооход ач холбогдолтой бол бүрэн, эсхүл хэсэгчлэн хангах, эсхүл хангахаас татгалзах тухай шийдвэр гаргана. **Хэргийн оролцогчоос гаргасан хүсэлтийг бүрэн хангаагүй, эсхүл хангахаас татгалзсан үндэслэлээ шийдвэртээ тодорхой тусгана.** |
| 26 | 34.16 дах хэсэгт 6 дугаар хэсгийг нэмэх | холбоотой хүсэлтийг хангалттай шийдвэрлэдэггүй тул өмгөөлөх тал шүүхэд нэмэлт баримт гарган өгөх боломжийг нээх нь зүйтэй гэж үзэж байгаа болно. Үүнтэй холбоотойгоор 32.1 дүгээр зүйлийн 10 дах хэсгийн заалтыг хасах нь зүйтэй. Мөрдөн шалгах ажиллагааг бүрэн хийгээгүй, ажиллагаагаар хэргийн бодит байдлыг бүрэн нотолж чадаагүй гэж үзвэл прокуророос мөрдөн байцаалтад, мөн шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгээс прокурорт буцаах зохицуулалт шаардлагатай.<br>Шүүх хуралдаанд мөрдөн шалгах ажиллагааг нууцаар явуулахтай холбоотой ил болгохыг хориглосон мэдээллийг танилцуулахдаа холбогдох хуулийг баримтална гэсэн ЭХХШтХ-ийн | **34.16 дугаар зүйл.Шүүх хуралдааныг хойшлуулах**<br>5.Шүүх хуралдааны явцад нотлох баримтаар тогтоогдсон хэргийн нөхцөл байдлыг үндэслэн шүүгдэгчид холбогдох хэргийн зүйлчлэлийг хүндрүүлэхээр бол, эсхүл энэ хуулийн 33.1 дүгээр зүйлийн 6.13, 6.14-т заасан гомдлыг шийдвэрлэх зорилгоор шүүх хэргийг хянан хэлэлцэхийг нэг удаа 60 хүртэл хоногоор хойшлуулна" гэснийг хэвээр үлдээх.<br>Мөн зүйлийн 6 дэх хэсэгт оруулахаар төсөлд тусгагдсан заалтыг хасах |
| 27 | 32.10 дугаар зүйлийн 8 дахь хэсгийн | 34.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн зохицуулалтын | **32.10 дугаар зүйлийн 8 дахь хэсэг** "Яллах дүгнэлт гардуулсны дараа хэргийн талаар |

| | | | |
|---|---|---|---|
| | Яллах дүгнэлт гардуулсны дараа хэргийн талаар гаргасан хүсэлт, гомдлыг гэсний дараа "*прокурор энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу хянан шийдвэрлэсний дараа хэргийг*" гэж нэмэх | агуулгыг тодорхой болгох шаардлагата бөгөөд аливаа хүн өөрийг нь буруутгаж байгаа баримттай бүрэн танилцахгүйгээр шийтгүүлэх, энэ боломжийг түүний өмгөөлөгч ч эдлэх боломжгүйгээр хэргээ шийдвэрлүүлэх үр дагавар байгаа тул хуулийн энэ зохицуулалтыг хүний эрхийг зөрчихгүй байдлаар, шударга шүүхээр шүүлгэх эрхийг бодитойгоор хэрэгжүүлэх боломжтой байдлаар найруулах саналтай.<br>Гэрч, шинжээч, хохирогчийг шүүх хуралдаанд дуудан ирүүлж, шүүх хуралдааны танхимд хэргийн нөхцөл байдлыг тодруулах нь бодитойгоор хэргийг шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой. Практикт мөрдөн шалгах ажиллагааны явцад бодит бус мэдүүлэг гаргаж, уг мэдүүлэгт үндэслэн яллагдагчаар татаж, буруутгах явдал байдаг. Тухайн мэдүүлэг авах ажиллагаанд яллагдагчийн өмгөөлөгч бараг оролцдоггүй тул мөрдөн байцаалтын ажиллагаа дуусахад л хэргийн материалтай танилцсанаар л энэ талаар мэдэх боломжтой. Тухайн хүний мэдүүлэгтэй холбоотой ажиллагаа хийгдэхгүй, уг мэдүүлгийг үгүйсгэх, няцаах боломж олгохгүйгээр шүүхэд шилжиж, шүүх хуралдаанд л дуудан ирүүлж нөхцөл байдлыг тодруулах боломж үлддэг. Шүүх хуралдаанд дуудагдсан гэрч, шинжээч хүрэлцэн ирэхгүй байгаа тохиолдолд шууд хуралдаанаар хэлэлцэх нь түгээмэл бөгөөд ингэснээр хангалттай мөн бодитой нотолгоо баримтгүйгээр, бодит бус мэдүүлэгт үндэслэн хүнийг буруутгах нөхцөл бүрддэг тул өмгөөлөгч хүсэлт гаргасан, түүнээсээ татгалзаагүй тохиолдолд тухайн гэрч шинжээч, хохирогчийг заавал хуралдаанд оролцуулах зохицуулалтыг хуульд тусгах нь зүйтэй.<br>Хуульд иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч нь зөвхөн иргэний нэхэмжлэлд хамаарах асуудлаар | гаргасан хүсэлт, гомдлыг прокурор энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу хянан шийдвэрлэсний дараа хэргийг шүүхэд шилжүүлнэ." |

| | | | |
|---|---|---|---|
| | | гомдол гаргах эрхтэй байхаар зохицуулсан. Харин ийнхүү гаргасан гомдлоор давж заалдах шатны шүүх хэргийг хянахдаа иргэний нэхэмжлэлтэй холбоотой асуудлын тухайд хянахгүйгээр бүхэлд нь хянаж байгааг өөрчлөх шаардлагатай. Иргэний нэхэмжлэгч, хариуцагчийн тухайд гаргасан гомдлын хүрээнд буюу иргэний нэхэмжлэлтэй холбоотой асуудлаар л хянаж, шийдвэрлэх нь зөв гэж үзэж байгаа болно. | |
| 28 | 32.10 дугаар зүйлийн 8 дахь хэсгийн Яллах дүгнэлт гардуулсны дараа хэргийн талаар гаргасан хүсэлт, гомдлыг гэсний дараа "*прокурор энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу хянан шийдвэрлэсний дараа хэргийг*" гэж нэмэх | Энэ өөрчлөлт нь урьдчилсан хэлэлцүүлгийн агуулга, ая холбогдлыг үгүйсгэж байгаа тул төслөөс хасах саналтай. Харин мөрдөн шалгах ажиллагааны явцад прокурорт болон дээд шатны прокурорт гаргасан хүсэлт гомдлыг шийдвэрлүүлсэний дараа хэргийг прокурорт шилжүүлэх санал гаргах талаар хуулийн 32.10 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт өөрчлөлт оруулах шаардлагатай. | **32.10 дугаар зүйлийн 8 дахь хэсэг** "Яллах дүгнэлт гардуулсны дараа хэргийн талаар гаргасан хүсэлт, гомдлыг прокурор энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу хянан шийдвэрлэсний дараа хэргийг шүүхэд шилжүүлнэ." |
| **Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн дараах зүйл, хэсэг заалтыг өөрчлөн найруулсугай** | | | |
| 29 | 9.6 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн "**мэдүүлэг өгөхөөс татгалзаж, өмгөөлөгчтэй мэдүүлэг өгөх эрхтэй.**" гэснийг "**мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхтэй.**" гэж өөрчлөн найруулах | | **9.6 дугаар зүйл. Гэрч**<br>6. Гэрч өөрийнх нь эсрэг, түүнийг гэмт хэрэг үйлдсэн, гэм буруутай байдлаар мэдүүлэг авч байна гэж үзвэл энэ тухай тэмдэглэлд тусгуулан **мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхтэй.** |
| 30 | 14.13 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг өөрчлөн найруулах | | 3.**Шүүхийн хэлэлцүүлэгт прокурор, яллагдагч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийг оролцуулна.** |
| 31 | 14.13 дугаар зүйлийн 5 дахь хэсгийг өөрчлөн найруулах | | 5.**Прокурор, яллагдагч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч гаргасан санал, хүсэлтийн үндэслэл болгож байгаа нотлох баримтыг шүүх хэргийн оролцогчид танилцуулж, тэдгээрт** |

| | | | |
|---|---|---|---|
| | | | тайлбар хийх, холбогдох нотлох баримтыг гаргаж өгөх боломжоор хангана. Талуудад танилцуулагдаагүй баримт нь шүүхийн шийдвэрийн үндэслэл болохгүй. |
| 32 | 32.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг өөрчлөн найруулах | | **32.1 дүгээр зүйл.Хавтаст хэргийн материал танилцуулах**<br>**3.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан оролцогч хэргийн материалтай 14 хоногийн хугацаанд танилцах ба мөрдөгч хэргийн материалтай танилцах боломж, нөхцөлийг бүрдүүлнэ. Хавтаст хэргийн тоо, хэргийн оролцогчдын тооноос хамааран хэргийн материалтай танилцах хугацааг мөрдөгч 14 хүртэл хоногоор сунгаж болно.** |
| 33 | 32.1 дүгээр зүйлийн 9 дэх хэсгийг өөрчлөн найруулах | | **9.Нэмэлт мөрдөн байцаалт явуулсан бол нэмж хийсэн ажиллагааны материалыг энэ зүйлд заасан журмын дагуу оролцогчид танилцуулна.** |
| 34 | 32.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг өөрчлөн найруулах | | **32.2 дугаар зүйл.Хэргийг прокурорт шилжүүлэх**<br>**1.Энэ хуулийн 32.1 дүгээр зүйлд заасан ажиллагаа бүрэн хийгдэж дууссаны дараа мөрдөгч холбогдох саналыг хавтаст хэргийн хамт 3 хоногийн дотор прокурорт шилжүүлнэ.** |

| | | | |
|---|---|---|---|
| 35 | 32.9 дүгээр зүйлийг бүхэлд өөрчлөн найруулах | | **32.9 дүгээр зүйл. Прокуророос хэргийг мөрдөн байцаалтад буцаах**<br>**1.Прокурор дор дурдсан үндэслэлээр хэргийг мөрдөн байцаалтад буцаана:**<br>**1.1.хэрэгт нэмэлт мөрдөн шалгах нэмэлт ажиллагаа хийлгэх шаардлагатай бол;**<br>**1.2.яллагдагчийг буруутгаж байгаа Эрүүгийн хуулийн зүйл, хэсэг, заалтыг өөрчлөх, нэмэлт оруулсантай холбоотой нэмэлт ажиллагаа хийлгэх;**<br>**1.3.энэ хуулийн 32.1 дүгээр зүйлд заасан ажиллагааг бүрэн хийгээгүй.** |
| 36 | 34.8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг өөрчлөн найруулах | | **34.8 дугаар зүйл.Хохирогч шүүх хуралдаанд оролцох**<br>**1.Хохирогч бичгээр хүсэлт гаргасан, эсхүл улсын яллагч, яллагдагч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч хүсэлт гаргасан бол анхан шатны журмаар хэргийг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд хохирогчийг оролцуулна.** |
| 37 | 34.8 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг өөрчлөн найруулах | | **34.8 дугаар зүйл.Хохирогч шүүх хуралдаанд оролцох**<br>**2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэлээр шүүх хуралдаанд оролцуулахаар шийдвэрлэсэн хохирогч ирээгүй нь шүүх хуралдааныг хойшлуулах үндэслэл болно.** |
| **Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн дараах зүйл, хэсэг заалтыг хассугай** | | | |
| 38 | 5.3 дугаар зүйлийн 1.6 дахь заалтын “**төлбөрийн чадваргүйн улмаас**” гэснийг хасах | | **5.3 дугаар зүйл.Өмгөөлөгч оролцуулах**<br>1.Дараахь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч оролцох эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг өмгөөлөгчгүйгээр явуулж болохгүй: |

| | | | |
|---|---|---|---|
| | | | **1.6.өмгөөлөгч оролцуулах хүсэлт гаргасан** |
| 39 | 5.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "**2.15**" гэснийг "**2.16**" гэж өөрчлөх, тус заалтын "**энэ**" гэснийг хасах | | 2.16.хуульд заасан бусад эрх. |
| 40 | 32.1 дүгээр зүйлийн 10 дахь хэсгийг хасах | | ~~10.Энэ хуульд заасны дагуу оролцогчид танилцуулаагүй, хавтаст хэрэгт хавсаргаагүй өмгөөлөгчийн нотлох баримтыг шүүх хуралдаанаар хэлэлцэхгүй~~ |
| 41 | 11.11 дүгээр зүйлийн 7 дахь хэсгийн "**шалгах"** гэсний дараа "**эрх бүхий"** гэдгийг хасах | Нэр томъёог жигдлэн мөрдөн шалгах байгууллага гэж тусгах. ЭХХШтХ-ийн 6.2, 31.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт тус тус "мөрдөн шалгах байгууллага" гэж тусгасан. | 11.11 дүгээр зүйлийн 7 дахь хэсэг Хавтаст хэргийг цахимжуулах, шүүх прокурор, мөрдөн шалгах байгууллагуудын нэгдсэн системд холбох журмыг Шүүхийн ерөнхий зөвлөл, Улсын ерөнхий прокурор, хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална. |
| 42 | 14.10 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн "Мөрдөн шалгах ажиллагааны явцад гэмт хэрэг үйлдэж, яллагдагчаар татагдан цагдан хоригдсон бол цагдан хорих хугацааг шинээр тоолно." гэснийг бүхэлд нь хасах | Мөрдөн шалгах ажиллагааны явцад дахин гэмт хэрэг үйлдэж цагдан хоригдсон тохиолдолд цагдан хорих хугацааг тусад нь тоолох шаардлага огт байхгүй, үүнтэй холбоотой бодит хүндрэлүүд гардаггүй болно. Монгол Улсын нэгдэн орсон, НҮБ-аас 1966 онд баталсан Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 9-р зүйлийн 3-т "... Шүүхийн өмнөх шатанд байгаа хүнийг заавал цагдан хорьж байх нийтлэг журам байх албагүй бөгөөд шүүх хуралд оролцох, шүүн таслах ажиллагааны аль ч шатанд байлцах, шаардлагатай тохиолдолд, шүүхийн шийдвэр гүйцэтгэхэд байх баталгаа гаргаж өгсөн бол этгээдийг суллаж болно" гэж заасан. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.1 дүгээр зүйлд цагдан хорьж мөрдөхөөс гадна өөр төрлийн 5 арга хэмжээг дангаар нь болон давхардуулан авч, сонгон хэрэглэх боломжтойгоор нэрлэн заасан байдаг. Энэ арга хэмжээнүүдээс аль тохирохыг нь сонгон хэрэглэж хэрэг хянан | Төслөөс хасах саналтай. |

| | | | |
|---|---|---|---|
| | | шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэх бүрэн боломжтой.<br>Цагдан хорьж дээд хугацааг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.10 дугаар зүйлд, харин өсвөр насны яллагдагчийн тухайд 18.8 дугаар зүйлд тодорхой зохицуулсан байдаг бөгөөд энэ зохицуулалтын хүрээнд хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг хэвийн явуулах бүрэн боломжтой. Түүнчлэн ЭХХШтХ-ийн 14.10 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт "Нэг хэрэгт дахин, эсхүл тусгаарласан, нэгтгэсэн хэрэгт шинээр цагдан хоригдсон бол өмнө нь цагдан хоригдсон хугацааг нийт цагдан хоригдсон хугацаанд оруулж тооцно" гэж заасан бөгөөд энэ нь манай улсын нэгдэн орсон олон улсын хүний эрхийн баримт бичгүүдэд бүрэн нийцэж байгаа бөгөөд хоригдсон этгээдийн эрх зүйн байдлыг дордуулахгүй байх талаасаа тохиромжтой зохицуулалт.<br>Харин ЭХХШтХ-ийн 14.10 дугаар зүйлийн 9-д заасан "Энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан яллагдагчийн цагдан хоригдсон хугацааг баривчилсан өдрөөс, эсхүл яллагдагчийг цагдан хорьсон өдрөөс эхлэн прокурор хэргийг шүүхэд шилжүүлэх хүртэл тоолно" гэсэн зохицуулалт нь яллагдагчийг шүүхийн шатанд хугацааны хязгаарлалтгүй хорих боломжийг бий болгож байгаа, хүний эрхийн талаасаа ухралт болсон зохицуулалт тул хүчингүй болгох зайлшгүй шаардлагатай юм. Учир нь олон улсын хүний эрхийн талаарх баримт бичгүүдэд цагдан хоригдсон "хүн"-ийг гэж нийтлэг ойлголтоор тусгаснаас бус сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг гэж ялган тодорхойлоогүйг харгалзан үзэх ёстой. | |
| 43 | 34.16 дах хэсэгт 6 дугаар хэсгийг хасах | Энэ заалтыг хасах саналтай. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа бүхэлдээ прокурорын | **34.16 дугаар зүйл.Шүүх хуралдааныг хойшлуулах** |

| | | | |
|---|---|---|---|
| | | хяналтад явагддаг бөгөөд тухайн хэргийг хангалттай нотлогдсон гэж үзэж хэргийг шүүхэд шилжүүлэх эсэхийг прокурор бие даан шийдвэрлэдэг. Хангалттай цаг хугацаагаар мөрдөн шалгах ажиллагаа явуулж, яллах үндэслэл бүрдсэн гэж шүүхэд шилжүүлсэн атлаа нэмэлт ажиллагаа шаардлагатай гэсэн үндэслэлээр 60 хоног шүүхээс олгож, шаардлагатай ажиллагааг гүйцэтгүүлж байгаа нь хангалттай хугацаа юм. Энэхүү төсөлд тусгагдсанаар шүүх хуралдааныг 30 хүртэл хоногоор сунгах боломжийг нээвэл мөрдөн шалгах ажиллагааг хэрэгжүүлдэг байгууллага дээр нотлох баримтыг цуглуулдаг, бэхжүүлдэг ажиллагаа нь шүүх рүү шилжих, дээр нь цаг хугацааны хязгаарлалтгүй, хэдэн удаа хойшлогдохыг тодорхой заагаагүй тул тухай бүр 30 хоногоор сунгагдах нөхцөл бүрджээ. Иймд энэ нэмэлтийг төслөөс хасах саналтай. | 5.Шүүх хуралдааны явцад нотлох баримтаар тогтоогдсон хэргийн нөхцөл байдлыг үндэслэн шүүгдэгчид холбогдох хэргийн зүйлчлэлийг хүндрүүлэхээр бол, эсхүл энэ хуулийн 33.1 дүгээр зүйлийн 6.13, 6.14-т заасан гомдлыг шийдвэрлэх зорилгоор шүүх хэргийг хянан хэлэлцэхийг нэг удаа 60 хүртэл хоногоор хойшлуулна" гэснийг хэвээр үлдээх.<br>Мөн зүйлийн 6 дэх хэсэгт оруулахаар төсөлд тусгагдсан заалтыг хасах |
| **Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн дараах зүйл, хэсэг заалтыг хэвээр үлдээсүгэй** | | | |
| 44 | 34.10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "төлөөлнө." гэдгийг төслөөс хасч, одоогийн зохицуулалтыг хэвээр үлдээх. | Өмгөөллийн тухай хуулийн 18-д заасны дагуу өмгөөлөгчид өөр өөрийн гэсэн бие даасан байр суурьтай байж болохоор зохицуулсан ба үйлчлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөх эрхийг хязгаарлахыг хориглосон зохицуулалтууд Өмгөөллийн тухай хуульд тусгагдсан. Түүнчлэн тодорхой асуудлаар мэтгэлцэхэд гэдэг ньпрактик хэрэглээнд тодорхойгүй байдал бий болгох магадлалтай. Тухайлбал олон зүйл хэсгээр буруутгагдаж байгаа шүүгдэгчийг хэд хэдэн өмгөөлөгч өмгөөлж, зүйл хэсэг бүрт няцаалт өгөх шаардлага үүсэхэд үүнийг | 34.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэг "Шүүгдэгчийг хэд хэдэн өмгөөлөгч өмгөөлж байгаа бол шүүх хуралдаанд тодорхой асуудлаар мэтгэлцэхэд нэг өмгөөлөгч бусдыгаа төлөөлж болно." |

| | | | |
|---|---|---|---|
| | | энэ зохицуулалтаар хязгаарлах тохиолдол үүсч болно. Мөн өмгөөлөгчид өөр өөрийн байр сууринаас асуудалд хандан, цагаатгах, яллагаа няцаах чиг үүрэгтэйгээр оролцох боломжийг хязгаарлах, улмаар олон улсын хүний эрхийн баримт бичгүүдэд тусгагдсан эрхүүдийг хязгаарлах тул энэ өөрчлөлт шаардлагагүй. | |
| 45 | 34.12 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн "болох ба энэ талаарх мэдээллийг харьяалах прокурорын байгууллага, Монголын Өмгөөлөгчдийн холбоонд даруй хүргүүлнэ." гэдэгийг хасч одоогийн зохицуулалтыг хэвээр үлдээх | Энэ зохицуулалт шаардлагагүй. Шүүхэд зөрчлийн хууль хэрэглэн хариуцлага хүлээлгэх эрх байгаа тохиолдолд харъяалах байгууллагуудад мэдэгдэх, хариуцлага тооцуулах асуудлыг дахин хөндөх нь зохимжгүй. | 34.12 дугаар зүйлийн 3 дахь хэсэг "Улсын яллагч, өмгөөлөгч, иргэдийн төлөөлөгч шүүх хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй нь хариуцлага хүлээлгэх үндэслэл болно." |
| 46 | 34.16 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн "хоёр ба түүнээс дээш удаа давтагдаж" гэснийг, мөн зүйлийн 5 дахь хэсгийн "нэг удаа" гэснийг хэвээр үлдээх | Энэ өөрчлөлтийг төслөөс хасах саналтай. "Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд санаатай саад учруулах нөхцөл болж байвал" гэдэг нь хэт ерөнхий, субъектив шинжтэй, шийдвэр гаргах албан тушаалтны хүсэл зоригоос шууд хамааралтай тул иргэний Үндсэн хуулиар хамгаалагдсан өмгөөлүүлэх эрх зөрчигдөх магадлалтай. Хэдийгээр императив шинжтэй бус, шүүх тухайн үеийн нөхцөл байдал, шалтгаан үндэслэлийг харгалзахаар зохицуулсан мэт боловч практикт шүүгдэгчийн эрхийг шууд хязгаарлах байдлаар хэрэгжих магадлалтай. Харин хүндэтгэн үзэх шалтгаан тогтоогдохгүй бол шүүх эрх хэмжээнийхээ хүрээнд хариуцлага тооцох эрхээ хэрэгжүүлэх боломжтой. | 34.16 дугаар зүйлийн 3 дахь хэсэг Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэл нь хоёр ба түүнээс дээш удаа давтагдаж эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд санаатай саад учруулах нөхцөл болж байвал шүүх хуралдааныг хойшлуулахгүй байж болно.<br>34.16 дугаар зүйлийн 5 дахь хэсэг<br>Шүүх хуралдааны явцад нотлох баримтаар тогтоогдсон хэргийн нөхцөл байдлыг үндэслэн шүүгдэгчид холбогдох хэргийн зүйлчлэлийг хүндрүүлэхээр бол, эсхүл энэ хуулийн 33.1 дүгээр зүйлийн 6.13, 6.14-т заасан гомдлыг шийдвэрлэх зорилгоор шүүх хэргийг хянан хэлэлцэхийг нэг удаа 60 хүртэл хоногоор хойшлуулна" гэсэн зохицуулалтыг одоогийн зохицуулалтаар үлдээх. |

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД О.АЛТАНГЭРЭЛ ТАНАА

МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБОО

14201 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Сүхбаатарын талбай-7,
Монголын Хуульчдын холбооны байр
Веб: www.mglbar.mn, И-мэйл: info@mglbar.mn
Утас: 70116364, Факс: 70116364

2024.10.28 № 1/971
танай 2024.10.17-ны № 1/1332 -т

## Санал өгөх тухай

Танаас 1/1332 дугаартай албан бичгээр ирүүлсэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй танилцлаа. Тус хуулийн төсөлд хуульчдаас ирүүлсэн саналыг нэгтгэн хүргүүлж байна. Үүнд:

1.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.1 дүгээр зүйлийн 12 дахь хэсэг буюу урьдчилсан хэлэлцүүлгээр энэ зүйлийн 6 дахь хэсгийн 6.13 дах заалтад заасан нотлох баримт цуглуулж, бэхжүүлэх талаар хуульд заасан журам зөрчигдсөн талаар, 6.14 дэх заалтад заасан хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад оролцогчийн эрхийг зөрчсөн, хууль бусаар хязгаарласан, 6.15 дах заалтад заасан мөрдөн шалгах ажиллагаа нэмж хийлгэх хүсэлтийг шийдвэрлэх боломжгүй бол хэлэлцэхгүй орхиж, анхан шатны шүүх хуралдаанаар уг асуудлыг шийдвэрлэнэ гэдэг заалтыг боловсронгуй болгож, энэ талаарх хүсэлт (цахимаар болон цаасаар) дээр талууд эсрэг байр суурьтай бол хүсэлтийг хэлэлцэхгүй орхих гэсэн өөрчлөлт оруулах;

2.Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг хийгдэх болсон шалтгаан, үндэслэлийн талаар талуудад цахим хэлбэрээр урьдчилан мэдэгдэх, бэлтгэх боломжийг хангах; зохицуулалт нэмэх;

3.Шүүхээс прокурорт хэрэг буцаах зохицуулалтыг эргэн харж, байгаа нотлогдсон хэмжээнд хэргийг шийдвэрлэх үзэл санааг бататгах;

4.Урьдчилсан хэлэлцүүлгийн товыг прокурор, өмгөөлөгчийн цахим саналыг харгалзан тогтоож байх хуулийн заалтыг хэрэгжүүлэх, урьдчилсан хэлэлцүүлэг явуулах тухай өмгөөлөгч, оролцогчдын гомдол, хүсэлт, шүүгчийн захирамжийг прокурорт заавал цахим хэдлбэрээр хүргүүлдэг байх, шүүх өөрийн санаачлагаар урьдчилсан хэлэлцүүлэг явуулах хууль зүйн үндэслэл тодорхойгүй байдгийг шийдвэрлэх;

01000375

5.ЭХХШТХ-д яллагдагчийг шүүхэд шилжүүлэх хэсэгт шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг явуулах талаар гомдол, хүсэлтэд тавигдах шаардлага, үндэслэлийг тодорхой болгох.

6.Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгт мэтгэлцэх зарчмыг бодитой хэрэгжүүлэх үүднээс оролцогч талуудаас гаргасан цахимаар болон бичгээр гаргасан хүсэлт болон шүүгч өөрийн санаачилгаар явагдах хэлэлцүүлгийн үндэслэл, шалтгаан, түүнтэй холбоотой баримт сэлтийг цахим хэлбэрээр харилцан танилцах боломжоор хангах зохицуулалтыг нэмж тусгах. Өөрөөр хэлбэл шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгт бэлтгэх, оролцогчдын гаргасан гомдол, хүсэлт түүнтэй холбоотой үйл баримт, хууль зүйн факттай цахим хэлбэрээр танилцах, хариу няцаалт бэлтгэх боломжийг агуулсан журмыг тусгах;

7.Шүүхийн өмнөх болон шүүхийн үе шатанд цахим хэлбэрээр хүсэлт гаргах, хариу өгөх, харилцах боломжоор хангах нь зүйтэй байна. Өнөөгийн байдлаар эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх бүх ажиллагааг цаасан хэлбэрээр явуулж байгаа бөгөөд мөрдөгч, прокурор, шүүгчийн ажлын ачааллын үндсэн шалтгаан болж байна. Иймээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаг хэрэгжүүлэгчид шийдвэрээ цахим хэлбэрээр баталгаажуулах, хүргүүлэх хэрэгт хавсаргах талаар зохицуулалт нэмэх зэрэг болно.

ЕРӨНХИЙЛӨГЧ П.ОДГЭРЭЛ

МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБОО
8119414
9021110023

МОНГОЛ УЛС
ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛ

15150-0007 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
5 дугаар хороо, Тасганы овоо, Хувьсгалын зам 22,
Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн байр,
Утас: 7000 8045, Факс: (976) 7000 7021,
И-мэйл: contact@judcouncil.mn, Вэбсайт: www.judcouncil.mn

2024. 11. 07 № 01/1830

танай ____________-ны №____________-т

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД
О.АЛТАНГЭРЭЛ ТАНАА

Таны 2024 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 1/1332 дугаар албан бичигтэй танилцлаа.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгуулахаар ирүүлсэн саналыг нэгтгэн, хүргүүлж байна.

Хүлээн авч танилцана уу.

Хавсралт 9 хуудастай.

Хүндэтгэсэн,

ДАРГА Л.ЭНХБИЛЭГ

91

Шүүхийн ерөнхий зөвлөлийн
2024 оны 11 дүгээр сарын 07
өдрийн 01/1830 дугаар албан
бичгийн хавсралт

УХА0052 1701517

# Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд шүүх, шүүхийн Тамгын газар, ажлын хэсгээс ирүүлсэн саналын нэгтгэл

| Д/д | Санал өгсөн | Хуулийн төслийн зүйл, заалт, хэсэг | Өгсөн санал | Саналын үндэслэл, тайлбар |
|---|---|---|---|---|
| 1. | Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх | 1 дүгээр зүйл<br>17/34.9 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг | -өөрчлөн найруулах эсхүл хасах | Шүүх хуралдаанд оролцсон атлаа шүүх хуралдаанаас зайлсхийх тохиолдол бага. Нөгөө талаас тухайн тохиолдол үүсэхэд зөвхөн гэм буруутай эсэхийг шийдвэрлээд эрүүгийн хариуцлагын хуралдаан явуулахгүйгээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаар түдгэлзүүлэх эсхүл шүүх хуралдааныг хойшлуулж орхихыг зөвшөөрөх боломжгүй. Мөн шүүгдэгч анхнаасаа өмгөөлөгч аваагүй бол заавал өмгөөлөгч оролцуулна гэдэг нь шүүхийн хувьд хэрэгжүүлэх боломжгүй, маргаан дагуулах асуудал болно. |
| | | 1 дүгээр зүйл<br>18/34.13 дугаар зүйлийн 2 дахь хэсэг | -өөрчлөн найруулах<br>2. Хохирогч бичгээр хүсэлт гаргасан атлаа шүүх хуралдаанд хүндэтгэх шалтгаангүйгээр ирээгүй эсхүл оролцохоос татгалзсан бол шүүх хуралдааныг хойшлуулахгүй. 3. “Шүүх урьдчилсан хэлэлцүүлгээр ЭХХШтХ-ийн 33.1 дүгээр зүйлийн 6.10 дахь заалтад заасны дагуу прокурор, оролцогчийн санал, хүсэлтийг хангасан боловч шүүх хуралдаанд дуудагдсан этгээд ирээгүй тохиолдолд талуудын хүсэлтийг харгалзан шүүх хуралдааныг хойшлуулах эсэхийг шүүх бүрэлдэхүүн шийдвэрлэнэ.” Гэх санал | Ингэснээр шүүх хуралдаанд удаа дараа хойшлох нөхцөл байдлыг бууруулах, оролцогч, талууд шүүх хуралдаанд дуудах хүнийг урьдчилан шийдвэрлүүлэх болон бусад хуульд заасан үндэслэл, журмыг мөрдөх нөхцөл хангагдана. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | 3 дугаар зүйл: 9/34.8 дугаар зүйлийн 1-2 дахь хэсэг | 1 дэх хэсгийг өөрчлөн найруулах, 2 дахь хэсгийг хасах 1. "Хохирогч бичгээр хүсэлт гаргасан эсхүл шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгээр ЭХХШтХ-ийн 33.1 дүгээр зүйлийн 6.10 дахь заалтад зааснаар прокурор, оролцогчийн санал, хүсэлтийг хангасан бол…оролцуулна." гэж өөрчлөх | 18/34.13 дугаар зүйлийн саналын үндэслэл нэгэн адил хамаарна. Мөн шүүх хуралдаанд дуудагдсан хүн ирээгүйн холбогдлыг 34.13 дугаар зүйлд нэг мөр зохицуулан шийдвэрлэх боломжтой тул 34.8 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг хасах. |
| | | 5 дугаар зүйл 34.16 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн "2 ба түүнээс дээш удаа давтагдаж" гэснийг хасах өөрчлөх / хасах боломжгүй/ | 2 ба түүнээс дээш удаа давтagдаж гэснийг "3 ба түүнээс дээш удаа давтагдаж" гэж өөрчлөх. | Анх шүүх хуралдаан удаа дараа хойшлогддог талаарх судалгааны үндсэн дээр тухайн зохицуулалтыг хийсэн тул дахин хасах үндэслэлгүй гэж үзэж байна. Харин давтамжийг нь өөрчлөх боломжтой. |
| 2. | Багануур дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх | 1 дүгээр зүйл 20/34.16 дугаар зүйлийн 9 дэх хэсэг | Шүүгдэгч нь томилсон өмгөөлөгчөөс хуульд заасан үндэслэл тогтоогдоогүй бол татгалзах эрхгүй гэдгийг хуульд тодорхой тусгах. | Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.16 дугаар зүйлийн 9 дэх заалтыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.16 дугаар зүйлийн 3 дахь хэсэгтээ уялдуулах. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгчөөсөө олон дахин татгалзаж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд удаа дараа саад учруулах байдлыг арилгах зорилготой. |
| 3. | Баян-Өлгий аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх | 1 дүгээр зүйл 17/34.9 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг | "Яллагдагч, шүүгдэгч шүүхээс оргон зайлсан бол түүний эзгүйд хэргийг өмгөөлөгчийг оролцуулан шийдвэрлэх" гэж нэмэх. | Тайлбар ирүүлээгүй. |
| 4. | Баянхонгор аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх | ЭХХШТХ-ийн 39.9 дүгээр зүйлийн 1-ийн 1.3 | ЭХХШТХ ийн 39.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.3-д " …энэ хуулийн 33.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 34.7 дугаар зүйлийн 6.2-т заасан үндэслэлээр анхан шатны шүүхийн шийдвэрийг бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг хүчингүй болгож, хэргийг прокурорт, эсхүл дахин хэлэлцүүлэхээр шүүхэд буцаах…" гэж байсан заалтыг эргэж оруулах | Давж заалдах шатны шүүх нь ЭХХШТХ ийн 39.5-д зааснаар анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, тус шүүхээр дамжуулан хэргийг нэмэлт мөрдөн байцаалтад буцааж шийдвэр гаргах боломжгүй болсон. Энэ заалтыг хүчингүй болгосноор хэрэг шийдвэрлээд шийдвэр гаргахад баримтлах тодорхой заалтгүйгээс одоо 39.5-ийг баримталж байгааг анхаарах |
| | | 38.2 дугаар зүйлийн 3 | Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хугацаа хэтрүүлж гаргасан гомдлыг шүүх хүлээж авахгүй. Бусад тохиолдолд анхан шатны шүүх гомдол, эсэргүүцлийг буцаах,хүлээн авахаас татгалзахыг хориглоно..гэж өөрчлөн найруулах | Анхан шатны шүүх нь давж заалдах гомдол, эсэргүүцлийг хуульд заагаагүй бусад үндэслэлээр буюу албан бичгээр гомдол эсэргүүцлийг хүлээн авахгүй буцаасан тохиолдол гарсан байна |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | 9.6 дугаар зүйлийн дараа 9.6 [1] заалт | гэмт хэрэгт сэрдэгдэх хангалттай үндэслэл байгаа хүнийг гэрчээр байцаахыг хориглоно..гэж нэмэх сэжигтнээр тооцох, тогтоол гаргах эрх зүйн үндсийг нэмэх | Гэмт хэрэгт сэрдэгдэж байгаа хүнийг анх гэрчээр байцааж мэдүүлэг авах нь хууль зөрчиж, улмаар нотлох баримтаар үнэлэхгүй, тооцохгүй байх үндэслэл болж байна. Хуульд сэжигтэн гэсэн статус тодорхойгүй байх тул сэжигтний эрх зүйн байдлыг тодорхой болгож, эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татахаас өмнө сэжигтнээр тооцон мэдүүлэг авах ажиллагааг тодорхой болгох |
| | | 38.1-ийн 1 | т "... улсын яллагч гэснийг прокурор..." гэж өөрчлөх | Анхан шатны шүүх хуралдаанд оролцсон улсын яллагч эсэргүүцэл бичих боломжгүй буюу хүндэтгэн үзэх шалтгаан тохиолдоход өөр прокурор эсэргүүцэл бичих боломжтой болно. |
| 5. | Говь-Алтай аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх | Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 39.9 дүгээр зүйл | Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд 1.3 дахь заалт нэмж, Уг заалтад энэ хуулийн 39.5 дугаар зүйлд заасан үндэслэлээр анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолыг хүчингүй болгосон тохиолдолд хэргийг анхан шатны шүүхээр дахин хэлэлцүүлэхээр буцаах зохицуулалтыг тусгах саналтай байна. | Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 39.5 дугаар зүйлд давж заалдах шатны шүүхээс анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй, болгох өөрчлөх үндэслэлийг зохицуулсан бөгөөд ийнхүү өөрчилж, хүчингүй болгосон тохиолдолд хэргийг хэрхэх нь зохицуулалтгүй үлдсэн. Түүнчлэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 39.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт давж заалдах шатны шүүх гомдол эсэргүүцлийг хянан шийдвэрлэхдээ тухайн хэргийн бүх ажиллагаа шийдвэрийг бүхэлд нь хянахаар зохицуулсан. Тиймээс энэ эрх хэмжээнийхээ хүрээнд анхан шатны шүүхийн бүх ажиллагаа, шийдвэрийг хянаж, зөвтгөх боломжтой байх шаардлагатай. |
| | | Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.1 дүгээр зүйл. | Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд 33.1 дүгээр зүйлийн 12 дахь заалтын "Шүүхийн шатнаас урьдчилсан хэлэлцүүлэг рүү хэрэг буцаахгүй" гэснийг "Анхан шатны журмаар хэргийг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанаас урьдчилсан хэлэлцүүлэг рүү хэрэг буцаахгүй" гэж өөрчлөх. | Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд анхан шатны журмаар эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагааг тодорхой үе шатуудад хуваагаагүй, шүүхийн шат гэсэн нэр томьёог тухайн хуульд тайлбарлаагүйгээс тодорхойгүй байдал бий болсон. |
| 6. | Говь-Алтай аймаг дахь Сум дундын | 1 дүгээр зүйл 19/34.16 дугаар зүйлийн 6 дахь хэсэг | 60 хүртэл хоногийн хугацаагаар шүүх хуралдаан хойшлуулах заалтыг эргэж харах. | Нэгэнт шүүхээс зүйлчлэлийг хүндрүүлэх даалгаврыг өгөөд шүүх хуралдааныг хойшлуулсан тохиолдолд шинээр явагдаж байгаа шүүх хуралдаанд шүүх хөндлөнгийн, хараат бус байх зарчим алдагдахад хүрнэ. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | эрүүгийн хэргийн анхан шатны шүүх | 1 дүгээр зүйлийн 23/36.13 дугаар зүйлийн 6 дахь хэсэг | Шүүхийн шийдвэрийн удиртгал, тогтоох хэсэгт төрийн нууцад хамаарах мэдээлэл агуулагдсан бол хасаж, хэвлэн тодорхой оролцогчид гардуулах. | Шүүхийн шийдвэрийн чухал хэсэг нь шүүх энэ шийдвэр гаргахдаа үндэслэл болгосон нотлох баримт, агуулга, хассан шүүхийн шийдвэр нь тодорхой ойлгомжтой байх зарчимд харшилна. Үүнийг анхаарна уу. |
| 7. | Говьсүмбэр аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх | ЭХХШтХ-ийн 14.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэг | "шүүх энэ хуулийн 14.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт" гэснийг "шүүх энэ хуулийн 14.9 дүгээр зүйлд" гэж өөрчлөх | ЭХХШтХ-ийн 14.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас бусад үндэслэлд яллагдагчид цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авсан тохиолдолд тухайн үндэслэл арилаагүй байхад уг таслан сэргийлэх арга хэмжээг сунгах боломжгүй байна. |
| 8. | Дундговь аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх | ЭХХШтХ-д 34.9.5 гэж нэмэх | "Шүүгдэгчийн өмгөөлөгчийг оролцуулна" гэсний дараа "энэ нь эрүүгийн хариуцлага оногдуулах шүүх хуралдаанд нэгэн адил хамаарна" гэж оруулах | Гэм буруугийн шүүх хуралдаанд шүүгдэгчийг байлцуулахгүйгээр шийдвэрлэж болно гэж заасан. Харин эрүүгийн хариуцлага оногдуулах шүүх хуралдаанд хэрхэх эсэх нь ойлгомжгүй байна. |
| 9. | Дундговь аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх | 39.9 | Хэргийг анхан шатны шүүхэд буцаах | Хэргийг нотолбол зохих байдал нотлогдоогүйгээс хэрэгтэнд ял завшуулах нөхцөл байдал үүсэхээс сэргийлж практикт хэргийг анхан шатны шүүх рүү буцаах тохиолдлууд гарч байна. Энэ тохиолдолд хэрэглэвэл зохих хуулийн заалтыг тухайн зохицуулалтад оруулах шаардлагатай байна. |
| 10. | Орхон аймгийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх | 5 дугаар зүйл | 34.16 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн "хоёр ба түүнээс дээш удаа давтагдаж" гэснийг хасахыг дэмжихгүй. | Шүүх хуралдаан удаа дараа хойшлох сөрөг үр дагавартай. |
| | | 6 дугаар зүйл | ЭХХШтХ-ийн 32.1 дүгээр зүйлийн 10 дахь хэсэг "... Энэ хуульд заасны дагуу оролцогчид танилцуулаагүй, хавтаст хэрэгт хавсаргаагүй өмгөөлөгчийн нотлох баримтыг шүүх хуралдаанаар хэлэлцэхгүй"-ийг хүчингүй болсонд тооцсугай гэснийг дэмжихгүй. | Энэ нь Эрүүгийн хуулийн зорилтод нийцээгүй байна. |
| 11. | Орхон аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх | 34.16.5 | 1/ 33.1 дүгээр зүйлийн 6.13, 6.14-д заасан үндэслэлээр нэмэлт мөрдөн шалгах ажиллагаа явуулах явцад өөр гэмт хэргийн шинжтэй нөхцөл байдал илрэх, өөр этгээдийг тухайн хэрэг хамаарал, оролцоотойгоор татах үндэслэл илэрвэл | Практикт яллах дүгнэлтээр хэрэг хэлэлцэх явцад хамтран оролцсон идэвхтэй үйлдэлтэй хүмүүсийг шалгаагүй орхисон болох нь тогтоогдож, нэмэлт мөрдөн шалгах шаардлага бий болсон. Энэ тохиолдлоор 34.16 дугаар зүйлийн 5-г хэрэглэхэд зөрчилтэй байдал үүссэн. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | хэрхэх вэ? Гэдэг зохицуулалт шаардлагатай.<br>2/ Яллах дүгнэлтийн хүрээ хязгаараас хэтрэх, яллагдагч нарын эрх ноцтой зөрчигдөх | Энэ тохиолдолд хэргийг нэмэлт мөрдөн шалгах ажиллагаа хийлгэхээр буцаах зайлшгүй шаардлага бий болно. Хэргийн бодит байдал бүрэн тогтоогдоогүй болох нь шүүхийн хэлэлцүүлгийн явцад талуудын мэтгэлцээний явцад тогтоогдвол хэрхэх вэ гэдэг зохицуулалт шаардлагатай. |
| | | 1 дүгээр зүйл 20/34.16-9 | Шүүгдэгчийн сонгон авсан өмгөөлөгч хүндэтгэн үзэх шалтгаангүй, ирээгүй… гэдэгт нэг удаагийн тохиолдлоор авч үзээд шүүгдэгчийн өмгөөлөгчөө сонгох эрхийг зөрчиж шууд өмгөөлөгч томилох нь зөрчилтэй харагдаж байна. | Шүүгдэгч нь сонгон авсан өмгөөлөгчөөрөө өмгөөлүүлэх сонирхолтой гэрээ мөнгө төгрөгийн асуудалтай болсон байдаг. Мөн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож хэргийн байдлыг мэдэх болсон өмгөөлөгчтэй шүүх хуралдаанд оролцох сонирхолтой байдаг. Шүүгдэгчийн өмгөөлөгч сонгох эрхийг харгалзан үзэж зохицуулах шаардлагатай. |
| 12. | Сэлэнгэ аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх | 34.16 | Нэмэлт зохицуулалт оруулах | 34.16 дугаар зүйлд заасан үндэслэлээр шүүх хуралдааны хойшилсон хугацаанд шүүхийн даалгасан ажлыг мөрдөгч хийж гүйцэтгээгүй тохиолдолд хэрхэн шийдвэрлэх талаар тодорхой зохицуулалт оруулж өгөх. |
| 13. | Сэлэнгэ аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх | 1 дүгээр зүйл 19/34.16-6 | Шүүх хуралдааныг 60 хүртэл хоногоор хойшлуулсан хугацаанд захирамжийн биелэлт хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хангагдаагүй бол хэргийг прокурорт буцаах | Одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн зохицуулалтаар прокурор 60 хоногт огт ажиллагаа хийхгүй байх тохиолдол удаа дараа гарч байна. Тухайн зүйл, заалтын зорилго нь юу вэ гэдгийг анхаарч хариуцлагажуулах шаардлагатай. Ажиллагаа хийгдэхгүйгээс болж үр нөлөөгүйгээр хэргийн шийдвэрлэлтийн хугацаа сунжирч, иргэд хуулийн байгууллагад итгэх итгэл буурч байна. |
| 14. | Увс аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх | 2 дугаар зүйл | ЭХХШтХ-ийн 14.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт энэ хуулийн 14.9 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.2-аас 2.5 дахь хэсгийг нэмэх | Урьд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах болсон үндэслэл арилаагүй байгаа уг таслан сэргийлэх арга хэмжээний хугацааг сунгаж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулах нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтод нийцнэ. |
| 15. | Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Сум дундын шүүх | 1 дүгээр зүйл 6/14.10-5 дахь хэсэг | “Мөрдөн шалгах ажиллагааны явцад гэмт хэрэг үйлдэж, яллагдагчаар татагдан цагдан хоригдсон бол цагдан хорих хугацааг шинээр тоолно” гэсэн заалтыг тодруулах шаардлагатай. | Зүйл заалтыг дахин тодруулах |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | ЭХХШтХ-ийн 17.2-5 дахь хэсэг | "Гэм буруугаа сайн дураараа хүлээн зөвшөөрч, хэргээ хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлүүлэх хүсэлт гаргасан боловч өмгөөлөгч авахаас татгалзсан яллагдагчид өмгөөлөгч томилж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулах журмыг Монголын Өмгөөлөгчдийн холбооны саналыг харгалзан хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална." | 2024 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн хуульд нэмэлт өөрчлөлт орсон хуулийн заалтын талаар тодруулга авах |
| 16. | Хэнтий аймгийн Бор-Өндөр сум дахь Сум дундын шүүх | ЭХХШтХ-ийн 3.1 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг | Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд ажлын бус цагт таслан сэргийлэх арга хэмжээг хянан шийдвэрлэсэн шийдвэрийг хэрхэн, ямар хугацаанд гаргах | Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд ажлын бус цагт таслан сэргийлэх арга хэмжээг хянан шийдвэрлэсэн шийдвэрийг хэрхэн, ямар хугацаанд гаргах нь тодорхойгүй байна. Жишээ нь олон оролцогчтой, олон хавтастай хэргээс нотлох баримт шинжлэн судалснаас шалтгаалж таслан сэргийлэх арга хэмжээг хэлэлцэх шүүх хуралдаан нь оройтож тарсан тохиолдолд шийдвэрийг даруй гаргах боломжгүй байна. Энэ тохиолдолд баримт үйлдэн цагдан хорих байранд хүргүүлэх зохицуулалт оруулах шаардлагатай байна. |
| | | ЭХХШтХ-ийн 33.1 дүгээр зүйлийн 6.13, 6.14 дэх заалт | Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.16 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт "Шүүх хуралдааны явцад нотлох баримтаар тогтоогдсон хэргийн нөхцөл байдлыг үндэслэн шүүгдэгчид холбогдох хэргийн зүйлчлэлийг хүндрүүлэхээр бол, эсхүл энэ хуулийн 33.1 дүгээр зүйлийн 6.13, 6.14-т заасан гомдлыг шийдвэрлэх зорилгоор шүүх хэргийг хянан хэлэлцэхийг нэг удаа 60 хүртэл хоногоор хойшлуулна." гэж хуульчилсан. Шаардлагатай тохиолдолд нэмж 30 хоногоор сунгах ба энэ хугацаанд шүүх хуралдаан хойшлуулсан шалтгаан нөхцөл арилаагүй бол шүүгдэгчийг цагаатгах эсхүл хэргийг хэрэг бүртгэлт мөрдөн байцаалтад буцаах гэж нэмэлт заалт оруулах, | Шүүх хуралдаан хойшлуулсан шалтгаан нөхцөл арилаагүй тохиолдолд хэргийг цаашид хэрхэн шийдвэрлэх талаар мухардалд орж болох тул зохицуулалт шаардлагатай байна. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | ЭХХШтХ-ийн 5.2 дугаар зүйлийн 6, 7 дахь хэсэг, 5.3 дугаар зүйл, 14.13 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 18.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 31.11 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг | Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авч байгаа тохиолдолд хэрхэн цахим гарын үсэг зурах, мөн хойшлуулшгүй тохиолдолд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг хэрхэн шийдвэрлэх тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах | Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авч байгаа тохиолдолд хэрхэн цахим гарын үсэг зурах, мөн хойшлуулшгүй тохиолдолд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг хэрхэн шийдвэрлэх талаар зохицуулалт шаардлагатай |
| 17. | Баянзүрх, Сүхбаатар Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Тамгын газар | | 1.Оргон зайлах зүйл ангийг нэмэх.<br>2.Өмгөөлөгчийн сахилга, хариуцлагыг дээшлүүлэх.<br>3.Шүүхийн шийдвэрийг олон нийтэд мэдээлэхээс татгалзсан этгээдэд оногдуулах хариуцлагыг тодорхой болгох. | |
| 18. | "Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль"-д орсон нэмэлт өөрчлөлттэй холбоотой бэлтгэл ажлыг хангах чиг үүрэг бүхий Ажлын хэсэг | 1 дүгээр зүйл<br>3/7.3 дугаар зүйлийн 5 дахь хэсэг | Нотлох баримт хуулбарлан авахтай холбоотой шинэ зохицуулалт байна. Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулийн 7.3 дугаар зүйл яллагдагчийн ямар хэрэгт яллагдаж байгаагаа мэдэх эрхтэй холбоотой зохицуулалт байх тул энэ зүйл, хэсэгт энэ агуулгаар, хэсэгт заасан агуулгад нийцэхгүй байна. Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулийн 7.5 дугаар зүйлд заасан мэдээлэл авах эрхтэй холбоотой зүйл, хэсэгт нэмэлтээр оруулах нь зөв байна.<br><br>Эсхүл 7.5 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт "Яллагдагч шинжээч томилсон тогтоол, шинжээчийн дүгнэлт, мөрдөн байцаалт дууссаны дараа хавтаст хэргийн материалтай танилцах эрхтэй." гэж заасныг **"Яллагдагч шинжээч томилсон тогтоол, шинжээчийн дүгнэлт, мөрдөн байцаалт дууссаны дараа хавтаст хэргийн материалтай танилцах, төр, байгууллага, хувь хүний нууцад хамаарахаас бусад нотлох баримтыг хуулбарлаж, хувилж авах эрхтэй." өөрчлөн найруулах боломжтой байна**. | Ингэснээр хуулийг боловсруулахдаа хоорондоо уялдаа холбоотой, дэс дараалал бүхий, агуулгыг товч илэрхийлсэн, нэг санааг илэрхийлж байвал нэг хэсэгт тусгах гэсэн Хууль тогтоомжийн тухай хуулийн шаардлагад нийцнэ. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | 1 дүгээр зүйл 5/12.1 дүгээр зүйлийн 9 дэх заалт | “12.1 дүгээр зүйлийн 9 дэх хэсгийг “... прокурорын мэдэгдэх хуудсыг хүргүүлж болох ба тухайн мэдэгдэх хуудсыг хүргүүлж, хүлээн авсанд тооцно” гэх агуулгатай найруулга хийх. | Цахим хаяг, систем ашиглан мэдэгдэх хуудсыг хүргүүлэх боломжтой байдлаар найруулга хийсэн байх боловч энэ аргаар мэдэгдэх хуудсыг илгээхэд хүргүүлсэнд тооцох эсэх буюу тухайн хүн, хуулийн этгээд хүлээн авсанд тооцох эсэх талаарх зохицуулалт байхгүй байна. Учир нь мэдэгдэх хуудсыг энэ аргаар хүргүүлээд тухайн хүн, хуулийн этгээд хүлээн аваагүй гэх тохиолдолд хэрхэх эсэх нь тодорхойгүй байна. |
| | | 1 дүгээр зүйл 6/14.10 дугаар зүйлийн 5 дахь хэсэг | Энэ заалт нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр нэмэлт, өөрчлөлт оруулсан хуулийн үзэл баримтлалд нийцэхгүй байна. Учир нь одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулиар нэг хэрэгт дахин, эсхүл тусгаарласан, нэгтгэсэн хэрэгт шинээр цагдан хоригдсон бол өмнө нь цагдан хоригдсон хугацааг нийт цагдан хоригдсон хугацаанд оруулан тооцохоор буюу яллагдагчийн эрх зүйн байдлыг дээрдүүлсэн зохицуулалт үйлчилж байна. Энэ нэмэлт, өөрчлөлтийн заалт нь яллагдагчийг хэрэг тус бүр дээр шинээр цагдан хорих хугацааг тоолох нөхцөл байдлыг бий болгож байх ба хамгийн сүүлийн үйлдэлдээ яллагдагчаар татагдсан тохиолдолд өмнө нь цагдан хоригдсон хугацааг хамааруулахгүй буюу яллагдагчийн эрх зүйн байдлыг дордуулж байна. | Учир нь шүүхээр гэм буруутай эсэх нь эцэслэн тогтоогдоогүй байхад яллагдагчийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.10 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан яллагдагчаар цагдан хорих хугацааг дахин дахин шинээр тоолох нөхцөл байдал буюу агуулгаараа хорих ял эдлүүлж буй мэт нөхцөл байдлыг практикт бий болгох эрсдэлтэй бөгөөд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.1 дүгээр зүйлд заасан хуулийн зорилгод нийцэхгүй гэж үзэж байна. |
| | | 1 дүгээр зүйл 2/5.1 дүгээр зүйлийн 2.11 дэх заалт | Хуульчдын холбоо, Өмгөөлөгчдийн холбооноос өөрийн гишүүн өмгөөлөгчдийн нэвтрэн орох системийг хийх шаардлагатай ба хэрэг бүртгэлт, прокурор, шүүх нь уг системд өгөгдөл солилцох боломжтой байж, хэргийн материалыг Өмгөөллийн системд илгээж тодорхой хугацаанд танилцах, татаж авах боломжтой болгох байдлаар өмгөөлөгчийг хэрэгтэй танилцах боломжоор хангаж болно. | Цахим хавтаст хэргийн мэдээллийн систем гэсэн нэгдсэн систем байхгүй байгаа ба нэгдсэн системийг бий болгох төлөвлөгөөгүй байгаа. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | 1 дүгээр зүйл<br>11.11 дүгээр зүйлийн 7 дахь хэсэг | Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчид хоорондоо өгөгдөл, мэдээллийг цахимаар солилцох журмыг Шүүхийн ерөнхий зөвлөл, Улсын ерөнхий прокурор, хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална гэх агуулгатай найруулга хийх. | Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч байгууллага өөр өөрийн системийг хоорондын холбох үндсэн хэрэгцээ шаардлага нь өгөгдөл мэдээлэл солилцох буюу хэргийн материалыг дамжуулж чаддаг байх шаардлагатай. ЭХШХШтХ-н 1.16 дугаар зүйлийн 2-т хэргийн материал, хавтас хэрэг нь шүүхийн цахим платформын шаардлагад нийцсэн байх гэсэн 2024 оны 6 дугаар сарын 06-ны өдөр орсон нэмэлт заалттай уялдаж хэрэгжихийг анхаарах шаардлагатай. |

--o0o-

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ
**ТАГНУУЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР**
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Жуулчны гудамж-3, Утас: 9226 3656, 9226 3017,
Факс: 9226 3656, Вэб хаяг: http://www.gia.gov.mn,
И-мэйл: info@gia.gov.mn

2024.10.31 № ТЕГ01/370
танай 2024.10.17-ны № 1/1332 -т

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН
САЙД О.АЛТАНГЭРЭЛ ТАНАА

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эрүүгийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох үүрэг бүхий байнгын ажиллагаатай ажлын хэсгийн хуралдаанд хэлэлцэх үеэр тус газраас оролцож төрийн нууцад хамаарах мэдээлэл агуулсан прокурор, шүүхийн шийдвэрийг гардуулахтай холбоотой болон бусад саналаа өгсөн.

Бидний өгсөн санал төсөлд туссан байна. Гагцхүү төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "төр, байгууллага, хувь хүний нууц"-аас гадна албаны нууцын талаар нэмж тусгах нь зүйтэй гэж үзэж байна.

ДАРГА П.ОДОНБААТАР

09105593

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ
ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
Самбуугийн гудамж 18, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо,
Улаанбаатар хот, 14201, Утас: 7019-1087,Факс: 7019-1087,
Цахим шуудан: info@police.gov.mn,
Цахим хуудас: www.police.gov.mn

2024.10.22 № 2/348

танай ____________-ны № ____________-т

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ,
ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН,
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН
САЙД О.АЛТАНГЭРЭЛ ТАНАА

Санал хүргүүлэх тухай

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй танилцаж, дараах саналыг тусгуулахаар хүргүүлэв. Үүнд:

1.Төслийн мөн зүйлийн 7 дахь заалтын “14.10 дугаар зүйлийн 14 дэх хэсэг”-ийн “эсэхийг” гэсний дараа “мөрдөгч, прокурорын саналыг үндэслэн” гэж нэмэх;

2.Төслийн мөн зүйлийн 8 дахь заалтын “14.13 дугаар зүйлийн 13 дахь хэсэг”-ийн “баримтыг” гэсний дараа “хүлээн авч” гэж нэмэх;

3.Төслийн мөн зүйлийн 10 дахь заалтын “16.3 дугаар зүйлийн 10 дахь хэсэг”-ийн “сэжигтнээр мэдүүлэг авах ажиллагааг” гэсний дараа “үргэлжлүүлэн” гэж нэмэх;

4.Төслийн мөн зүйлийн 14 дэх заалтын “32.9 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг”-ийн “хувийг гардуулна.” гэснийг хасах;

5.Төслийн мөн зүйлийн 16 дахь заалтын “33.3 дугаар зүйлийн 1.4 дэх заалт”-ыг хасах;

6.Төслийн 2 дугаар зүйлийн “2.12 дахь заалт”-ын “таслан сэргийлэх арга хэмжээ авах үндэслэл болсон мөрдөгч, прокурорын санал, шийдвэрийн үндэслэлд хамаарах баримт, мэдээлэлтэй танилцах” гэснийг хасах;

7.Төслийн мөн зүйлийн “7.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэг”-ийн “шийдвэрийн хувийг авах” гэснийг хасах;

8.Төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалтын “14.13 дугаар зүйлийн 5 дахь хэсэг”-ийн “үндэслэл болохгүй” гэсний дараа “бөгөөд мөрдөн шалгах нууц ажиллагааны баримт нь үүнд хамаарахгүй.” гэж нэмэх;

9.Төслийн мөн зүйлийн 4 дэх заалтын “31.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг”-ийн “хувийг гардуулан өгнө.” гэснийг хасах;

10.Төслийн мөн зүйлийн 6 дахь заалтын “32.2 дугаар зүйлийн 6 дахь хэсэг”-ийн “хамт” гэсний дараа “ажлын” гэж нэмэх;

11.Төсөлд “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 5.1 дүгээр зүйл”-д дор дурдсан агуулгатай хэсэг нэмэх;

“6.Өмгөөлөгч энэ зүйлд заасан үндэслэл журмын дагуу хуулбарлан авсан эсхүл өмгөөллийн үйл ажиллагааны явцад мэдсэн баримт, мэдээллийг бусдад дамжуулах, нууцлалыг задруулахгүй байх үүрэгтэй.”.

12.Төсөлд “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 7.3 дугаар зүйл”-д дор дурдсан агуулгатай хэсэг нэмэх;

“6.Яллагдагч энэ зүйлийн 5-д заасан үндэслэл журмын дагуу хуулбарлаж авсан нотлох баримт, мэдээллийг бусдад дамжуулах, нууцлалыг задруулахгүй байх үүрэгтэй.”.

1522 06 7957

13.Төсөлд "Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 7.5 дугаар зүйл"-д дор дурдсан агуулгатай хэсэг нэмэх;

"5.Яллагдагч шинжээч томилсон тогтоол, шинжээчийн дүгнэлт, мөрдөн байцаалт дууссаны дараа хавтаст хэргийн материалыг хүний эрх, эрх чөлөөг зөрчиж, олон нийтэд түгээх үндэслэл бүхий сэжиг байгаа тохиолдолд мөрдөгч, прокурор нь хуулбарлан өгөхөөс татгалзаж болно.".

14.Төсөлд "Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн Гучдугаар бүлэгт сэжигтний эрх, хувийн байдлыг тогтоох, сэжигтнээс мэдүүлэг авах, хэрэг бүртгэлтийн хэргийг түдгэлзүүлэх, сэргээх зохицуулалт"-ыг нэмж тусгаж, дараах агуулгатай зүйл, заалт нэмэх;

"30.7$^{1}$ дүгээр зүйл.Сэжигтэн

1.Гэмт хэрэг үйлдсэн гэж буруутгагдаж байгаа хүнийг сэжигтэн гэнэ.

30.7$^{2}$ дугаар зүйл.Сэжигтний эрх

1.Сэжигтэн дараах эрхтэй:

1.1.ямар хэрэгт сэжиглэгдэж байгааг мэдэх;

1.2.энэ хуулийн 7.4, 7.5, 7.6, 7.7-д заасан эрхийг тус тус эдлэх;

1.3.хуульд заасан бусад.

30.7$^{3}$ дугаар зүйл.Хувийн байдлыг тогтоох

1.Мөрдөгч сэжигтний хувийн байдлыг тогтоох зорилгоор дараах ажиллагааг явуулна:

1.1.хувийн бичиг баримтыг шалгах, шаардлагатай тохиолдолд хувийн байдлын талаар нэмэлт мэдээлэл авах;

1.2.гэрэл зураг, эсхүл дүрсний, дуу-дүрсний бичлэгээр нүүр царай, биеийн төрх байдлыг бэхжүүлэх;

1.3.хуруу, алганы хээ, эсхүл бусад хэв загварыг бэхжүүлэх;

1.4.шаардлагатай бол шинжилгээнд зориулж биеэс нь биологийн дээж авах;

1.5.биед үзлэг хийх;

1.6.харьцуулсан шинжилгээ хийх.

2.Хувийн байдлыг нь тогтооход саад учруулбал мөрдөгч холбогдох хуульд заасан үндэслэл, журмын дагуу албадлага хэрэглэнэ.

3.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хувийн байдлыг тогтоосон мэдээллийг хавтаст хэрэгт тусгана.

30.7$^{4}$ дугаар зүйл.Сэжигтнээс мэдүүлэг авах

1.Мөрдөгч сэжигтнээс мэдүүлэг авахын өмнө түүнд ямар хэрэгт холбогдуулан мэдүүлэг авч байгаа талаар танилцуулж, дараах эрхийг тайлбарлана:

1.1.өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх;

1.2.өөрийгөө өмгөөлөх, өмгөөлөгч сонгон авах;

1.3.өмгөөлөгчтэй ганцаарчлан уулзах, өмгөөлөгч байлцуулан мэдүүлэг өгөх;

1.4.эх хэлээрээ, эсхүл өөрийн сайн мэдэх хэлээр мэдүүлэг өгөх;

1.5.орчуулагч, хэлмэрчийн туслалцааг авах;

1.6.мэдүүлэг өгөхөөс татгалзах;

1.7.мөрдөгч, прокурор, орчуулагч, хэлмэрчээс татгалзах;

1.8.энэ хуулийн Долдугаар бүлэгт заасан бусад эрх.

2.Сэжигтнээс мэдүүлэг авахад энэ хуулийн 25.1, 25.2, 25.3 дугаар зүйлд заасан журмыг баримтална.

3.Сэжигтний сонгон авсан өмгөөлөгч 2 цагийн дотор хүрэлцэн ирээгүй, эсхүл өмгөөлөгч авахаас татгалзсан бол энэ хуулийн 5.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу өмгөөлөгч оролцуулна.

4.Баривчлагдсан өсвөр насны сэжигтнээс мэдүүлэг авахад энэ хуулийн 25.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 25.3 дугаар зүйл, энэ зүйлд заасан журмыг баримтална.

30.18.Хэрэг бүртгэлтийн хэргийг түдгэлзүүлэх, сэргээх

1.Прокурор нь мөрдөгчийн саналыг үндэслэлтэй гэж үзвэл дараах тохиолдолд хэрэг бүртгэлтийг түдгэлзүүлнэ:

1.1.хэрэг бүртгэлтийн хэрэгт хийгдвэл зохих бүхий л ажиллагаа хийгдсэн болovч яллагдагчаар татагдвал зохих этгээд нь тогтоогдоогүй бол;

1.2.яллагдагчаар татагдвал зохих этгээд Монгол Улсаас гарч явсан нь тогтоогдсон бол;

1.3.зайлшгүй шаардлагатай гэрч, хохирогч хаана байгаа газар нь тогтоогдохгүй бол;

1.4.өөр хэргийг шийдвэрлэхгүйгээр хэргийг шийдвэрлэх боломжгүй бол.

2.Хэрэг бүртгэлтийн хэргийг түдгэлзүүлэхийн өмнө мөрдөгч нь гүйцэтгэж болох бүх ажиллагааг явуулах, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг олж илрүүлэх бүх арга хэмжээг авах үүрэгтэй.

3.Хэрэг бүртгэлтийн хэргийг түдгэлзүүлэх тухай тогтоолд энэ хуулийн 31.14 дүгээр зүйлийн 4 дэх зүйлийг баримтална.

4.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан нөхцөл арилсан, эсхүл нэмэлт мөрдөн шалгах ажиллагаа явуулах шаардлагатай бол хэрэг бүртгэлтийг сэргээх тухай прокурор тогтоол гаргана.

5.Хэрэг бүртгэлтийн хэргийг сэргээх тухай тогтоолд энэ хуулийн 31.14 дүгээр зүйлийн 6 дахь зүйлийг баримтална.".

15.Төсөлд "Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31.10, 31.11 дүгээр зүйл"-ийг тус тус хасах;

16.Төсөлд "Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг"-т дор дурдсан агуулгатай заалт нэмэх;

"1.4.яллагдагч Монгол Улсаас гарч явсан нь тогтоогдсон бол.".

17.Төсөлд "Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31.13 дугаар зүйл"-д дор дурдсан агуулгатай хэсэг нэмэх;

"7.Энэ хуулийн 32.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан хугацаа нь мөрдөн байцаалтын хугацаанд тооцогдохгүй.".

Хүлээн авч, танилцана уу.

Хүндэтгэсэн,

ТЭРГҮҮН ДЭД ДАРГА,
БРИГАДЫН ГЕНЕРАЛ Ц.НЯМ-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
**ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗАР**

Бага тойруу 13/1, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 63 32, Факс: (976-11) 32 99 33,
Цахим шуудан: info@cd.gov.mn,
Цахим хуудас: www.cd.gov.mn

2024.11.04 № 01/2786
танай 2024.10.17-ны № 1/1332-т

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН,
ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН,
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН
САЙД О.АЛТАНГЭРЭЛ ТАНАА

Санал өгөх тухай

Таны 2024 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 1/1332 тоот албан бичгээр ирүүлсэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, холбогдох материалтай танилцаад дараах саналтай байна. Үүнд:

1.Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.3-т “үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих” гэж заасан шаардлагад нийцүүлэн хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1/5.1 дүгээр зүйлийн 2.7 дахь заалтын “хуулбарлан” гэсний өмнө “нотлох баримт” гэж, 6/14.10 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн “гэмт хэрэг” гэсний өмнө “дахин” гэж тус тус нэмэх.

Мөн Төрийн болон албаны нууцын тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд нийцүүлэн хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 3/7.3 дугаар зүйлийн 5 дахь хэсэг болон 3 дугаар зүйлийн 2/7.5 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн “төр, байгууллага, хувь хүний нууцад” гэснийг “төрийн болон албаны нууц, хүний хувийн мэдээлэлд” гэж өөрчлөх.

2.Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 8/14.13 дугаар зүйлийн 14 дэх хэсэгт эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч үед “тодорхой үйл ажиллагаа явуулах, албан үүргээ биелүүлэхийг түдгэлзүүлэх” таслан сэргийлэх арга хэмжээг авах, өөрчлөх, хүчингүй болгох, хүсэлт болон хугацааг сунгасан шүүхийн шийдвэрийг цахим мэдээллийн сүлжээгээр шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад даруй хүргүүлэх гэж шинээр тусгасан байна.

Тус зохицуулалт нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.4 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт “Тодорхой үйл ажиллагаа явуулах, албан үүргээ биелүүлэхийг түдгэлзүүлэх таслан сэргийлэх арга хэмжээний хугацаа дууссан, эсхүл уг арга хэмжээг хүчингүй болгосон, өөрчилсөн шүүхийн шийдвэр гарсан бол прокурор, эсхүл мөрдөгч уг шийдвэрийг яллагдагч болон холбогдох байгууллага, хуулийн этгээдэд даруй хүргүүлнэ.” гэж заасантай нийцэхгүй байна.

Түүнчлэн, 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулиар тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.3-т “хязгаарлалт тогтоох тухай шүүгчийн захирамж”-ийг хэрэгжүүлэхээр нэмэлт орсон бөгөөд 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Өөрөөр хэлбэл эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг сэжигтнийг баривчлах, яллагдагчийг цагдан хорих, хязгаарлалт тогтоох тухай шүүгчийн захирамжийг үндэслэн гүйцэтгэхээр хуульчилсан ба харин тодорхой үйл ажиллагаа явуулах, албан үүргээ биелүүлэхийг түдгэлзүүлэх таслан сэргийлэх арга хэмжээг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хэрэгжүүлэх нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн үзэл баримтлалд нийцэхгүй байх тул Хууль

1501077153

тогтоомжийн 29 дүгээр зүйлийн 29.1-д заасан хууль тогтоомжийн төслийн агуулгад тавигдах шаардлагад нийцүүлэн хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 8/14.13 дугаар зүйлийн 14 дэх хэсгийн "1.2," гэснийг хасах.

3.Улсын Их Хурлын 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 153 дугаар зүйлийн 153.1 дэх хэсэгт "Хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн этгээд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад хүрэлцэн ирээгүй нь шүүхийн шийдвэрийг хүлээн авах, эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хэрэг үүсгэхэд саад болохгүй" гэж, 185 дугаар зүйлийн 185.1 дэх хэсэгт "Холбогдох этгээд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад хүрэлцэн ирээгүй нь албадлагын арга хэмжээ авсан шүүхийн шийтгэх тогтоолыг хүлээн авахад саад болохгүй" гэж тус тус нэмэлт оруулсан бөгөөд тус хуулийн дагуу шүүхээс ял, албадлагын арга хэмжээ авагдсан боловч оргон зайлсан, шийдвэрээ гардаж аваагүй, оршин суух хаяг нь тодорхойгүй 840 хүний материалыг хүлээн авч, эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдаж байна.

Гэтэл хуулийн төслийн 1 зүйлийн 17/34.9 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт шинээр тусгасан зохицуулалтад шүүгдэгч шүүхийн хэлэлцүүлэгт мэдүүлэг өгөх эсэх эрхээ эдэлсний дараа хүндэтгэн үзэх шалтгаангүй шүүх хуралдаанд оролцохоос санаатай зайлсхийсэн тохиолдолд түүнийг эзгүйд шүүх хуралдааныг үргэлжлүүлэн явуулж, шүүгдэгч гэм буруутай эсэхийг эцэслэн шийдвэрлэж болохоор тусгасан нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хүндрэл учруулах, ачаалал нэмэх тул дахин нягталж найруулах, эсхүл хасах.

Түүнчлэн, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.9 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт "Шүүх хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй шүүгдэгчийг албадан ирүүлэх, түүнд энэ хуульд заасан таслан сэргийлэх арга хэмжээ авах, өөрчлөх шийдвэр гаргаж болно" гэж заасан байгааг анхаарах.

4.Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 24/39.1 дүгээр зүйлийн 9 дэх хэсэгт шинээр тусгасан зохицуулалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1-д "... хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна" гэж, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 39.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт "Шүүх давж заалдсан гомдол, эсэргүүцэлд заасан асуудлаар хязгаарлахгүй ба ..." гэж тус тус заасантай зөрчилдөж байх тул хасах.

5.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 3 дугаар зүйлд "Баривчлах шийтгэл оногдуулсан шүүхийн шийдвэрийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд нийслэлд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, аймаг, суманд цагдаагийн байгууллага гүйцэтгэнэ. Цагдаагийн байгууллага баривчлах шийтгэл оногдуулсан шүүхийн шийдвэрийг биелүүлэх чиг үүргийг энэ зүйлд заасан хугацааны дотор үе шаттайгаар шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагад шилжүүлнэ." гэж заасныг хэрэгжүүлэхэд санхүүгийн асуудлыг шийдвэрлэх, бэлтгэл ажлыг хангах шаардлагатай байх тул "2025 оны" гэснийг "2027 оны" гэж өөрчлөх саналтай байгааг илтгэн танилцуулъя.

Хүндэтгэсэн,

ДАРГА,
ХУРАНДАА Б.НАНДИНБОЛОР

9060989 СБТ 21269 9023020393

# ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГУУДААС ИРҮҮЛСЭН САНАЛЫН ТОВЬЁГ

| д/д | Санал ирүүлсэн байгууллага | Ирүүлсэн санал | Саналыг тусгасан байдал |
|---|---|---|---|
| 1. | Монгол Улсын дээд шүүх<br>2024.11.01<br>01/5220 | Таны 2024 оны 1/1332 дугаартай албан бичгээр санал авахаар ирүүлсэн "Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" хуулийн төслийг Монгол Улсын Дээд шүүхийн нийт шүүгчийн 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж, гаргасан саналыг нэгтгэн Шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.3 дахь заалтад заасны дагуу хавсралтаар хүргүүлэв. Үүнд:<br>1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 7/14.10 дугаар зүйлийн 14 дэх хэсэг:<br>- Төслийн заалттай холбогдуулан ЭХХШТХ-ийн 14.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, мөн хуулийн 3.1 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт нэмэлт өөрчлөлт оруулах;<br>- Цагдан хорих хугацааг сунгах журмыг зохицуулсан ЭХХШТХ-ийн 14.10 дугаар зүйлийн 2 дах хэсэгт "Шүүх энэ хуулийн 14.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан..." гэснийг Шүүх энэ хуулийн 14.9 дүгээр зүйлд заасан..." гэж өөрчлөх,<br>- Мөн ЭХХШТХ-ийн 3.1 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт "Шүүх энэ хуулийн 14.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.3, 1.5 дахь заалт, 31.5 дугаар зүйлд заасан асуудлыг хянан шийдвэрлэх ажиллагааг хуанлийн өдөр бүр шөнийн цагаас бусад цагт тасралтгүй хэрэгжүүлнэ." гэсэн заалтад 31.4 заалтыг нэмэх шаардлагатай.<br>2. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 10/16.3 дугаар зүйлийн 10-11 дэх хэсэг:<br>- Гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүнийг гэрчээр дуудаж болохгүй талаар нэмж тусгах.<br>3. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 11/16.14 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг:<br>- Төслийн заалтыг Монгол Улсын дээд шүүхийн Нийт шүүгчийн хуралдааны 2023 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн "Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг зөв хэрэглэх тухай" 31 дүгээр тогтоолын 6 дахь хэсэгт заасан цахим баримтыг бэхжүүлэх, хадгалах, шилжүүлэх, цахим баримтын аюулгүй байдлыг хамгаалахтай холбоотой заалтад нийцүүлэх.<br>4. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 17/34.9 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг:<br>- Энэхүү заалт нь ЭХХШТХ-ийн 34.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан "Анхан шатны журмаар хэргийг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд шүүгдэгчийг оролцуулна. Шүүгдэгч ирээгүй нь шүүх хуралдааныг хойшлуулах үндэслэл болно." гэсэн заалттай зөрчилдөж байх тул: | Саналыг тусгасан.<br>Харин Монгол Улсын Их Хурлын 2024 оны 18 дугаар тогтоол болон хуулийн төслийн үзэл баримтлалд тусгагдаагүй асуудлын талаар ирүүлсэн саналыг тусгаагүй болно. |

| | | | |
|---|---|---|---|
| | | 1. Уг заалтыг 2002 оны ЭБШХ-ийн 240 дүгээр зүйлийн 240.2 дахь хэсэгт заасан агуулгаар өөрчлөн найруулах,<br>2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 240 дүгээр зүйл. Шүүгдэгч шүүх хуралдааны ажиллагаанд оролцох<br>240.2. Шүүгдэгч нь Монгол Улсын хилийн гадна байгаа бөгөөд шүүхэд хүрэлцэн ирэхээс зайлсхийсэн бол хэргийг түүний байхгүйд хэлэлцэж болно.<br><br>2. 2002 оны Эрүүгийн хуулийн 261 дүгээр зүйлийг сэргээн хуульчлах.<br>2002 оны Эрүүгийн хуулийн 261 дүгээр зүйл.Прокурорын хяналт, шүүх, цагдан хорих, хорих ангиас оргох<br>261.1.Таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан прокурорын хяналт, шүүх, цагдан хорих, хорих ангиас оргосон, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүн таслах ажиллагаанаас зориуд зайлсхийсэн бол гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.<br><br>5. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 18/34.13 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:<br>- Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан зохицуулалттай агуулга нь давхардаж байх тул хасах.<br>Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.13 дугаар зүйл.Шүүх хуралдаанд хохирогч, гэрч, шинжээч хүрэлцэн ирээгүйн холбогдол<br>1.Шүүх хуралдаанд хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, түүний хууль ёсны төлөөлөгч, гэрч, шинжээч хүрэлцэн ирээгүй бол шүүх хуралдаан даргалагч түүнийг оролцуулахгүйгээр хэрэг хэлэлцэж болох эсэхийг улсын яллагч, шүүгдэгч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчөөс асууж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үргэлжлүүлэх, эсхүл хойшлуулах тухай асуудлыг шийдвэрлэнэ.<br>6. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 19/34.16 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт дараах саналтай байна.<br>- Шүүх хуралдааныг хойшлуулсан хугацаанд прокурор даалгасан ажиллагааг бүрэн биелүүлээгүй бол хэргийг прокурорт буцаана гэсэн агуулгаар өөрчлөх.<br>7. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 23/36.13 дугаар зүйлийн 5, 6 дахь хэсэг:<br>- Дэмжихгүй. Төрийн нууцад хамаарах мэдээлэл агуулсан шүүхийн шийдвэрийг прокурор, оролцогчдод бүрэн эхээр нь гардуулж өгөх агуулгаар саналын томьёоллыг өөрчлөх саналтай. | |

| | | | |
|---|---|---|---|
| | | Тайлбар: Монгол Улсын нэгдэж орсон Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 14 дүгээр зүйлийн 1, 3 (а), 5 дахь заалт болон Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14 дэх хэсэг, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2024 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн хуулийн үзэл баримтлалд нийцэхгүй байна. Энэ асуудлыг Төрийн нууц мэдээлэл агуулсан шүүхийн шийдвэрийг боловсруулах аргачлал, журмын талаар Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2021 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн 29 дүгээр тогтоолоор баталсан анхан, давж заалдах шатны шүүхийн шийдвэр боловсруулах аргачлал, журамд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэх боломжтой.<br>8. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлийн /5.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “хохирогч,” гэсний дараа “гэрч,” гэж нэмэх,<br>- Дэмжихгүй. ЭХХШТХ-ийн 9.6 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт зааснаар гэрч нь өмгөөлөгчтэй мэдүүлэг өгөх эрхтэй. Харин гэрчээс мэдүүлэг авахдаа заавал өмгөөлөгчөөр хангахыг мөрдөгчид үүрэг болгож болохгүй. Учир гэрч нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эрх ашиг нь хөндөгдсөн оролцогч биш.<br>9. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлийн /34.1 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийн “болохгүй.” гэсний дараа “Шүүгдэгч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй нь шүүх хуралдаан хойшлуулах үндэслэл болохгүй.” гэж нэмэх,<br>- Дэмжихгүй. Хуулийн төслийн 34.9 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгтэй холбогдуулж өгсөн тайлбарыг үзэх.<br>10. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 1/5.1 дүгээр зүйлийн 2.6 дахь заалт:<br>- Хуулийн 7.3 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасантай уялдуулан Төр, байгууллага, хувь хүний нууцад хамаарахаас бусад нотлох баримтыг хуулбарлаж, хувилж авах эрхтэй гэсэн агуулгаар өөрчлөн найруулах.<br>11. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн /34.12 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “болно.” гэснийг “болох ба энэ талаарх мэдээллийг харьяалах прокурорын байгууллага, Монголын Өмгөөлөгчдийн холбоонд даруй хүргүүлнэ.” гэж өөрчлөх,<br>- Шүүх хуралдааны дэг болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн оролцогчид хариуцлага хүлээлгэх асуудлыг зохицуулсан Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн холбогдох заалтад өөрчлөлт оруулах талаар УДШ-ээс 2024 оны 4 дүгээр сарын 25-нд хууль санаачлагчид хүргүүлсэн саналыг хуулийн төсөлд нэмж тусгах. | |

| | | | |
|---|---|---|---|
| 2. | Шүүхийн ерөнхий зөвлөл<br>2024.11.07<br>01/1830 | Таны 2024 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 1/1332 дугаар албан бичигтэй танилцлаа. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгуулахаар ирүүлсэн саналыг нэгтгэн, хүргүүлж байна.<br>1.Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх<br>- 1 дүгээр зүйл 17/34.9 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийг өөрчлөн найруулах эсхүл хасах.<br>Шүүх хуралдаанд оролцсон атлаа шүүх хуралдаанаас зайлсхийх тохиолдол бага. Нөгөө талаас тухайн тохиолдол үүсэхэд зөвхөн гэм буруутай эсэхийг шийдвэрлээд эрүүгийн хариуцлагын хуралдаан явуулахгүйгээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх эсхүл шүүх хуралдааныг хойшлуулж орхихыг зөвшөөрөх боломжгүй. Мөн шүүгдэгч анхнаасаа өмгөөлөгч аваагүй бол заавал өмгөөлөгч оролцуулна гэдэг нь шүүхийн хувьд хэрэгжүүлэх боломжгүй, маргаан дагуулах асуудал болно.<br>- 1 дүгээр зүйл 18/34.13 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг өөрчлөн найруулах<br>2.Хохирогч бичгээр хүсэлт гаргасан атлаа шүүх хуралдаанд хүндэтгэх шалтгаангүйгээр ирээгүй эсхүл оролцохоос татгалзсан бол шүүх хуралдааныг хойшлуулахгүй. 3. "Шүүх урьдчилсан хэлэлцүүлгээр ЭХХШТХ-ийн 33.1 дүгээр зүйлийн 6.10 дахь заалтад зааснаар прокурор, оролцогчийн санал, хүсэлтийг хангасан боловч шүүх хуралдаанд дуудагдсан этгээд ирээгүй тохиолдолд талуудын хүсэлтийг харгалзан шүүх хуралдааныг хойшлуулах эсэхийг шүүх бүрэлдэхүүн шийдвэрлэнэ." гэх санал. Ингэснээр шүүх хуралдаанд удаа дараа хойшлох нөхцөл байдлыг бууруулах, оролцогч, талууд шүүх хуралдаанд дуудах хүнийг урьдчилан шийдвэрлүүлэх болон бусад хуульд заасан үндэслэл, журмыг мөрдөх нөхцөл хангагдана.<br>- 3 дугаар зүйл 9/34.8 дугаар зүйлийн 1-2 дахь хэсэг.<br>1 дэх хэсгийг өөрчлөн найруулах, 2 дахь хэсгийг хасах 1. "Хохирогч бичгээр хүсэлт гаргасан эсхүл шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгээр ЭХХШТХ-ийн 33.1 дүгээр зүйлийн 6.10 дахь заалтад зааснаар прокурор, оролцогчийн санал, хүсэлтийг хангасан бол...оролцуулна." гэж өөрчлөх 18/34.13 дугаар зүйлийн саналын үндэслэл нэгэн адил хамаарна. Мөн шүүх хуралдаанд дуудагдсан хүн ирээгүйн холбогдлыг 34.13 дугаар зүйлд нэг мөр зохицуулан шийдвэрлэх боломжтой тул 34.8 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг хасах.<br>- 5 дугаар зүйл 34.16 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн "2 ба түүнээс дээш удаа давтагдаж" гэснийг хасах өөрчлөх / хасах боломжгүй/<br>2 ба түүнээс дээш удаа давтагдаж гэснийг "3 ба түүнээс дээш удаа давтагдаж" гэж өөрчлөх.<br>Анх шүүх хуралдаан удаа дараа хойшлогддог талаарх судалгааны үндсэн дээр тухайн зохицуулалтыг хийсэн тул дахин хасах үндэслэлгүй гэж үзэж байна. Харин давтамжийг нь өөрчлөх боломжтой.<br><br>2.Багануур дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх<br>- 1 дүгээр зүйл 20/34.16 дугаар зүйлийн 9 дэх хэсэг. | Саналыг тусгасан.<br>Харин Монгол Улсын Их Хурлын 2024 оны 18 дугаар тогтоол болон хуулийн төслийн үзэл баримтлалд тусгагдаагүй асуудлын талаар ирүүлсэн саналыг тусгаагүй болно. |

| | | | |
|---|---|---|---|
| | | Шүүгдэгч нь томилсон өмгөөлөгчөөс хуульд заасан үндэслэл тогтоогдоогүй бол татгалзах эрхгүй гэдгийг хуульд тодорхой тусгах.<br>Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.16 дугаар зүйлийн 9 дэх заалтыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.16 дугаар зүйлийн 3 дахь хэсэгтэй уялдуулах. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгчөөсөө олон дахин татгалзаж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд удаа дараа саад учруулах байдлыг арилгах зорилготой.<br><br>3.Баян-Өлгий аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх<br>- 1 дүгээр зүйл 17/34.9 дүгээр зүйлийн 5 хэсэг.<br>"Яллагдагч, шүүгдэгч шүүхээс оргон зайлсан бол түүний эзгүйд хэргийг өмгөөлөгчийг оролцуулан шийдвэрлэх" гэж нэмэх. Тайлбар ирүүлээгүй.<br><br>4.Баянхонгор аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх<br>- ЭХХШТХ-ийн 39.9 дүгээр зүйлийн 1-ийн 1.3. ЭХХШТХ-ийн 39.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.3-д " ...энэ хуулийн 33.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 34.7 дугаар зүйлийн 6.2-т заасан үндэслэлээр анхан шатны шүүхийн шийдвэрийг бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг хүчингүй болгож, хэргийг прокурорт, эсхүл дахин хэлэлцүүлэхээр шүүхэд буцаах..." гэж байсан заалтыг эргэж оруулах. Давж заалдах шатны шүүх нь ЭХХШТХ-ийн 39.5-д заасныг анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, тус шүүхээр дамжуулан хэргийг нэмэлт мөрдөн байцаалтад буцааж шийдвэр гаргах боломжгүй болсон. Энэ заалтыг хүчингүй болгосноор хэрэг шийдвэрлээд шийдвэр гаргахад баримтлах тодорхой заалтгүйгээс одоо 39.5-ийг баримталж байгааг анхаарах.<br>- 38.2 дугаар зүйлийн 3. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хугацаа хэтрүүлж гаргасан гомдлыг шүүх хүлээж авахгүй. Бусад тохиолдолд анхан шатны шүүх гомдол, эсэргүүцлийг буцаах, хүлээн авахаас татгалзахыг хориглоно… гэж өөрчлөн найруулах. Анхан шатны шүүх нь давж заалдах гомдол, эсэргүүцлийг хуульд заагаагүй бусад үндэслэлээр буюу албан бичгээр гомдол эсэргүүцлийг хүлээн авахгүй буцаасан тохиолдол гарсан байна.<br>- 9.6 дугаар зүйлийн дараа $9.6^1$ заалт. Гэмт хэрэгт сэрдэгдэх хангалттай үндэслэл байгаа хүнийг гэрчээр байцаахыг хориглоно… гэж нэмэх сэжигтнээр тооцох, тогтоол гаргах эрх зүйн үндсийг нэмэх. Гэмт хэрэгт сэрдэгдэж байгаа хүнийг анх гэрчээр байцааж мэдүүлэг авах нь хууль зөрчиж, улмаар нотлох баримтаар үнэлэхгүй, тооцохгүй байх үндэслэл болж байна. Хуульд сэжигтэн гэсэн статус тодорхойгүй байх тул сэжигтний эрх зүйн байдлыг тодорхой болгож, эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татахаас өмнө сэжигтнээр тооцон мэдүүлэг авах ажиллагааг тодорхой болгох. | |

| | | | |
|---|---|---|---|
| | | - 38.1-ийн 1-т "... улсын яллагч гэснийг прокурор..." гэж өөрчлөх. Анхан шатны шүүх хуралдаанд оролцсон улсын яллагч эсэргүүцэл бичих боломжгүй буюу хүндэтгэн үзэх шалтгаан тохиолдоход өөр прокурор эсэргүүцэл бичих боломжтой болно.<br><br>5.Говь-Алтай аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх<br>- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 39.9 дүгээр зүйл. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд 1.3 дахь заалт нэмж, уг заалтад энэ хуулийн 39.5 дугаар зүйлд заасан үндэслэлээр анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолыг хүчингүй болгосон тохиолдолд хэргийг анхан шатны шүүхээр дахин хэлэлцүүлэхээр буцаах зохицуулалтыг тусгах саналтай байна. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 39.5 дугаар зүйлд давж заалдах шатны шүүхээс анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгох, өөрчлөх үндэслэлийг зохицуулсан бөгөөд ийнхүү өөрчилж, хүчингүй болгосон тохиолдолд хэргийг хэрхэх нь зохицуулалтгүй үлдсэн. Түүнчлэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 39.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт давж заалдах шатны шүүх гомдол эсэргүүцлийг хянан шийдвэрлэхдээ тухайн хэргийн бүх ажиллагаа шийдвэрийг бүхэлд нь хянахаар зохицуулсан. Тиймээс энэ эрх хэмжээнийхээ хүрээнд анхан шатны шүүхийн бүх ажиллагаа, шийдвэрийг хянаж, зөвтгөх боломжтой байх шаардлагатай.<br>- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.1 дүгээр зүйл. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд 33.1 дүгээр зүйлийн 12 дахь заалтын "Шүүхийн шатнаас урьдчилсан хэлэлцүүлэг рүү хэрэг буцаахгүй" гэснийг "Анхан шатны журмаар хэргийг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанаас урьдчилсан хэлэлцүүлэг рүү хэрэг буцаахгүй" гэж өөрчлөх. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд анхан шатны журмаар эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагааг тодорхой үе шатуудад хуваагаагүй, шүүхийн шат гэсэн нэр томьёог тухайн хуульд тайлбарлаагүйгээс тодорхойгүй байдал бий болсон.<br><br>6.Говь-Алтай аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх<br>- 1 дүгээр зүйл 19/34.16 дугаар зүйлийн 6 дахь хэсэг. 60 хүртэл хоногийн хугацаагаар шүүх хуралдаан хойшлуулах заалтыг эргэж харах. Нэгэнт шүүхээс зүйлчлэлийг хүндрүүлэх даалгаврыг өгөөд шүүх хуралдааныг хойшлуулсан тохиолдолд шинээр явагдаж байгаа шүүх хуралдаанд шүүх хөндлөнгийн, хараат бус байх зарчим алдагдахад хүрнэ.<br>- 1 дүгээр зүйлийн 23/36.13 зүйлийн дугаар зүйлийн 6 дахь хэсэг. Шүүхийн шийдвэрийн удиртгал, тогтоох хэсэгт төрийн нууцад хамаарах мэдээлэл агуулагдсан бол хасаж, хэвлэн тодорхой оролцогчид гардуулах. Шүүхийн шийдвэрийн чухал хэсэг нь шүүх энэ шийдвэр гаргахдаа үндэслэл болгосон нотлох баримт, агуулга, хассан шүүхийн шийдвэр нь тодорхой ойлгомжтой байх зарчимд харшилна. Үүнийг анхаарна уу. | |

7.Говьсүмбэр аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх

- ЭХХШТХ-ийн 14.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэг. "шүүх энэ хуулийн 14.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт" гэснийг "шүүх энэ хуулийн 14.9 дүгээр зүйлд" гэж өөрчлөх. ЭХХШТХ-ийн 14.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас бусад үндэслэлд яллагдагчид цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авсан тохиолдолд тухайн үндэслэл арилаагүй байхад уг таслан сэргийлэх арга хэмжээг сунгах боломжгүй байна.

8.Дундговь аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх

- ЭХХШТХ-д 34.9.5 гэж нэмэх. “Шүүгдэгчийн өмгөөлөгчийг оролцуулна" гэсний дараа "энэ нь эрүүгийн хариуцлага оногдуулах шүүх хуралдаанд нэгэн адил хамаарна" гэж оруулах. Гэм буруугийн шүүх хуралдаанд шүүгдэгчийг байлцуулахгүйгээр шийдвэрлэж болно гэж заасан. Харин эрүүгийн хариуцлага оногдуулах шүүх хуралдаанд хэрхэх эсэх нь ойлгомжгүй байна.

9.Дундговь аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх

- 39.9.Хэргийг анхан шатны шүүхэд буцаах. Хэргийг нотолбол зохих байдал нотлогдоогүйгээс хэрэгтэнд ял завшуулах нөхцөл байдал үүсэхээс сэргийлж практикт хэргийг анхан шатны шүүх рүү буцаах тохиолдлууд гарч байна. Энэ тохиолдолд хэрэглэвэл зохих хуулийн заалтыг тухайн зохицуулалтад оруулах шаардлагатай байна.

10.Орхон аймгийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх

- 5 дугаар зүйл. 34.16 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн "хоёр ба түүнээс дээш удаа давтагдаж” гэснийг хасахыг дэмжихгүй. Шүүх хуралдаан удаа дараа хойшлох сөрөг үр дагавартай.
- 6 дугаар зүйл. ЭХХШТХ-ийн 32.1 дүгээр зүйлийн 10 дахь хэсэг "... Энэ хуульд зааснь дагуу оролцогчид танилцуулаагүй, хавтаст хэрэгт хавсаргаагүй өмгөөлөгчийн нотлох баримтыг шүүх хуралдаанаар хэлэлцэхгүй"-ийг хүчингүй болсонд тооцсугай гэснийг дэмжихгүй. Энэ нь Эрүүгийн хуулийн зорилтод нийцээгүй байна.

11.Орхон аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх

- 34.16.5. 1/33.1 дүгээр зүйлийн 6.13. 6.14-д заасан үндэслэлээр нэмэлт мөрдөн шалгах ажиллагаа явуулах явцад өөр гэмт хэргийн шинжтэй нөхцөл байдал илрэх, өөр этгээдийг тухайн хэрэг хамаарал, оролцоотойгоор татах үндэслэл илэрвэл хэрхэх вэ? гэдэг зохицуулалт шаардлагатай. 2/ Яллах дүгнэлтийн хүрээ хязгаараас хэтрэх, яллагдагч нарын эрх ноцтой зөрчигдөх.

Практикт яллах дүгнэлтээр хэрэг хэлэлцэх явцад хамтран оролцсон идэвхтэй үйлдэлтэй хүмүүсийг шалгаагүй орхисон болох нь тогтоогдож, нэмэлт мөрдөн шалгах шаардлага бий

| | | | |
|---|---|---|---|
| | | болсон. Энэ тохиолдлоор 34.16 дугаар зүйлийн 5-г хэрэглэхэд зөрчилтэй байдал үүссэн. Энэ тохиолдолд хэргийг нэмэлт мөрдөн шалгах ажиллагаа хийлгэхээр буцаах зайлшгүй шаардлага бий болно. Хэргийн бодит байдал бүрэн тогтоогдоогүй болох нь шүүхийн хэлэлцүүлгийн явцад талуудын мэтгэлцээний явцад тогтоогдвол хэрхэх вэ гэдэг зохицуулалт шаардлагатай.<br>- 1 дүгээр зүйл 20/34.16- 9. Шүүгдэгчийн сонгон авсан өмгөөлөгч хүндэтгэн үзэх шалтгаангүй, ирээгүй... гэдэгт нэг удаагийн тохиолдлоор авч үзээд шүүгдэгчийн өмгөөлөгчөө сонгох эрхийг зөрчиж шууд өмгөөлөгч томилох нь зөрчилтэй харагдаж байна. Шүүгдэгч нь сонгон авсан өмгөөлөгчөөрөө өмгөөлүүлэх сонирхолтой гэрээ мөнгө төгрөгийн асуудалтай болсон байдаг. Мөн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож хэргийн байдлыг мэдэх болсон өмгөөлөгчтэй шүүх хуралдаанд оролцох сонирхолтой байдаг. Шүүгдэгчийн өмгөөлөгч сонгох эрхийг харгалзан үзэж зохицуулах шаардлагатай.<br><br>12.Сэлэнгэ аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх<br>- 34.16. Нэмэлт зохицуулалт оруулах. 34.16 дугаар зүйлд заасан үндэслэлээр шүүх хуралдааны хойшилсон хугацаанд шүүхийн даалгасан ажлыг мөрдөгч хийж гүйцэтгээгүй тохиолдолд хэрхэн шийдвэрлэх талаар тодорхой зохицуулалт оруулж өгөх.<br><br>13.Сэлэнгэ аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх<br>- 1 дүгээр зүйл 19/34.16-6. Шүүх хуралдааныг 60 хүртэл хоногоор хойшлуулсан хугацаанд захирамжийн биелэлт хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хангагдаагүй бол хэргийг прокурорт буцаах. Одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн зохицуулалтаар прокурор 60 хоногт огт ажиллагаа хийхгүй байх тохиолдол удаа дараа гарч байна. Тухайн зүйл, заалтын зорилго нь юу вэ гэдгийг анхаарч хариуцлагажуулах шаардлагатай. Ажиллагаа хийгдэхгүйгээс болж үр нөлөөгүйгээр хэргийн шийдвэрлэлтийн хугацаа сунжирч, иргэд хуулийн байгууллагад итгэх итгэл буурч байна.<br><br>14.Увс аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх<br>- 2 дугаар зүйл. ЭХХШТХ-ийн 14.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт энэ хуулийн 14.9 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.2-аас 2.5 дахь хэсгийг нэмэх. Урьд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах болсон үндэслэл арилаагүй байгаа уг таслан сэргийлэх арга хэмжээний хугацааг сунгаж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулах нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтод нийцнэ.<br><br>15.Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Сум дундын шүүх | |

- 1 дүгээр зүйл 6/14.10-5 дахь хэсэг. “Мөрдөн шалгах ажиллагааны явцад гэмт хэрэг үйлдэж, яллагдагчаар татагдан цагдан хоригдсон бол цагдан хорих хугацааг шинээр тоолно" гэсэн заалтыг тодруулах шаардлагатай. Зүйл заалтыг дахин тодруулах.
- ЭХХШТХ-ийн дахь хэсэг 17.2-5. “Гэм буруугаа сайн дураараа хүлээн зөвшөөрч, хэргээ хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлүүлэх хүсэлт гаргасан боловч өмгөөлөгч авахаас татгалзсан яллагдагчид өмгөөлөгч томилж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулах журмыг авах Монголын Өмгөөлөгчдийн холбооны саналыг харгалзан хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална." 2024 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн хуульд нэмэлт өөрчлөлт орсон хуулийн заалтын талаар тодруулга авах.

16.Хэнтий аймгийн Бор-Өндөр сум дахь Сум дундын шүүх

- ЭХХШТХ-ийн 3.1 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд ажлын бус цагт таслан сэргийлэх арга хэмжээг хянан шийдвэрлэсэн шийдвэрийг хэрхэн, ямар хугацаанд гаргах. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд ажлын бус цагт таслан сэргийлэх арга хэмжээг хянан шийдвэрлэсэн шийдвэрийг хэрхэн, ямар хугацаанд гаргах нь тодорхойгүй байна. Жишээ нь олон оролцогчтой, олон хавтастай хэргээс нотлох баримт шинжлэн судалснаас шалтгаалж таслан сэргийлэх арга хэмжээг хэлэлцэх шүүх хуралдаан нь оройтож тарсан тохиолдолд шийдвэрийг даруй гаргах боломжгүй байна. Энэ тохиолдолд баримт үйлдэн цагдан хорих байранд хүргүүлэх зохицуулалт оруулах шаардлагатай байна.
- ЭХХШТХ-ийн 33.1 дүгээр зүйлийн 6.13, 6.14 дэх заалт. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.16 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт "Шүүх хуралдааны явцад нотлох баримтаар тогтоогдсон хэргийн нөхцөл байдлыг үндэслэн шүүгдэгчид холбогдох хэргийн зүйлчлэлийг хүндрүүлэхээр бол, эсхүл энэ хуулийн 33.1 дүгээр зүйлийн 6.13, 6.14-т заасан гомдлыг шийдвэрлэх зорилгоор шүүх хэргийг хянан хэлэлцэхийг нэг удаа 60 хүртэл хоногоор хойшлуулна." гэж хуульчилсан. Шаардлагатай тохиолдолд нэмж 30 хоногоор сунгах ба энэ хугацаанд шүүх хуралдаан хойшлуулсан шалтгаан нөхцөл арилаагүй бол шүүгдэгчийг цагаатгах эсхүл хэргийг хэрэг бүртгэлт мөрдөн байцаалтад буцаах гэж нэмэлт заалт оруулах, Шүүх хуралдаан хойшлуулсан шалтгаан нөхцөл арилаагүй тохиолдолд хэргийг цаашид хэрхэн шийдвэрлэх талаар мухардалд орж болох тул зохицуулалт шаардлагатай байна.
- ЭХХШТХ-ийн 5.2 дугаар зүйлийн 6, 7 дахь хэсэг, 5.3 дугаар зүйл, 14.13 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 18.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 31.11 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг. Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авч байгаа тохиолдолд хэрхэн цахим гарын үсэг зурах, мөн хойшлуулшгүй тохиолдолд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг хэрхэн шийдвэрлэх тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах. Цагдан хорих таслан

| | | | |
|---|---|---|---|
| | | сэргийлэх арга хэмжээ авч байгаа тохиолдолд хэрхэн цахим гарын үсэг зурах, мен хойшлуулшгүй тохиолдолд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг хэрхэн шийдвэрлэх талаар зохицуулалт шаардлагатай.<br><br>17.Баянзүрх, Сүхбаатар Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Тамгын газар<br>- Оргон зайлах зүйл ангийг нэмэх.<br>- Өмгөөлөгчийн сахилга, хариуцлагыг дээшлүүлэх.<br>- Шүүхийн шийдвэрийг олон нийтэд мэдээлэхээс татгалзсан этгээдэд оногдуулах хариуцлагыг тодорхой болгох.<br><br>18.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль"-д орсон нэмэлт, өөрчлөлттэй холбоотой бэлтгэл ажлыг хангах чиг үүрэг бүхий Ажлын хэсэг<br>- 1 дүгээр зүйл 3/7.3 дугаар зүйлийн 5 дахь хэсэг. Нотлох баримт хуулбарлан авахтай холбоотой шинэ зохицуулалт байна. Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулийн 7.3 дугаар зүйл яллагдагчийн ямар хэрэгт яллагдаж байгаагаа мэдэх эрхтэй холбоотой зохицуулалт байх тул энэ зүйл, хэсэгт энэ агуулгаар, хэсэгт заасан агуулгад нийцэхгүй байна. Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулийн 7.5 дугаар зүйлд заасан мэдээлэл авах эрхтэй холбоотой зүйл, хэсэгт нэмэлтээр оруулах нь зөв байна.<br>Эсхүл 7.5 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт "Яллагдагч шинжээч томилсон тогтоол, шинжээчийн дүгнэлт, мөрдөн байцаалт дууссаны дараа хавтаст хэргийн материалтай танилцах эрхтэй." гэж заасныг "Яллагдагч шинжээч томилсон тогтоол, шинжээчийн дүгнэлт, мөрдөн байцаалт дууссаны дараа хавтаст хэргийн материалтай танилцах, төр, байгууллага, хувь хүний нууцад хамаарахаас бусад нотлох баримтыг хуулбарлаж, хувилж авах эрхтэй." өөрчлөн найруулах боломжтой байна.<br>Ингэснээр хуулийг боловсруулахдаа хоорондоо уялдаа холбоотой, дэс дараалал бүхий, агуулгыг товч илэрхийлсэн, нэг санааг илэрхийлж байвал нэг хэсэгт тусгах гэсэн Хууль тогтоомжийн тухай хуулийн шаардлагад нийцнэ.<br>- 1 дүгээр зүйл 5/12.1 дүгээр зүйлийн 9 дэх заалт. 12.1 дүгээр зүйлийн 9 дэх хэсгийг "... прокурорын мэдэгдэх хуудсыг хүргүүлж болох ба тухайн мэдэгдэх хуудсыг хүргүүлж, хүлээн авсанд тооцно" гэх агуулгатай найруулга хийх.<br>Цахим хаяг, систем ашиглан мэдэгдэх хуудсыг хүргүүлэх боломжтой байдлаар найруулга хийсэн байх боловч энэ аргаар мэдэгдэх хуудсыг илгээхэд хүргүүлсэнд тооцох эсэх буюу тухайн хүн, хуулийн этгээд хүлээн авсанд тооцох эсэх талаарх зохицуулалт байхгүй байна. Учир нь мэдэгдэх хуудсыг энэ аргаар хүргүүлээд тухайн хүн, хуулийн этгээд хүлээн аваагүй гэх тохиолдолд хэрхэх эсэх нь тодорхойгүй байна. | |

| | | | |
|---|---|---|---|
| | | - 1 дүгээр зүйл 6/14.10 дугаар зүйлийн 5 дахь хэсэг. Энэ заалт нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр нэмэлт, өөрчлөлт оруулсан хуулийн үзэл баримтлалд нийцэхгүй байна. Учир нь одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулиар нэг хэрэгт дахин, эсхүл тусгаарласан, нэгтгэсэн хэрэгт шинээр цагдан хоригдсон бол өмнө нь цагдан хоригдсон хугацааг нийт цагдан хоригдсон хугацаанд оруулан тооцохоор буюу яллагдагчийн эрх зүйн байдлыг дээрдүүлсэн зохицуулалт үйлчилж байна. Энэ нэмэлт, өөрчлөлтийн заалт нь яллагдагчийг хэрэг тус бүр дээр шинээр цагдан хорих хугацааг тоолох нөхцөл байдлыг бий болгож байх ба хамгийн сүүлийн үйлдэлдээ яллагдагчаар татагдсан тохиолдолд өмнө нь цагдан хоригдсон хугацааг хамааруулахгүй буюу яллагдагчийн эрх зүйн байдлыг дордуулж байна. Учир нь шүүхээр гэм буруутай эсэх нь эцэслэн тогтоогдоогүй байхад яллагдагчийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.10 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан яллагдагчаар цагдан хорих хугацааг дахин дахин шинээр тоолох нөхцөл байдал буюу агуулгаараа хорих ял эдлүүлж буй мэт нөхцөл байдлыг практикт бий болгох эрсдэлтэй бөгөөд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.1 дүгээр зүйлд заасан хуулийн зорилгод нийцэхгүй гэж үзэж байна.<br>- 1 дүгээр зүйл 2/5.1 дүгээр зүйлийн 2.11 дэх заалт. Хуульчдын холбоо, Өмгөөлөгчдийн холбооноос өөрийн гишүүн өмгөөлөгчдийн нэвтрэн орох системийг хийх шаардлагатай ба хэрэг бүртгэлт, прокурор, шүүх нь уг системд өгөгдөл солилцох боломжтой байж, хэргийн материалыг Өмгөөллийн системд илгээж тодорхой хугацаанд танилцах, татаж авах боломжтой болгох байдлаар өмгөөлөгчийг хэрэгтэй танилцах боломжоор хангаж болно. Цахим хавтаст хэргийн мэдээллийн систем гэсэн нэгдсэн систем байхгүй байгаа ба нэгдсэн системийг бий болгох төлөвлөгөөгүй байгаа.<br>- 1 дүгээр зүйл 11.11 дүгээр зүйлийн 7 дахь хэсэг. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчид хоорондоо өгөгдөл, мэдээллийг цахимаар солилцох журмыг Шүүхийн ерөнхий зөвлөл, Улсын ерөнхий прокурор, хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална гэх агуулгатай найруулга хийх. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч байгууллага өөр өөрийн системийг хоорондын холбох үндсэн хэрэгцээ шаардлага нь өгөгдөл мэдээлэл солилцох буюу хэргийн материалыг дамжуулж чаддаг байх шаардлагатай. ЭХШХШТХ-н 1.16 дугаар зүйлийн 2-т хэргийн материал, хавтас хэрэг нь шүүхийн цахим платформын шаардлагад нийцсэн байх гэсэн 2024 оны 6 дугаар сарын 06-ны өдөр орсон нэмэлт заалттай уялдаж хэрэгжихийг анхаарах шаардлагатай. | |
| 3. | Улсын ерөнхий прокурорын газар 2024.11.08 1/7283 | 1.Хуулийн төслийн 1 дүгээр зүйл. 4/11.11 дүгээр зүйлийн 7 дахь хэсэг: 7.Хавтаст хэргийг цахимжуулах, шүүх, прокурор, мөрдөн шалгах эрх бүхий байгууллагуудын нэгдсэн системд холбох журмыг Шүүхийн ерөнхий зөвлөл, Улсын ерөнхий прокурор, хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална".<br>"...нэгдсэн системд холбох" гэсний дараа "ашиглах" гэж нэмэх. | Саналыг тусгасан.<br>Харин Монгол Улсын Их Хурлын 2024 оны 18 дугаар тогтоол |

| | | | |
|---|---|---|---|
| | | Хавтаст хэргийг цахимжуулах, шүүх, прокурор, мөрдөн шалгах эрх бүхий байгууллагуудын нэгдсэн системд холбохоос гадна уг системийг ашиглах асуудлыг журамд тусгах шаардлагатай.<br><br>2.Хуулийн төслийн 1 дүгээр зүйл. 7/14.10 дугаар зүйлийн 14 дэх хэсэг: Хоригдолд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авсан үед хорих ялын хугацаа дуусахаар бол энэ зүйлийн 7-д заасан журмын дагуу цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах эсэхийг шүүх шийдвэрлэнэ.<br>"14.Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах тухай шүүгчийн захирамжийн дагуу хоригдлыг цагдан хорих байранд хүлээн авсан өдрөөс эхлэн цагдан хорих хугацааг тоолж, энэ зүйлд заасан журмын дагуу цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг сунгах эсэхийг шүүх шийдвэрлэнэ." гэж өөрчлөх.<br>ШШГТХ-ийн 212 дугаар зүйлийн 2-т "Энэ хуулийн 212.1-д заасны дагуу шилжүүлэх тохиолдолд хоригдлыг яллагдагчид цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах тухай шүүгчийн захирамжийг үндэслэн шилжүүлэн авсан албан тушаалтан цагдан хорих төв, эсхүл цагдан хорих байранд хүргэх бөгөөд уг хугацааг ял эдэлсэн хугацаанд тооцно" гэж заасан.<br>Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авсан шүүгчийн захирамж гарч, тус шийдвэрийг биелүүлэх зорилгоор хоригдлыг хорих ангиас очиж авах, шүүгчийн захирамжид заасан цагдан хорих төв, байранд хүргэх, цагдан хорих төв байр нь хоригдлыг шүүгчийн захирамжийн хамт зохих журмын дагуу хүлээн авснаар хоригдол нь яллагдагчийн эрхийг эдэлнэ.<br>Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах тухай шүүгчийн захирамж гарсан хэдий ч тус захирамж биелээгүй буюу цагдан хорих төв, байр яллагдагчийг хүлээн аваагүй тохиолдолд яллагдагчаар цагдан хоригдсон гэж үзэх үндэслэлгүй юм. Өөрөөр хэлбэл, хорих ангиас цагдан хорих төв, байр хүртэлх зам хоногийг хорих ял эдэлсэн хугацаанд оруулан тооцох тухай ойлголт юм.<br>Ийнхүү цагдан хорих төв, байранд хүргэгдэн, өмнөх, эсхүл дахин гэмт хэрэгт холбогдож, яллагдагчаар цагдан хоригдсон үеэс тасалбар болгон хорих ял биечлэн эдэлсэн хугацааг зогсоох буюу хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолын биелэлтийг түр зогсоох нь зүйтэй. Учир нь хоригдол, яллагдагчийн эрх зүйн байдал, дэглэм журам харилцан адилгүй юм.<br>Түүнчлэн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолоор хорих ял эдэлж буй ялтан шүүхийн шийтгэх тогтоол гарахаас өмнө, эсхүл ял эдэлж байх хугацаандаа гэмт хэрэг үйлдсэн гэх хангалттай үндэслэл тогтоогдсон бол прокуророос ЭХХШТХ-д заасан үндэслэл журмын дагуу түүнд эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татах тухай шийдвэр гаргаж, улмаар эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг шуурхай явуулж, шийдвэрлэх нь ЭХХШТХ-ийн "гэмт хэргийг шуурхай, бүрэн илрүүлэх, гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоон шударгаар ял оногдуулах, хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх" зорилтод бүрэн нийцнэ.<br>ЭХХШТХ-ийн 14.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Яллагдагч, шүүгдэгчид энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу дараах таслан сэргийлэх арга хэмжээ авна" гэж заасны дагуу | болон хуулийн төслийн үзэл баримтлалд тусгагдаагүй асуудлын талаар ирүүлсэн саналыг тусгаагүй болно. |

| | | | |
|---|---|---|---|
| | | яллагдагчийн холбогдсон гэмт хэргийн шинж, байдал, нийгмийн хор аюул, хувийн байдал зэргийг харгалзан хуульд заасан 6 төрлийн таслан сэргийлэх арга хэмжээнээс сонгож авах үндэслэл, журмыг тогтоосон ба хүчин төгөлдөр шийтгэх тогтоолоор хорих ял эдэлж буй ялтанд цагдан хорихоос өөр төрлийн таслан сэргийлэх арга хэмжээ авах боломжгүй юм.<br>Мөн ЭХХШТХ-д заасан яллагдагчийн "мөрдөн шалгах ажиллагаанд биечлэн оролцох, өмгөөлөгчтэйгөө уулзах, гомдол хүсэлт гаргах, мэдээлэл авах, шүүхийн хэлэлцүүлэгт оролцох" зэрэг эрхийг хангах, хэргийн мөрдөн шалгах ажиллагааг шуурхай явуулж, хүний эрхийг шуурхай сэргээн тогтоох зэрэг хэрэгцээ шаардлага үүсдэг.<br>Хорих ял эдэлж буй хоригдлын ял эдэлж буй хорих ангийн дэглэм, журмаас хамаарч хоригдлын эрх, эрх чөлөө, хүлээх үүрэгт тодорхой хязгаарлалт, дэглэм журам үйлчлэх бөгөөд энэ нь ЭХХШТХ болон ШШГТХ-иар зохицуулсан процесс ажиллагаа, журамд нийцэхгүй буюу тохирохгүй, мөн яллагдагчийн эрх, үүргийн хэрэгжилт хангагдах боломжгүй байдалд хүргэнэ.<br>Ийм учраас ШШГТХ-ийн 212 дугаар зүйлийн 212.1-д "Хоригдол шүүхийн шийтгэх тогтоол гарахаас өмнө, эсхүл ял эдэлж байх хугацаандаа гэмт хэрэг үйлдсэн гэх хангалттай үндэслэл тогтоогдсон бол прокурорын зөвшөөрлийг үндэслэн хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллагад шилжүүлж болно" гэж, Прокурорын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1- д "Хуульд заасан тохиолдолд прокурор зөрчил шалган шийдвэрлэх, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагааны явцад зөвшөөрөл өгнө" гэж, мөн хорих ял эдэлж буй хүнд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах үндэслэлийг ЭХХШТХ-д 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр нэмэлт, өөрчлөлт оруулсан. Хоригдолд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах нь түүний хорих ял эдэлж буй гэмт хэрэгтэй хамааралгүй бөгөөд түүнийг шүүхээс гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцсон тохиолдолд цагдан хоригдсон хугацааг эдлэх ялд нь оруулан тооцох талаар ЭХХШТХ-д, мөн хэд хэдэн шийтгэх тогтоолоор оногдуулсан ялыг нэмж нэгтгэх талаар Эрүүгийн хуулийн 6.9-д тодорхой зохицуулсан.<br><br>3.Хуулийн төслийн 1 дүгээр зүйл. 18/34.13 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:2.Улсын яллагч, шүүгдэгч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч нь гэрч, шинжээч оролцуулах хүсэлтээсээ татгалзаагүй тохиолдолд шүүх талуудын хүсэлтийг харгалзан шүүх хуралдааны хойшлуулах эсэхийг шийдвэрлэнэ.<br>"2. Гэрч, шинжээч оролцуулах тухай хүсэлтийг хангаж, шүүх хуралдааныг хойшлуулсан боловч шүүх хуралдаанд хүрэлцэн ирээгүй, улсын яллагч, шүүгдэгч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч уг хүсэлтээсээ татгалзаагүй тохиолдолд шүүх талуудын хүсэлтийг харгалзан шүүх хуралдааны хойшлуулах эсэхийг шийдвэрлэнэ." гэж өөрчлөх.<br>ЭХХШТХ-ийн 34.13 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зохицуулалттай ижил агуулгатай буюу зохицуулалтын давхардал үүсэж байх тул найруулгыг өөрчлөх нь зүйтэй байна.<br><br>4.Хуулийн төслийн 1 дүгээр зүйл. 19/34.16 дугаар зүйлийн 6 дахь хэсэг: "6. Прокурор энэ хуулийн 5 дахь хэсэгт заасан ажиллагааг шүүхээс тогтоосон хугацаанд биелүүлэх боломжгүй бол шүүх хуралдааныг 30 хүртэл хоногоор хойшлуулж болно. | |

| | | | |
|---|---|---|---|
| | | "6.Прокурор энэ зүйлийн 5 дахь хэсэгт заасан ажиллагааг шүүхээс тогтоосон хугацаанд биелүүлэх боломжгүй бол шүүх хуралдааныг нэг удаа 30 хүртэл хоногоор хойшлуулж болно" гэж өөрчлөх.<br>Хуулийн төслийн энэ хэсэгт "хуулийн" гэснийг "зүйлийн" гэж өөрчлөх. Мөн шүүх хуралдааныг 30 хүртэл хоногоор хойшлуулж болно гэж заасан нь хэдэн ч удаа хойшлуулж болохоор зохицуулалт байна. Энэ нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчдыг чирэгдүүлэх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа удаашрах үр дагавар үүсгэхээр байх тул нэг удаа 30 хүртэл хоногоор хойшлуулах нь зүйтэй.<br><br>5.Хуулийн төслийн 1 дүгээр зүйл. 23/36.13 дугаар зүйлийн 5, 6 дахь хэсэг: "5.Төрийн нууц мэдээлэл агуулсан шүүхийн шийдвэрийн нууц агуулаагүй "Удиртгал" болон "Тогтоох" хэсгийг нууцын тэмдэглэлээ, дардас дарахгүйгээр прокурор, оролцогчид гардуулж, нууц мэдээлэл агуулсан "Тодорхойлох" хэсгийг гардуулахгүйгээр, шүүхийн шийдвэрийг бүрэн бодитой танилцуулах арга хэмжээ авна"<br>"6.Шүүхийн шийдвэрийн "Удиртгал" болон "Тогтоох" хэсэгт төрийн нууцад хамаарах мэдээлэл агуулагдсан бол тэр хэсгийг хасаж хэвлэн, прокурор, оролцогчид гардуулна".<br>5, 6 дахь заалтаас "прокурор" гэснийг тус тус хасах.<br>Прокурорын тухай хуулийн 25 дугаар зүйлд заасны дагуу Улсын ерөнхий прокурор, түүний тусгайлан эрх олгосон прокурор мөрдөн шалгах нууц ажиллагаа, гүйцэтгэх ажилд хяналт тавьж ажилладаг бөгөөд нууц мөрдөн шалгах ажиллагаа явуулах, түүнтэй прокурор танилцах, хяналт тавих, нууцыг хамгаалахтай холбоотой харилцааг холбогдох хууль, журмаар зохицуулдаг. Түүнчлэн төрийн нууцад хамаарах мэдээлэл агуулсан эрүүгийн хэргийн мөрдөн шалгах ажиллагаанд тухайн хэрэгтэй танилцах, хянах, нууц мэдээллийг хадгалах үүрэг бүхий тусгай эрх олгогдсон прокурор хяналт тавьж ажиллан шүүхэд шилжүүлж шийдвэрлүүлсэн байхад тухайн прокурорт шүүхийн шийтгэх тогтоолын холбогдох хэсгийг нууцлан танилцуулах, гардуулах нь өрөөсгөл бөгөөд агуулгын хувьд алдаатай байна.<br>Харин тухайн хэргийн оролцогчид танилцуулах, гардуулах ажиллагаатай холбоотой харилцааг ийнхүү зохицуулж, хуульд нэмэлт өөрчлөлт оруулах нь зүйтэй юм.<br><br>6.Хуулийн төслийн 2 дугаар зүйл. 5.1 дүгээр зүйлийн 2.5 дахь заалт: "асуулт тавих" гэсний дараа "хариулт авах" – хасах.<br>Өмгөөлөгчөөс асуусан асуултад хариулт заавал өгөхөөр зохицуулалт тусгасан нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нийцээгүй байна. Тухайлбал, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 7.4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт "яллагдагчийг өөрийнх нь эсрэг мэдүүлэг авахаар албадахыг хориглоно" гэж заасан.<br><br>7.Хуулийн төслийн 2 дугаар зүйл. 5.1 дүгээр зүйлийн 2.12 дахь заалт: "оролцох" гэсний дараа "таслан сэргийлэх арга хэмжээ авах үндэслэл болсон мөрдөгч, прокурорын санал, шийдвэрийн үндэслэлд хамаарах баримт, мэдээлэлтэй танилцах" | |

| | | | |
|---|---|---|---|
| | | “таслан сэргийлэх арга хэмжээ авах үндэслэл болсон мөрдөгч, прокурорын санал, шийдвэрийн үндэслэл, түүний нотлох баримттай танилцах” гэж өөрчлөх.<br>ЭХХШТХ-ийн 14.13 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасантай нийцүүлэн таслан сэргийлэх арга хэмжээ авах үндэслэл болсон мөрдөгч, прокурорын санал, шийдвэрийн үндэслэл, түүний нотлох баримттай танилцах эрхтэй гэж тусгах нь зүйтэй байна.<br><br>8.Хуулийн төслийн 3 дугаар зүйл. 1/5.1 дүгээр зүйлийн 2.6 дахь заалт:2.6.Мөрдөн шалгах ажиллагаа, шүүхийн хэлэлцүүлэг, шүүх хуралдааны үед хийгдсэн дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг болон тэмдэглэлтэй хэргийн материалтай танилцах үед хуулбарлан авах, тэмдэглэлд засвар оруулах тухай хүсэлт гаргах.<br>"...хэргийн материалтай" гэснийг хасах.<br>Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 32.1 дүгээр зүйлд "мөрдөгч мөрдөн шалгах бүх ажиллагааг хийж дууссан, хэргийн бодит байдлыг бүрэн нотолж тогтоосон гэж үзвэл яллагдагч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, тэдний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчид хавтаст хэргийн материалтай танилцуулж, хэрэгт тусгагдсан эд мөрийн баримт, мөрдөн шалгах ажиллагааны тэмдэглэлд тусгагдсан дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгтэй танилцах тухай оролцогчийн хүсэлтийг хангах арга хэмжээ авах. Оролцогч хүсэлт гаргавал хавтаст хэргийн материалаас шүүхээр хэлэлцүүлэх төрийн нууцад хамаарахаас бусад нотлох баримтыг өөрийн зардлаар хуулбарлаж, хувилж авах боломжоор хангах",<br>Мөн 5.1 дүгээр зүйлд өмгөөлөгч нь "өмгөөлж байгаа сэжигтэн, хохирогч, яллагдагч, шүүгдэгч, ялтны, эсхүл өөрийнхөө хүсэлтээр хийгдэж байгаа мөрдөн шалгах ажиллагаанд байлцаж, аль ч үед асуулт тавих, хүсэлт гаргах; өөрийн оролцсон мөрдөн шалгах ажиллагаа, шүүхийн хэлэлцүүлэг, шүүх хуралдааны тэмдэглэлтэй танилцаж, засвар оруулах тухай хүсэлт гаргах;" эрхийг хуульчилсан.<br><br>9.Хуулийн төслийн 3 дугаар зүйл. 3/14.13 дугаар зүйлийн 5 дахь хэсэг: 5.Прокурор, яллагдагч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн гаргасан санал, хүсэлтийн үндэслэлд хамаарах баримт, мэдээллийг шүүх хэргийн оролцогчид танилцуулж, тэдгээрт тайлбар хийх, холбогдох баримт, мэдээллийг гаргаж өгөх боломжоор хангана. Талуудад танилцуулагдаагүй баримт, мэдээлэл нь шүүхийн шийдвэрийн үндэслэл болохгүй. Хасах.<br>Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.13 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт "Прокурор, яллагдагч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч гаргасан санал, хүсэлтийнхээ үндэслэлийг шүүхэд танилцуулна" гэж заасан ба сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид холбогдох хэсгийг танилцуулах зохицуулалт байхгүй.<br>Мөн хуулийн 32.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар мөрдөн шалгах ажиллагаа дууссаны дараа хэргийн материалтай танилцах, өөрийн зардлаар хуулбарлан авах тухай зохицуулалт тусгагдсан. Мөрдөн шалгах ажиллагаа дуусаагүй байх үед өмгөөлөгчид нотлох баримттай танилцуулах нь мөрдөн шалгах ажиллагааны нууцлал, үр дүнд хамаарна. | |

10.Хуулийн төслийн 3 дугаар зүйл. 7/32.10 дугаар зүйлийн 6 дахь хэсэг: 6.Прокурор хэргийг шүүхэд шилжүүлэхээс ажлын 3-аас доошгүй хоногийн өмнө яллах дүгнэлтийг яллагдагчид гардуулж, энэ талаар түүний хууль ёсны төлөөлөгч, хохирогч, өмгөөлөгчид мэдэгдэнэ.
"6.Прокурор яллах дүгнэлтийн хувийг яллагдагчид гардуулж, хавтаст хэргийн материалыг ажлын 3 хоногийн дараа харьяалах шүүхэд шилжүүлэх тухай яллагдагч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчид мэдэгдэнэ" гэж өөрчлөх.
Утга найруулгыг засах шаардлагатай. Учир нь прокурор хэргийг хянаад шүүхэд шилжүүлэх үндэслэлтэй гэж үзвэл яллах дүгнэлт үйлдэх ба ийнхүү үйлдсэн яллах дүгнэлтээ яллагдагчид гардуулж, улмаар хэргийг шүүхэд шилжүүлдэг.

11.Хуулийн төслийн 4 дүгээр зүйл. 5.1 дүгээр зүйлийн 2.4 дэх заалт: прокурорт гэснийг "прокурор, шүүхэд". Хасах.
Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "нотлох баримтыг тал бүрээс нь бүрэн бодитойгоор шалгаж хянасны үндсэн дээр хэргийн бодит байдлыг тогтоох" үүргийг, 16.4 дүгээр зүйлд энэ хуульд заасан мөрдөн шалгах ажиллагаа явуулах замаар нотлох баримт цуглуулж бэхжүүлэх ажиллагаа явуулахыг мөрдөгчид даалгасан зохицуулалттай нийцэхгүй байна.
Энэ зохицуулалтыг одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 5.1 дүгээр зүйлд заасан "хууль зүйн туслалцаа үзүүлэхэд шаардлагатай эд зүйл, баримт бичиг, мэдээлэл, бусад баримтыг мөрдөгч, прокурорт гаргаж өгөх, хавтаст хэрэгт бэхжүүлж тусгуулах, мөрдөн шалгах ажиллагаа явуулах хүсэлт гаргах; энэ хуульд заасан журмын дагуу оролцох, өмгөөлж байгаа сэжигтэн, хохирогч, яллагдагч, шүүгдэгч, ялтны, эсхүл өөрийнхөө хүсэлтээр хийгдэж байгаа мөрдөн шалгах ажиллагаанд байлцаж, аль ч үед асуулт тавих, хүсэлт гаргах; өөрийн оролцсон мөрдөн шалгах ажиллагаа, шүүхийн хэлэлцүүлэг, шүүх хуралдааны тэмдэглэлтэй танилцаж, засвар оруулах тухай хүсэлт гаргах; өөрсдийнх нь зөвшөөрснөөр хүн, хуулийн этгээдээс хэрэгт ач холбогдол бүхий тайлбар, баримт бичиг, лавлагаа, тодорхойлолт гаргуулж авах эрхийн хүрээнд хэрэгжүүлэх боломжтой юм.

12.Хуулийн төслийн 4 дүгээр зүйл. 21.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг: "эд мөрийн баримтыг" гэснийг "энэ хуулийн 16.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан "баримтат мэдээллийг". Хасах.
ЭХХШТХ-ийн 16.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "Баримтат мэдээлэл нь гэрч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн мэдүүлэг, эд мөрийн баримт, баримт бичиг, шинжээчийн дүгнэлт, мэдүүлэг, мөрдөгчийн магадалгаа, энэ хуульд заасны дагуу бэхжүүлсэн кино ба гэрэл зураг, зураглал, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг, эрх бүхий байгууллагын цахим мэдээллийн сангаас цахим гарын үсгээр баталгаажуулж авсан лавлагаа, тодорхойлолт, ул мөрөөс авсан хэв, мөрдөн шалгах ажиллагааны болон шүүх хуралдааны тэмдэглэл, хүн, хуулийн этгээд, албан тушаалтнаас ирүүлсэн гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл болон энэ хуульд заасан бусад баримтаар тогтоогдоно" гэж заасан. ЭХХШТХ-ийн 21.1 дүгээр зүйлд эрүүгийн хэрэгт хураан авсан хөрөнгө, орлого, эд мөрийн баримтыг

| | | | |
|---|---|---|---|
| | | хадгалахтай холбоотой харилцааг зохицуулсан бөгөөд тус зүйлийн 2 дахь хэсэгт шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болох хүртэл, эсхүл яллагдагчаар татах тогтоолыг хүчингүй болгох, хэргийг хэрэгсэхгүй болгох шийдвэрт давж заалдах хугацаа дуустал хураан авсан хөрөнгө, орлого, эд мөрийн баримтыг тусгай байранд хадгалахтай холбоотой зохицуулалтыг тусгасан.<br>Гэтэл эрүүгийн хэрэгт хураан авсан хөрөнгө, орлого, эд мөрийн баримтыг тухайн хэргийг шийдвэрлэсэн прокурор, шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болох хүртэл хугацаанд тодорхой орчин, нөхцөл бүхий тусгай байранд /хавтаст хэргээс тусад нь/ хадгалах тухай зохицуулалтад эрүүгийн хэргийн нотлох баримт буюу "баримтат мэдээлэл"-ийг бүхэлд нь хамааруулсан нь ойлгомжгүй, алдаатай байна. Өөрөөр хэлбэл, хавтаст хэрэгт авагдсан баримтат мэдээллийг эд мөрийн баримт, хураан авсан эд зүйл, хөрөнгө, орлогын хамт тусгай орчин нөхцөл бүхий байранд хадгалах тухай ойлголт байх тул бүхэлд нь хасах үндэслэлтэй байна.<br><br>13.ЭХХШТХ-ийн 43 дугаар бүлэг. Гэмт хэрэг үйлдсэн хүнийг гадаад улсад эрэн сурвалжлах зохицуулалтыг тусгах. "43.7 дугаар зүйл. Гэмт хэрэг үйлдсэн хүнийг гадаад улсад эрэн сурвалжлах.<br>1.Улсын ерөнхий прокурор өөрийн санаачилгаар, эсхүл мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллагын саналыг үндэслэн гэмт хэрэг үйлдсэн хүнийг гадаад улсад эрэн сурвалжлах шийдвэр гаргана.<br>2.Мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага прокурорын шийдвэрийн дагуу гэмт хэрэг үйлдсэн хүнийг гадаад улсад эрэн сурвалжлах ажлыг зохион байгуулж, үр дүнг прокуророос тогтоосон хугацаанд танилцуулна." гэж нэмэх.<br>Прокурорын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2-т "Улсын ерөнхий прокурор нь өөрийн санаачилгаар, эсхүл холбогдох байгууллагын саналыг үндэслэн гэмт хэрэг үйлдсэн хүнийг гадаад улсад эрэн сурвалжлах шийдвэр гаргана." гэж заасан. Харин Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд гэмт хэрэг үйлдсэн хүнийг гадаад улсад эрэн сурвалжлах зохицуулалт байхгүй тул энэ талаар хуульд нэмж тусгах нь зүйтэй байна.<br><br>14.Хуулийн төслийн 1 дүгээр зүйл. 7/14.13 дугаар зүйлийн 14 дэх заалт: 14.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч үед энэ хуулийн 14.1 дүгээр зүйлийн 1.2, 1.3, 1.5-д заасан таслан сэргийлэх арга хэмжээ авах, өөрчлөх, хүчингүй болгох, хүсэлт болон хугацааг сунгасан шүүхийн шийдвэрийг мөрдөгч, прокурорт мэдэгдэх бөгөөд шүүхийн шийдвэрийг цахим мэдээллийн сүлжээгээр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад даруй хүргүүлнэ."<br>"14. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч үед энэ хуулийн 14.1 дүгээр зүйлийн 1.2, 1.3, 1.5-д заасан таслан сэргийлэх арга хэмжээ авах, өөрчлөх, хүчингүй болгох, хугацаа сунгах санал, хүсэлт болон хугацаа сунгасан шүүхийн шийдвэрийг даруй мөрдөгч, прокурорт мэдэгдэж, шүүхийн шийдвэрийг цахим мэдээллийн сүлжээгээр эрх бүхий байгууллагад хүргүүлнэ." гэж өөрчлөх.<br>Шүүхийн шийдвэрийг мөрдөгч, прокурорт мэдэгдэх хугацаа болон шүүхийн шийдвэрийг хүргүүлэх хугацааг "даруй" болгож тодорхой тусгах. Мөн таслан сэргийлэх арга хэмжээний | |

| | | | |
|---|---|---|---|
| | | төрлөөс хамааран шүүхийн шийдвэрийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас гадна бусад эрх бүхий байгууллагад хүргүүлэхээр байх тул "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад" гэснийг эрх бүхий байгууллагад гэж өөрчлөх нь зүйтэй байна.<br><br>15.Хуулийн төслийн 2 дугаар зүйл. 33.1 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг: "мэдэгдэнэ" гэсний дараа "Прокурор, оролцогч ирээгүй нь шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг хойшлуулах үндэслэл болохгүй." Хасах.<br>ЭХХШТХ-ийн 33.1 дүгээр зүйлийн 6 дахь хэсэгт зааснаар шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгээр мөн зүйлийн 6.1-6.17 дахь хэсэгт заасан асуудлуудыг хэлэлцэх тул талуудыг оролцуулахгүйгээр урьдчилсан хэлэлцүүлэг хийх боломжгүй. Урьдчилсан хэлэлцүүлэг нь талуудын оролцоотойгоор шүүх хуралдааны бэлтгэл хангах үйл ажиллагаа юм. Иймд прокурор, оролцогчийг оролцуулан урьдчилсан хэлэлцүүлэг хийх нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилт, зарчимд нийцнэ.<br><br>16.ЭХХШТХ-ийн 11.8 дугаар зүйлийн 2 дахь хэсэг: 2.Шүүх хуралдаанд оролцогч, бусад оролцогч, прокурор шүүх хуралдааны тэмдэглэлийг танилцуулснаас хойш 5 хоногийн дотор засвар оруулах санал, хүсэлт гаргах эрхтэй.<br>"гаргах" гэсний дараа "хуулбарлан авах" гэж нэмэх.<br>Хуулийн төслийн 5.1 дүгээр зүйлийн 2.6 дахь заалтад өмгөөлөгч шүүх хуралдааны тэмдэглэл болон дуу-дүрсний бичлэгийг хуулбарлан авах эрхийг тусгасан атлаа мэтгэлцэгч нөгөө тал болох прокурорт энэ эрхийг олгохгүй, орхигдуулсан байна. Хуулийн төсөлд өмгөөлөгчийн эрхтэй холбоотой зохицуулалтууд нэмж тусгахдаа шүүх хуралдааны мэтгэлцээнд тэгш эрхтэй оролцогч нэг тал болох прокурор шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад эдлэх эрх, үүргийг орхигдуулсан байгааг анхаарах шаардлагатай байна.<br><br>17.ЭХХШТХ-ийн 11.8 дугаар зүйлийн 5 дахь хэсэг: 5.Оролцогчийн хүсэлтээр шүүх хуралдааны явцыг баталгаажуулсан дууны, дуу-дүрсний бичлэгийг түүнд танилцуулна. "Шүүх хуралдааны явцыг баталгаажуулсан дууны, дуу-дүрсний бичлэгийг прокурор хуулбарлан авах"зохицуулалтыг нэмэх.<br><br>18.ЭХХШТХ-ийн 7 дугаар бүлэг: Яллагдагч. 7.10 дугаар зүйл. Яллагдагчийн хүүхдийг харгалзан дэмжих, эд хөрөнгийг хамгаалах<br>1.Мөрдөгч, прокурор, шүүх яллагдагчийн харгалзах хүнгүй үлдэж буй бага насны болон насанд хүрээгүй хүүхдийг харгалзан дэмжих, эд хөрөнгийг хамгаалах талаар дор дурдсан үүрэг хүлээнэ:<br>1.1.Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан яллагдагчийн асрах хүнгүй бага насны болон насанд хүрээгүй хүүхэд, өндөр настай эцэг, эх болон бусад асруулагчийг харгалзан дэмжүүлэхээр төрөл садны буюу бусад хүмүүст, эсхүл зохих байгууллагад мөрдөгч, прокурор, шүүхийн шийдвэрээр шилжүүлэн өгөх; | |

| | | | |
|---|---|---|---|
| | | 1.2.Цагдан хоригдсон яллагдагчийн эд хөрөнгийг хамгаалуулах арга хэмжээ авах;<br>2.Энэ хуулийн 1 дэх хэсэгт заасан арга хэмжээ авсан талаар яллагдагчид мэдэгдэнэ." гэж нэмэх.<br>Мөрдөн шалгах ажиллагааны явцад сэжигтэн, яллагдагчийн үйлдсэн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хор уршгаас шалтгаалж сэжигтнийг баривчлах, яллагдагчийг цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах үндэслэл бий болдог. Энэ үед тэдний бага насны хүүхэд болон бусад асруулагчид зайлшгүй хамгаалалт тогтоох, эд хөрөнгийг хамгаалах шаардлага үүсдэг. Ялангуяа, бага насны хүүхэд хараа хяналтгүй үлдэх, үүнээс үүдэн хүүхдийн эрх ашигт хохирол учирч болзошгүй нөхцөл байдал бий болдог бөгөөд энэ тохиолдолд хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа байгууллага болон прокурор, шүүх тухай бүр яллагдагчийн хүүхдийг харгалзан дэмжих болон эд хөрөнгийг хамгаалах арга хэмжээг авч байх шаардлага тулгардаг.<br><br>19.ЭХХШТХ-ийн 34.19 дүгээр зүйл. 3.Энэ зүйлийн 1.1-д заасны дагуу шүүх хэрэгсэхгүй болгосон хэргийг хэрэг бүртгэлтэд буцаана.<br>"3.Энэ зүйлийн 1.1, 1.9-д заасны дагуу шүүх хэрэгсэхгүй болгосон хэргийг хэрэг бүртгэлтэд буцааж болно." гэж өөрчлөх.<br>Хуулийн төслийн 34.19 дүгээр зүйлийн 1.9 дэх заалтад "нэмэлт нотлох баримтыг цуглуулах бүхий ажиллагааг хийсэн боловч шүүгдэгч гэмт хэрэг үйлдсэн болох нь нотлогдоогүй." гэсэн нэмэлт өөрчлөлттэй холбогдуулан энэхүү өөрчлөлтийг төсөлд нэмж тусгах шаардлагатай.<br>Гэмт хэрэг үйлдэгдсэн боловч тухайн хүн үйлдсэн болох нь нотлогдоогүй бол түүнд холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгох нь зүйн хэрэг боловч энэ нь үйлдэгдсэн гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдал биш юм. Энэ нь тухайн гэмт хэргийг үйлдсэн этгээдэд ял завших боломж олгож, хохирогчийн зөрчигдсөн эрхийг сэргээх боломжгүй байдалд хүргэх эрсдэлтэй. Мөн гэмт хэргийн шинжгүй болон нэмэлт нотлох баримтыг цуглуулсан боловч гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдоогүй үндэслэлээр шүүгдэгчид холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгосон боловч нэмэлт хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулах боломжгүй, шаардлагагүй тохиолдлууд үүснэ. Иймд "буцааж болно" гэх байдлаар өөрчлөх нь зүйтэй юм.<br><br>20.ЭХХШТХ-ийн 1.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг: 1.3.яллагдагч, шүүгдэгч нас барсан;<br>"1.3.яллагдагчаар татагдвал зохих этгээд, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч нас барсан " гэж өөрчлөх.<br>Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг шалгах, мөн хэрэг бүртгэлтийн хэрэгт мөрдөн шалгах ажиллагаагаар яллагдагчаар татагдвал зохих этгээд нь тодорхой боловч нас барсан бол түүнд холбогдуулан эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тухай шийдвэр гаргах боломжгүй, эсхүл прокуророос эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тухай шийдвэр гарч, дуудагдсан сэжигтэн нас барсан тохиолдолд холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгох үндэслэл байхгүй тул хуулийг төсөөтэй хэрэглэн ЭХХШТХ-ийн 1.5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.3-ийг | |

| | | | |
|---|---|---|---|
| | | баримталж шийдвэрлэж байна. Иймд хуулийг нэг мөр хэрэгжүүлэх үүднээс уг хийдлийг засах шаардлагатай.<br><br>21.ЭХХШТХ-ийн 1.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг: 1.4. тухайн хэргийг урьд нь хэрэгсэхгүй болгосон тогтоол, магадлал хүчинтэй байгаа;<br>"1.4.тухайн гомдол, хэргийг шийдвэрлэсэн прокурор, шүүхийн шийдвэр хүчинтэй байгаа" гэж өөрчлөх.<br>Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд "хэргийг", "хэрэгсэхгүй болгосон тогтоол" гэж заасан нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан "… нэг нэр томьёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх, хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих" шаардлагад нийцэхгүй байна. Учир нь гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авахаас татгалзах, хэрэг бүртгэлтийн хэргийг хаах зэрэг шийдвэрүүд хүчин төгөлдөр байгаа буюу эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж болохгүй тохиолдолд хамаарах нөхцөл байдал тогтоогдсон боловч тус үндэслэлээр гомдол, хэргийг шийдвэрлэх боломжгүй, энэ тохиолдолд ЭХХШТХ-ийн 1.5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.4-ийг төсөөтэй хэрэглэж байна. Иймд тухайлсан нэр томьёогоор бус өргөн агуулга, ерөнхий нэр томьёогоор, эсхүл шийдвэр тус бүрийг нэг бүрчлэн тоочин бичих шаардлагатай.<br>22.ЭХХШТХ-ийн 3.1 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг: Шүүх энэ хуулийн 14.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.3, 1.5 дахь заалт, 31.5 дугаар зүйлд заасан асуудлыг хянан шийдвэрлэх ажиллагааг хуанлийн өдөр бүр шөнийн цагаас бусад цагт тасралтгүй хэрэгжүүлнэ. 5."1.5 дахь заалт гэсний дараа 31.4" гэж нэмэх.<br>ЭХХШТХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар тус зүйл хэсгийг орхигдуулсан байх тул нэмэлт оруулах шаардлагатай. Ингэснээр хүнийг баривчлах, цагдан хорих асуудлыг шүүхийн зөвшөөрлийн үндсэн дээр явуулдаг байх тухай хуулийн төслийн үзэл баримтлал, олон улсын байгууллагын дүгнэлт, зөвлөмжид нийцнэ.<br><br>23.ЭХХШТХ-ийн 30.14 дүгээр зүйл. Хэрэг бүртгэлтийн хэргийг хаах.<br>"Хэрэг бүртгэлтийн хэргийг хаах саналтай прокурорт шилжүүлсэн хэргийн материалыг прокурор хоногийн 14 дотор хянах ба зайлшгүй тохиолдолд зохих дээд шатны прокурор энэ хугацааг тухай бүр 14 хүртэл хоногоор сунгаж болно" гэсэн заалт шинээр нэмэх.<br>ЭХХШТХ-ийн 30.14 дүгээр зүйлд хэрэг бүртгэлтийн хэргийг хаах саналтай шилжүүлсэн тохиолдолд прокуророос хянах, шийдвэрлэх хугацааг тодорхой заагаагүй тул хэргийг хянах хугацааг хуульд тусгах шаардлагатай. Мөн түүнчлэн олон хавтастай, олон хохирогчтой, ээдрээ төвөгтэй хэргийг хянах хугацааг сунгаж болох зохицуулалтыг нэмж тусгах шаардлагатай байна.<br><br>24.ЭХХШТХ-ийн 30 дугаар бүлэгт: "30.18.Хэрэг бүртгэлтийг түдгэлзүүлэх, сэргээх<br>1.Мөрдөгч хэрэг бүртгэлтийн хэрэгт гэмт хэрэг үйлдсэн хүнийг олж илрүүлэх бүхий л арга хэмжээг авах үүрэгтэй. | |

| | | | |
|---|---|---|---|
| | | 2.Хэрэг бүртгэлтийн хэрэгт хийгдвэл зохих ажиллагааг хийж шалгасан боловч 6 сарын хугацаанд яллагдагчаар татагдвал зохих этгээд нь тогтоогдоогүй бол мөрдөгч хэрэг бүртгэлтийн хэргийг түдгэлзүүлэх тухай саналыг прокурорт гаргана.<br>3.Прокурор энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан үндэслэл тогтоогдвол хэрэг бүртгэлтийг түдгэлзүүлнэ.<br>4.Хэрэг бүртгэлтийг түдгэлзүүлэх тухай тогтоолд дараах зүйлийг тусгана:<br>4.1.прокурорын нэр, албан тушаал;<br>4.2.түдгэлзүүлсэн он, сар, өдөр;<br>4.3.хэргийн дугаар, хэргийн утга;<br>4.4.хэрэг бүртгэлтийг түдгэлзүүлэх үндэслэл;<br>5.Мөрдөгч түдгэлзүүлсэн хэрэгт гэмт хэрэг үйлдсэн хүнийг олж тогтоохоор явуулсан эрэн сурвалжлах ажиллагааны үр дүнг прокуророос тогтоосон хугацаанд танилцуулна. 6.Энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан нөхцөл арилсан, эсхүл нэмэлт мөрдөн шалгах ажиллагаа явуулах шаардлагатай бол хэрэг бүртгэлтийг сэргээх тухай прокурор тогтоол гаргана.<br>7.Хэрэг бүртгэлтийг сэргээх тухай тогтоолд дараахь зүйлийг тусгана:<br>7.1.хэрэг бүртгэлтийг сэргээсэн прокурорын нэр, албан тушаал;<br>7.2.хэрэг бүртгэлтийг сэргээсэн үндэслэл;<br>7.3.хэрэг бүртгэлтийн хугацааг сунгуулахыг даалгах" гэж нэмэх.<br><br>ЭХХШТХ-ийн 30.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Хэрэг бүртгэлтийн үндсэн хугацаа нь хэрэг бүртгэлтийн хэрэг нээснээс хойш 1 сар байна.", 3 дахь хэсэгт "Хэрэг бүртгэлтийн хугацааг прокурор тухай бүр 3 сар хүртэл хугацаагаар сунгаж болно." гэж заасны дагуу гэмт хэрэг үйлдсэн хүн тогтоогдоогүй хэрэгт хэрэг бүртгэлтийн хугацааг ихэвчлэн тухай бүр 1 сараар сунган, мөрдөн шалгах ажиллагаа явуулж байна. Гэмт хэрэг үйлдсэн хүнийг эрэн сурвалжлахын тулд мөрдөгч харьяаллын бус мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллагад даалгавар бичих, байгаа газар нь мэдэгдэхгүй байгаа сэжигтнийг эрэн сурвалжлуулах ажиллагааг прокурорын даалгавраар явуулж, эрх бүхий байгууллага прокурорын шийдвэрийн дагуу эрэн сурвалжлах ажлыг зохион байгуулан, үр дүнг прокуророос тогтоосон хугацаанд танилцуулан ажиллаж байна.<br>Улсын хэмжээнд 2024 оны III улирлын байдлаар хэрэг бүртгэлтийн нийт 62,309 хэрэг шалгагдсаны 33,178 буюу 53.2 хувь нь 2024 онд шинээр нээсэн, 29,131 буюу 46.8 хувь нь өмнөх онуудад хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн хэргүүд байна. Хэрэг бүртгэлтийн ажиллагаанд 41,547 хэрэг шалгагдаж байгаагийн 2,846 буюу 6.8 хувь нь гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээд тодорхой, 11,342 буюу 27.2 хувь нь гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээдийг илрүүлэх боломжтой, 27,359 буюу 65.8 хувь нь гэмт хэрэг үйлдсэн хүн нь тодорхойгүй хэргүүд байна.<br>Мөрдөгч нарын ажлын ачаалал өндөр байгаа нь мөрдөн шалгах ажиллагаа явуулж буй хэрэг нэг бүрд хүрч ажиллах боломжгүй байдалд хүргэж байна. Нөгөөтэйгөөр, гэмт хэрэг үйлдсэн этгээд хэн болох нь тодорхойгүй хэрэгт хэрэг бүртгэлтийн хугацааг ач холбогдолгүй сунгах, хэрэг нэг бүрд ажиллагаа хийсэн байх шаардлагыг хангахын тулд гэрч, хохирогчийг нэг | |

асуудлаар удаа дараа дуудаж мэдүүлэг авч чирэгдэл учруулах зэргээр мөрдөн шалгах ажиллагааг үр дүн муутай явуулж байгаа нь эргээд ажлын бүтээмж, чанар үр нөлөөнд сөргөөр нөлөөлж байна. Үүнээс шалтгаалан бусад ээзэнтэй хэрэг нэг бүрд хүрч ажиллаж чадахгүй, мөрдөгч нар хэт их ажлын ачааллаас хамаарч ажлаас халшрах хам шинжид өртөж байгаа асуудал ихээр яригдаж байна.
Иймд гэмт хэрэг үйлдсэн этгээд хэн болох нь тодорхойгүй хэрэг бүртгэлтийн хэргийн хугацааг сунган шалгаад, гэмт хэрэг үйлдсэн хүн нь тогтоогдоогүй тохиолдолд хэрэг бүртгэлтийг түдгэлзүүлдэг байх. Прокурор хэргийг түдгэлзүүлэх шийдвэр гаргахдаа эрэн сурвалжлах тогтоол үйлдэж, тогтоосон хугацаанд биелэлт, үр дүнг тооцдог байх. Эрэн сурвалжлах ажиллагаагаар сэжигтнийг тогтоосны үндсэн дээр хэргийг сэргээж, шалгадаг зохицуулалтыг тусгах нь мөрдөгч, прокурорын ажлын бүтээмжид эерэг нөлөө үзүүлэхээр байна.

25.ЭХХШТХ-ийн 14.10 дугаар зүйлийн 5 дахь хэсэг: 5.Баривчлагдсан хугацааг цагдан хорих хугацаанд оруулж тооцно. Баривчлагдсан 24 цаг хүртэл хугацааг цагдан хоригдсон 1 хоногоор тооцно.
“5.Баривчлагдсан хугацааг цагдан хорих хугацаанд оруулан тооцох ба энэ зүйлийн 1-д заасан цагдан хорих үндсэн хугацаанаас хасаж тооцно. Баривчлагдсан 24 цаг хүртэл хугацааг цагдан хоригдсон 1 хоногоор тооцно" гэж өөрчлөн найруулах.
ЭХХШТХ-д баривчлагдсан хугацааг цагдан хорих хугацаанд оруулан тооцох талаар заасан боловч яллагдагчаар цагдан хорих эсэх асуудлыг шийдвэрлэхдээ, эсхүл шүүгдэгчид ял оногдуулахдаа тус хугацааг цагдан хоригдсон нийт хугацаанд оруулан тооцох эсэх нь тодорхой бус байдгаас хууль нэг мөр хэрэгжихгүй байна.
Тухайлбал, яллагдагчид цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах тухай шүүгчийн захирамжид яллагдагчийг "...-ээс эхлэн 1 сарын хугацаагаар" гэж, эсхүл "2024.08.05- ны өдрөөс эхлэн 2024.09.05 хүртэл 1 сарын хугацаагаар" гэж цагдан хорих хугацааг тогтоож, мөн шүүгчийн захирамжийн тогтоох хэсэгт "баривчлагдсан хугацааг цагдан хорих хугацаанд оруулан тооцсугай" гэж тусад нь заалт болгон бичдэг. Өөрөөр хэлбэл, цагдан хоригдсон хугацааг 1 сараар, улмаар тус хугацааг сунгах захирамжид цагдан хорих хугацааны сүүлийн хоногоос тооцон дуусах хугацааг тус тус зааж бичиж байгаагаас ЭХХШТХ-ийн 14.10 дугаар зүйлд заасан цагдан хорих нийт хугацааг сэжигтнээр баривчлагдсан хугацаагаар хэтрүүлэн яллагдагчийн эрхийг зөрчиж болзошгүй байдал үүсэж байна. Иймд сэжигтнээр баривчлагдсан хүнийг үргэлжлүүлэн яллагдагчаар цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах тухай саналыг шүүх шийдвэрлэхдээ баривчлагдсан хугацааг оруулан тооцох талаар тусгахаас гадна, сэжигтний баривчлагдсан хугацааг тухайн захирамжаар тогтоох хугацаанаас хасаж тооцон хугацаа дуусах сүүлчийн өдрийг захирамжид заах шаардлагатай байна.

26.ЭХХШТХ-ийн 30.15 дугаар зүйлд 3 дахь заалт нэмэх.
"3.Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан шийдвэр гаргах хугацааг зайлшгүй тохиолдолд дээд шатны прокурор 14 хүртэл хоногоор нэмж сунгаж болно." гэж нэмэх.

| | | | |
|---|---|---|---|
| | | Практикт олон холбогдогчтой, олон үйлдэлтэй, олон хавтастай хэргийг ажлын 3 хоногийн дотор бүрэн хянаж, шийдвэр гаргахад хүндрэл учирдаг. Энэхүү зохицуулалтыг нэмснээр мөрдөгчийн саналын дагуу прокурор хэргийг бүрэн хянаж, хууль зүйн үндэслэлтэй шийдвэр гаргах нөхцөлийг бүрдүүлнэ.<br><br>27.ЭХХШТХ-ийн 8.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг: 1.8.хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан, мөрдөн байцаалт дууссан бол хавтаст хэргээс өөрт хамааралтай хэсэгтэй танилцах, нэмэлт ажиллагаа хийлгэх тухай хүсэлт гаргах.<br>"1.8.хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан, мөрдөн байцаалт дууссан бол хавтаст хэргээс өөрт хамааралтай хэсэгтэй биечлэн, эсхүл цахимаар танилцаж, төр, байгууллага, хувь хүний нууцад хамаарахаас бусад нотлох баримтыг хуулбарлаж, хувилж авах эрхтэй;" гэж өөрчлөн найруулах.<br>ЭХХШТХ-ийн 8.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.8-д хохирогч нь хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан, мөрдөн байцаалт дууссан хэрэгтэй танилцаж, нэмэлт ажиллагаа хийлгэх хүсэлт гаргах эрхийг хуульчилсан. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд талууд тэгш эрхтэй оролцох зарчимтай. Хуулийн төсөлд яллагдагч хавтаст хэрэгтэй биечлэн болон цахимаар танилцах, нотлох баримт хуулбарлан авах болон бусад эрхийг хангах зохицуулалтууд тусгагдсан байна. Иймд хохирогч цахимаар хэргийн материалтай танилцах, нотлох баримт хуулбарлан авах эрхийг тусгах нь зүйтэй байна.<br><br>28.ЭХХШТХ-ийн 15.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэг: 1.Прокурор, оролцогч энэ хуулийн 12.3, 13.1, 13.2, 13.5, 13.7, 14.4, 14.5, 14.13, 19.2, 19.3 дугаар зүйл, 21.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 21.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан шүүхийн шийдвэрийг эс зөвшөөрвөл 3 хоногийн дотор гомдол гаргаж болно.<br>"1.эс зөвшөөрвөл гэсний дараа “ажлын" гэж нэмэх.<br>Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд заасан олон хоногоор амрах баярын өдрүүдтэй давхцах тохиолдолд гомдол гаргах хугацаа хэтэрч болзошгүй тул “ажлын” өдрөөр тооцох шаардлагатай.<br><br>29.ЭХХШТХ-ийн 34.18 дугаар зүйл: Хэргийг тусгаарлаж хэлэлцэх. Хэргийг тусгаарлах процессыг нэмж тусгах.<br>Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.18 дугаар зүйлд хэргийг тусгаарлах тохиолдлыг тусгасан атлаа тусгаарлах процессыг хуульчлаагүй байна. Үүнээс шалтгаалан хэргийн дугаарыг хэрхэн олгох, хэргийг прокурорт хүргүүлэх эсэх, давж заалдах болон хяналтын шатны шүүхээс зарим шүүгдэгчид холбогдох заалтыг хүчингүй болгосон тохиолдолд анхан шатны шүүх ямар ажиллагаа хийх зэргийг тодорхой болгох нь зүйтэй байна.<br><br>30.ЭХХШТХ-ийн 39.9 дүгээр зүйл. Давж заалдах шатны шүүхийн шийдвэр.<br>ЭХХШТХ-ийн 40.8 дугаар зүйл. Хяналтын шатны шүүхийн шийдвэр. | |

| | | | |
|---|---|---|---|
| | | 39.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт:"анхан шатны шүүхийн шийдвэрийг бүхэлд нь хүчингүй болгож, гэм буруугийн шүүх хуралдаанаар дахин хэлэлцүүлэх",<br>40.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт: "анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, гэм буруугийн шүүх хуралдаанаар дахин хэлэлцүүлэх" гэж тус тус нэмэх.<br>2022 оны 06 дугаар сарын 03-ны өдөр ЭХХШТХ-д орсон нэмэлт, өөрчлөлтийн үзэл баримтлалд нийцүүлэн хэргийг прокурорт буцаахгүйгээр, мөн хуулийн 34.16 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт зааснаар шүүх хуралдааныг 60 хүртэл хоногоор хойшлуулж, нэмэлт ажиллагаа хийхийг прокурорт даалгах нь зүйтэй. Давж заалдах болон хяналтын шатны шүүхээс анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгосон тохиолдолд хэргийг хэрхэх нь тодорхойгүй, урьдчилсан хэлэлцүүлэг, эсхүл прокурорт буцааж болохгүй, хориглосон хэм хэмжээг зөрчихөд хүргэж байна. Шүүхийн практикт давах, хяналтын шатны шүүх шийдвэрийг хүчингүй болгохдоо шийдвэрийнхээ тодорхойлох хэсэгт тусгасан хэлбэрээр шүүх өөрсдөө шийдэх, эсхүл шууд урьдчилсан хэлэлцүүлэг зарлан прокурорт буцааж байна. Өөрөөр хэлбэл, давж заалдах болон хяналтын шатны шүүхээс анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгохоор шийдвэрийнхээ тогтоох хэсэгт бичиж байгаа боловч анхан шатны шүүх хэргийг хүлээн аваад шууд урьдчилсан хэлэлцүүлэг хийснээр ЭХХШТХ-ийн 33.1 дүгээр зүйлийн 12 дахь заалтыг зөрчих, эсхүл албан бичгээр хэргийг прокурорт буцаах тохиолдол гарч байна.<br><br>31.ЭХХШТХ-ийн 25.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэг: 2.Арван найман насанд хүрээгүй гэрчээс мэдүүлэг авахад түүний хууль ёсны төлөөлөгч, эсхүл төрөл, садангийн хүн, сурган хүмүүжүүлэгчийг оролцуулах бөгөөд тэдэнд эрх, үүргийг нь тайлбарлан өгч, энэ тухай тэмдэглэлд тусгана.<br>“2.сурган хүмүүжүүлэгчийг гэсний дараа “шаардлагатай бол сэтгэл зүйчийг...” гэж нэмэх.<br>ЭХХШТХ-ийн 35.15 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт шүүх хуралдаанд арван найман насанд хүрээгүй гэрчийн мэдүүлгийг сонсохдоо сэтгэл зүйчийг оролцуулж болохоор хуульчилсан. Мөрдөн шалгах ажиллагааны явцад арван найман насанд хүрээгүй хүнээс мэдүүлэг авахдаа шаардлагатай тохиолдолд сэтгэл зүйч оролцуулах нь зүйтэй байна.<br><br>32.ЭХХШТХ-ийн 12.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг: 2.Мөрдөгч нь гэрч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, шинжээч, яллагдагчаас мэдүүлэг авах, шийдвэр танилцуулах, мөрдөн шалгах ажиллагаанд оролцуулах зайлшгүй шаардлагатай бол прокурорын мэдэгдэх хуудсаар дуудан ирүүлнэ.<br><br>ЭХХШТХ-ийн 12.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэг: 3.Гэрч, хохирогч, иргэний хариуцагч, шинжээч, яллагдагч, шүүгдэгч мэдэгдэх хуудсыг хүлээн авахаас зайлсхийсэн бол түүний өмгөөлөгч, эсхүл гэр бүлийн арван найман насанд хүрсэн гишүүнд хүргүүлнэ. "шинжээч" гэсний дараа "сэжигтэн" гэж тус тус нэмэх.<br>ЭХХШТХ-ийн 31.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт "Тогтоол танилцуулахаар сэжигтнийг дуудан ирүүлэхдээ 12.1 дүгээр зүйлд заасан журмыг баримтална." гэж заасан. Мөн хуулийн 12.1 дүгээр | |

| | | | |
|---|---|---|---|
| | | зүйлийн 2, 12.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт сэжигтнийг прокурорын мэдэгдэх хуудсаар дуудан ирүүлэх болон мэдэгдэх хуудсыг хүлээн авахаас зайлсхийсэн бол хэрхэх талаар тусгаагүй байна. | |
| 4. | Хүний эрхийн Үндэсний Комисс<br>2024.11.11<br>01/1761 | Танай яамнаас боловсруулан ирүүлсэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зарчмын хувьд дэмжиж байгаа бөгөөд дараах саналыг тусгуулахаар хүргүүлж байна. Үүнд:<br>1.Хуулийн төслийн 14.10 дугаар зүйлийн 5 дахь хэсгийг хасах, ерөнхий зохицуулалтаар буюу одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулийн заалтаар шийдвэрлэх;<br>2.Шүүхийн шатанд шүүгдэгчид цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авч хоригдсон хугацааг нийт цагдан хорьсон хугацаанд оруулан тооцохгүй байгаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.10 дугаар зүйлийн 12 дахь хэсгийг хасах. | Саналыг агуулгын хувьд тусгасан.<br>Хуулийн төслийн үзэл баримтлалд тусгагдаагүй асуудал байх тул 2 дахь саналыг тусгаагүй болно. |
| 5. | Авлигатай тэмцэх газар<br>2024.10.30<br>03/17554 | Таны 2024 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 1/1332 дугаартай албан бичгээр ирүүлсэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй танилцан, төсөлд тусгуулах саналыг хавсралтаар хүргүүлэв. Үүнд:<br>Нэг.Хуулийн төслийн 1 дүгээр зүйл 5 дахь хэсэгт “төр, байгууллага, хувь хүний нууцад” гэснийг Төрийн болон албаны нууцын тухай хууль, Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль батлагдан мөрдөгдөж байгаа тул нэр томьёог нэг мөр болгох шаардлагаар холбогдох хэсгийг өөрчлөх; Үүнд:<br>5.Мөрдөн байцаалт дууссан бол хэргийн бүх материалтай биечлэн, эсхүл цахимаар танилцаж, төрийн болон албаны нууц, байгууллагын нууц, хувь хүний эмзэг мэдээлэлд хамаарахаас бусад нотлох баримтыг хуулбарлаж, хувилж авах эрхтэй.” гэж өөрчлөх;<br>5/12.1 дүгээр зүйлийн 9 дэх хэсгийн “хаягийг” гэсний дараах “ашиглаж дуудаж” гэснийг “ашиглан дуудаж” гэж Хууль тогтоомжийн тухай хуулийн 30.1.3-т заасныг баримтлан өөрчлөх;<br>“9.Мөрдөгч нь хэргийн оролцогчийн хүсэлтээр төрийн байгууллага, албан тушаалтны албаны цахим шуудан, албан бичиг солилцооны дундын систем, мэдэгдэл хүргэх систем, мөн иргэний төрийн үйлчилгээний нэгдсэн систем, мэдэгдэл хүргэх системд иргэний үүсгэсэн, бүртгүүлсэн цахим шуудан, тухайн этгээдийг таньж, баталгаажуулах боломжтой бусад цахим системд бүртгүүлэн холбогдсон хаягийг ашиглан дуудаж, прокурорын мэдэгдэх хуудсыг хүргүүлж болно.” | Саналыг агуулгын хувьд тусгасан |

| | | | |
|---|---|---|---|
| | | 8/14.13 дугаар зүйлийн 14 дэх хэсгийн “шийдвэрийг цахим мэдээллийн сүлжээгээр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад” гэснийг “сүлжээг ашиглан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад болон холбогдох төрийн байгууллага, хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтанд” гэж өөрчлөх;<br><br>“14.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч үед энэ хуулийн 14.1 дүгээр зүйлийн 1.2, 1.3, 1.5-д заасан таслан сэргийлэх арга хэмжээ авах, өөрчлөх, хүчингүй болгох, хүсэлт болон хугацааг сунгасан шүүхийн шийдвэрийг мөрдөгч, прокурорт мэдэгдэх бөгөөд шүүхийн шийдвэрийг цахим мэдээллийн сүлжээг ашиглан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад болон холбогдох төрийн байгууллага, хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтанд даруй хүргүүлнэ.”<br><br>10/16.3 дугаар зүйлийн 10-11 дэх хэсэг:<br><br>“10.Гэрчээр мэдүүлэг авч байх үед гэмт хэрэгт сэжиглэх үндэслэл илэрвэл мэдүүлэг авах ажиллагааг зогсоож, сэжигтнээр мэдүүлэг авах ажиллагааг энэ хуульд заасны дагуу явуулна.” гэжээ.<br><br>Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31.2 дугаар зүйлийн 1-д “Энэ хуульд заасны дагуу баривчлагдсан, эсхүл яллагдагчаар татах тогтоолтой танилцуулахаар мэдэгдэх хуудсаар дуудагдсан хүнийг сэжигтэн гэнэ.” гэж заасан. Хэрэв дээр дурьдсанаар хуулийн 16.3 дугаар зүйлийн 10-т өөрчлөлт оруулахаар бол одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн 31.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зохих өөрчлөлт оруулах шаардлагатай болно. Тухайлбал, “31.2 дугаар зүйл.Эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоол үйлдсэний дараа хийгдэх ажиллагаа.<br>1.Энэ хуульд заасны дагуу баривчлагдсан, эсхүл яллагдагчаар татах тогтоолтой танилцуулахаар мэдэгдэх хуудсаар дуудагдсан, эсхүл энэ хуулийн 16.3.10 дахь хэсэгт заасан үндэслэлээр сэжигтнээр мэдүүлэг өгөх хүнийг сэжигтэн гэнэ." гэж өөрчлөн найруулах;<br><br>“11.Дүрс харж ярих боломжтой технологи, мэдээллийн хэрэгсэл ашиглан мэдүүлгийг авч болно. Энэ тохиолдолд өмгөөлөгч, хууль ёсны төлөөлөгч, асран хамгаалагчийн оролцоог ханган дуу-дүрсний бичлэгээр бэхжүүлж, хавтаст хэрэгт хавсаргана.” гэжээ. Олон түмнийг нийтлэл, нэвтрүүлгийн тусламжтайгаар үнэн бодитой мэдээллээр шуурхай, тогтмол хангах зорилго бүхий тогтмол хэвлэл, радио, телевиз, мэдээллийн агентлаг, баримтат кино, цахим хэвлэл зэрэг мэдээллийн сувгийг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл гэж нэрлэдэг. Иймд “технологи” гэсний дараахь “мэдээллийн хэрэгсэл” гэснийг “цахим харилцаа холбооны хэрэгсэл” гэж өөрчлөх;<br><br>11.Дүрс харж ярих боломжтой технологи, цахим харилцаа холбооны хэрэгсэл ашиглан мэдүүлгийг авч болно. Энэ тохиолдолд өмгөөлөгч, хууль ёсны төлөөлөгч, асран хамгаалагчийн оролцоог ханган дуу-дүрсний бичлэгээр бэхжүүлж, хавтаст хэрэгт хавсаргана.” | |

| | | | |
|---|---|---|---|
| | | 11/16.14 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг:<br>"5.Мөрдөн шалгах ажиллагааны явцад гэрч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, шинжээч, сэжигтэн, яллагдагчаас мэдүүлэг авахад бэхжүүлсэн дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн хувийг хавтаст хэргийн хамт хадгална." гэжээ. Мэдүүлэг бүрийн бичлэгийг хэрэгт хадгалах боломжгүй тул "дуу-дүрсний" гэсний дараахь "...бичлэгийн хувийг хавтаст хэргийн хамт хадгална." гэснийг "бичлэгийн хувийг хэргийг шийдвэрлэх хугацаанд мөрдөх байгууллагад хадгална." гэж өөрчлөх.<br>"5.Мөрдөн шалгах ажиллагааны явцад гэрч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, шинжээч, сэжигтэн, яллагдагчаас мэдүүлэг авахад бэхжүүлсэн дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн хувийг хэргийг шийдвэрлэх хугацаанд мөрдөх байгууллагад хадгална.<br>14/ 32.9 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг:<br>"3.Яллагдагчаар татах тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулж, яллагдагчаар татах тогтоолд оруулсан өөрчлөлтийг яллагдагчид танилцуулж, хувийг гардуулна." гэснийг хасах;<br>2 дугаар зүйлийн 2/7.5 дугаар зүйлийн 4 дэх хэсэг:<br>"4.Яллагдагч шинжээч томилсон тогтоол, шинжээчийн дүгнэлттэй танилцах, мөрдөн байцаалт дууссаны дараа хавтаст хэргийн материалтай танилцаж, төр, байгууллага, хувь хүний нууцад хамаарахаас бусад нотлох баримтыг дууны, дүрсний болон бусад техник хэрэгсэл ашиглан өөрийн зардлаар хуулбарлаж, хувилж авах эрхтэй." гэжээ.<br>Төрийн болон албаны нууцын тухай хууль, Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль батлагдан мөрдөгдөж байгаа тул нэр томьёог нэг мөр болгох шаардлагаар "төр, байгууллага, хувь хүний нууцад" гэснийг "төрийн болон албаны нууц, байгууллаганы нууц, хувь хүний эмзэг мэдээлэлд" гэж өөрчлөх;<br>4. Яллагдагч шинжээч томилсон тогтоол, шинжээчийн дүгнэлттэй танилцах, мөрдөн байцаалт дууссаны дараа хавтаст хэргийн материалтай танилцаж, төрийн болон албаны нууц, байгууллагын нууц, хувь хүний эмзэг мэдээлэлд хамаарахаас бусад нотлох баримтыг дууны, дүрсний болон бусад техник хэрэгсэл ашиглан өөрийн зардлаар хуулбарлаж, хувилж авах эрхтэй."<br>3/14.13 дугаар зүйлийн 5 дахь хэсэг:<br>"5.Прокурор, яллагдагч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн гаргасан санал, хүсэлтийн үндэслэлд хамаарах баримт, мэдээллийг шүүх хэргийн оролцогчид танилцуулж, тэдгээрт тайлбар хийх, холбогдох баримт, мэдээллийг гаргаж өгөх боломжоор хангана. Талуудад танилцуулагдаагүй баримт, мэдээлэл нь шүүхийн шийдвэрийн үндэслэл болохгүй." гэжээ. | |

Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн 14.13 дугаар зүйлийн "5. Прокурор, яллагдагч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч гаргасан санал, хүсэлтийнхээ хууль зүйн үндэслэл, түүний нотлох баримтыг шүүх, шүүхийн хэлэлцүүлэгт оролцогчид танилцуулна." гэснийг хэвээр үлдээж, өөрчлөлт оруулах саналын нэг дэх өгүүлбэрийг хасч, "Талуудад танилцуулагдаагүй баримт, мэдээлэл нь шүүхийн шийдвэрийн үндэслэл болохгүй." гэснийг хэвээр үлдээх;

"5.Талуудад танилцуулагдаагүй баримт, мэдээлэл нь шүүхийн шийдвэрийн үндэслэл болохгүй."

4/31.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

"1.Мөрдөгч эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолыг прокуророос хүлээн авсан даруй дуудан ирүүлсэн сэжигтэнд танилцуулж, хувийг гардуулан өгнө. Төрийн нууцад хамаарах хэргийн яллагдагчаар татах тогтоолыг яллагдагч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчид гардуулахгүйгээр танилцуулна."

Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн 31.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг хэвээр үлдээх. Өөрчлөн найруулах саналыг дэмжихгүй.

5/32.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг:

"3.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан оролцогч хэргийн материалтай 14 хүртэл хоногийн хугацаанд танилцах ба мөрдөгч хэргийн материалтай танилцах боломж, нөхцөлийг бүрдүүлнэ. Хавтаст хэргийн тоо, хэргийн оролцогчдын тооноос хамааран хэргийн материалтай танилцах хугацааг мөрдөгч 14 хүртэл хоногоор сунгаж болно."

Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн "32.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг хэвээр үлдээх. Өөрчлөн найруулах саналыг дэмжихгүй.

7/ 32.10 дугаар зүйлийн 6 дахь хэсэг:

"6.Прокурор хэргийг шүүхэд шилжүүлэхээс ажлын 3-аас доошгүй хоногийн өмнө яллах дүгнэлтийг яллагдагчид гардуулж, энэ талаар түүний хууль ёсны төлөөлөгч, хохирогч, өмгөөлөгчид мэдэгдэнэ." гэсний "ажлын 3-аас доошгүй хоногийн" гэснийг "ажлын 3-аас доошгүй өдрийн" гэж өөрчлөх;

6.Прокурор хэргийг шүүхэд шилжүүлэхээс ажлын 3-аас доошгүй өдрийн өмнө яллах дүгнэлтийг яллагдагчид гардуулж, энэ талаар түүний хууль ёсны төлөөлөгч, хохирогч, өмгөөлөгчид мэдэгдэнэ."

3 дугаар зүйл.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай 32.1 дүгээр зүйлийн 9 дэх хэсгийн "тухайн ажиллагаанд холбогдох оролцогчид танилцуулна." гэснийг "энэ зүйлд заасан журмын дагуу оролцогчид танилцуулна." гэж, ....өөрчилсүгэй.

| | | | |
|---|---|---|---|
| | | Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн 32.1 дүгээр зүйлийн 9 дэх хэсгийг хэвээр үлдээх. Өөрчлөлтийг дэмжихгүй.<br>Хоёр.Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31.14 дүгээр зүйлд 1.5 дахь заалт нэмэх;<br>“1.5 Шаардлагатай гэрч, хохирогч, сэжигтэн, яллагдагч Монгол улсын хилээр гарсан нь эрх бүхий байгууллагын лавлагаа, мэдээллээр тогтоогдсон бол.”<br>Гурав.Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн “6.2 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг дараах байдлаар өөрчлөн найруулах:<br>“2.11.прокурорын даалгавраар мөрдөн шалгах ажиллагаа явуулах, даалгаврыг эс зөвшөөрвөл хүлээн авснаас хойш ажлын 3 өдрийн дотор тухайн прокурорын газрын дээд шатны прокурорт, тухайн прокурорын газрын дээд шатны прокурорын шийдвэрийг эс зөвшөөрвөл дээд шатны прокурорт саналаа тус тус бичгээр нэг удаа гаргах;” | |
| 6. | Тагнуулын ерөнхий газар<br>2024.10.31<br>ТЕГ 01/370 | Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эрүүгийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох үүрэг бүхий байнгын ажиллагаатай ажлын хэсгийн хуралдаанд хэлэлцэх үеэр тус газраас оролцож төрийн нууцад хамаарах мэдээлэл агуулсан прокурор, шүүхийн шийдвэрийг гардуулахтай холбоотой болон бусад саналаа өгсөн.<br>Бидний өгсөн санал төсөлд туссан байна. Гагцхүү төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “төр, байгууллага, хувь хүний нууц"-аас гадна албаны нууцын талаар нэмж тусгах нь зүйтэй гэж үзэж байна. | Саналыг агуулгын хувьд тусгасан |
| 7. | Цагдаагийн ерөнхий газар<br>2024.10.22<br>2/348 | Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй танилцаж, дараах саналыг тусгуулахаар хүргүүлэв. Үүнд:<br>1.Төслийн мөн зүйлийн 7 дахь заалтын "14.10 дугаар зүйлийн 14 дэх хэсэг"-ийн "эсэхийг" гэсний дараа "мөрдөгч, прокурорын саналыг үндэслэн" гэж нэмэх;<br>2.Төслийн мөн зүйлийн 8 дахь заалтын "14.13 дугаар зүйлийн 13 дахь хэсэг"-ийн "баримтыг" гэсний дараа "хүлээн авч" гэж нэмэх;<br>3.Төслийн мөн зүйлийн 10 дахь заалтын "16.3 дугаар зүйлийн 10 дахь хэсэг"-ийн "сэжигтнээр мэдүүлэг авах ажиллагааг" гэсний дараа "үргэлжлүүлэн" гэж нэмэх;<br>4.Төслийн мөн зүйлийн 14 дэх заалтын "32.9 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг"-ийн "хувийг гардуулна." гэснийг хасах;<br>5.Төслийн мөн зүйлийн 16 дахь заалтын "33.3 дугаар зүйлийн 1.4 дэх заалт"-ыг хасах; | Саналыг агуулгын хувьд тусгасан.<br><br>Хэрэг бүртгэлтийн хэргийг түдгэлзүүлэх, сэргээх асуудал хуулийн төслийн үзэл баримтлалд тусгагдаагүй байх тул саналыг тусгаагүй болно. |

| | | | |
|---|---|---|---|
| | | 6.Төслийн 2 дугаар зүйлийн "2.12 дахь заалт"-ын "таслан сэргийлэх арга хэмжээ авах үндэслэл болсон мөрдөгч, прокурорын санал, шийдвэрийн үндэслэлд хамаарах баримт, мэдээлэлтэй танилцах" гэснийг хасах;<br>7.Төслийн мөн зүйлийн "7.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэг"-ийн "шийдвэрийн хувийг авах" гэснийг хасах;<br>8.Төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалтын "14.13 дугаар зүйлийн 5 дахь хэсэг"- ийн "үндэслэл болохгүй" гэсний дараа "бөгөөд мөрдөн шалгах нууц ажиллагааны баримт нь үүнд хамаарахгүй." гэж нэмэх;<br>9.Төслийн мөн зүйлийн 4 дэх заалтын "31.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг"-ийн "хувийг гардуулан өгнө." гэснийг хасах;<br>10.Төслийн мөн зүйлийн 6 дахь заалтын "32.2 дугаар зүйлийн 6 дахь хэсэг"-ийн "хамт" гэсний дараа "ажлын" гэж нэмэх;<br>11.Төсөлд "Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 5.1 дүгээр зүйл"-д дор дурдсан агуулгатай хэсэг нэмэх;<br>"6.Өмгөөлөгч энэ зүйлд заасан үндэслэл журмын дагуу хуулбарлан авсан эсхүл өмгөөллийн үйл ажиллагааны явцад мэдсэн баримт, мэдээллийг бусдад дамжуулах, нууцлалыг задруулахгүй байх үүрэгтэй.".<br>12.Төсөлд "Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 7.3 дугаар зүйл"-д дор дурдсан агуулгатай хэсэг нэмэх;<br>"6. Яллагдагч энэ зүйлийн 5-д заасан үндэслэл журмын дагуу хуулбарлаж авсан нотлох баримт, мэдээллийг бусдад дамжуулах, нууцлалыг задруулахгүй байх үүрэгтэй.".<br>13.Төсөлд "Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 7.5 дугаар зүйл"-д дор дурдсан агуулгатай хэсэг нэмэх;<br>"5. Яллагдагч шинжээч томилсон тогтоол, шинжээчийн дүгнэлт, мөрдөн байцаалт дууссаны дараа хавтаст хэргийн материалыг хүний эрх, эрх чөлөөг зөрчиж, олон нийтэд түгээх үндэслэл бүхий сэжиг байгаа тохиолдолд мөрдөгч, прокурор нь хуулбарлан өгөхөөс татгалзаж болно.".<br>14.Төсөлд "Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн Гучдугаар бүлэгт сэжигтний эрх, хувийн байдлыг тогтоох, сэжигтнээс мэдүүлэг авах, хэрэг бүртгэлтийн хэргийг түдгэлзүүлэх, сэргээх зохицуулалт"-ыг нэмж тусгаж, дараах агуулгатай зүйл, заалт нэмэх;<br>"30.7[1] дүгээр зүйл.Сэжигтэн<br>1.Гэмт хэрэг үйлдсэн гэж буруутгагдаж байгаа хүнийг сэжигтэн гэнэ.<br><br>30.7[2] дугаар зүйл.Сэжигтний эрх<br>1.Сэжигтэн дараах эрхтэй:<br>1.1.ямар хэрэгт сэжиглэгдэж байгааг мэдэх; | |

| | | | |
|---|---|---|---|
| | | 1.2.энэ хуулийн 7.4, 7.5, 7.6, 7.7-д заасан эрхийг тус тус эдлэх;<br>1.3. хуульд заасан бусад.<br>30.7[3] дугаар зүйл. Хувийн байдлыг тогтоох<br>1.Мөрдөгч сэжигтний хувийн байдлыг тогтоох зорилгоор дараах ажиллагааг явуулна:<br>1.1.хувийн бичиг баримтыг шалгах, шаардлагатай тохиолдолд хувийн байдлын талаар нэмэлт мэдээлэл авах;<br>1.2.гэрэл зураг, эсхүл дүрсний, дуу-дүрсний бичлэгээр нүүр царай, биеийн төрх байдлыг бэхжүүлэх;<br>1.3.хуруу, алганы хээ, эсхүл бусад хэв загварыг бэхжүүлэх;<br>1.4.шаардлагатай бол шинжилгээнд зориулж биеэс нь биологийн дээж авах;<br>1.5.биед үзлэг хийх;<br>1.6.харьцуулсан шинжилгээ хийх.<br>2.Хувийн байдлыг нь тогтооход саад учруулбал мөрдөгч холбогдох хуульд заасан үндэслэл, журмын дагуу албадлага хэрэглэнэ.<br>3.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хувийн байдлыг тогтоосон мэдээллийг хавтаст хэрэгт тусгана.<br><br>30.7[4] дугаар зүйл.Сэжигтнээс мэдүүлэг авах<br>1.Мөрдөгч сэжигтнээс мэдүүлэг авахын өмнө түүнд ямар хэрэгт холбогдуулан мэдүүлэг авч байгаа талаар танилцуулж, дараах эрхийг тайлбарлана:<br>1.1.өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх;<br>1.2.өөрийгөө өмгөөлөх, өмгөөлөгч сонгон авах;<br>1.3.өмгөөлөгчтэй ганцаарчлан уулзах, өмгөөлөгч байлцуулан мэдүүлэг өгөх;<br>1.4.эх хэлээрээ, эсхүл өөрийн сайн мэдэх хэлээр мэдүүлэг өгөх;<br>1.5.орчуулагч, хэлмэрчийн туслалцааг авах;<br>1.6.мэдүүлэг өгөхөөс татгалзах;<br>1.7.мөрдөгч, прокурор, орчуулагч, хэлмэрчээс татгалзах;<br>1.8.энэ хуулийн Долдугаар бүлэгт заасан бусад эрх.<br>2.Сэжигтнээс мэдүүлэг авахад энэ хуулийн 25.1, 25.2, 25.3 дугаар зүйлд заасан журмыг баримтална.<br>3.Сэжигтний сонгон авсан өмгөөлөгч 2 цагийн дотор хүрэлцэн ирээгүй, эсхүл өмгөөлөгч авахаас татгалзсан бол энэ хуулийн 5.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу өмгөөлөгч оролцуулна. | |

| | | | |
|---|---|---|---|
| | | 4.Баривчлагдсан өсвөр насны сэжигтнээс мэдүүлэг авахад энэ хуулийн 25.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 25.3 дугаар зүйл, энэ зүйлд заасан журмыг баримтална.<br>30.18.Хэрэг бүртгэлтийн хэргийг түдгэлзүүлэх, сэргээх<br>1.Прокурор нь мөрдөгчийн саналыг үндэслэлтэй гэж үзвэл дараах тохиолдолд хэрэг бүртгэлтийг түдгэлзүүлнэ:<br>1.1.хэрэг бүртгэлтийн хэрэгт хийгдвэл зохих бүхий л ажиллагаа хийгдсэн боловч яллагдагчаар татагдвал зохих этгээд нь тогтоогдоогүй бол;<br>1.2.яллагдагчаар татагдвал зохих этгээд Монгол Улсаас гарч явсан нь тогтоогдсон бол;<br>1.3.зайлшгүй шаардлагатай гэрч, хохирогч хаана байгаа газар нь тогтоогдохгүй бол;<br>1.4.өөр хэргийг шийдвэрлэхгүйгээр хэргийг шийдвэрлэх боломжгүй бол.<br>2.Хэрэг бүртгэлтийн хэргийг түдгэлзүүлэхийн өмнө мөрдөгч нь гүйцэтгэж болох бүх ажиллагааг явуулах, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг олж илрүүлэх бүх арга хэмжээг авах үүрэгтэй.<br>3.Хэрэг бүртгэлтийн хэргийг түдгэлзүүлэх тухай тогтоолд энэ хуулийн 31.14 дүгээр зүйлийн 4 дэх зүйлийг баримтална.<br>4.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан нөхцөл арилсан, эсхүл нэмэлт мөрдөн шалгах ажиллагаа явуулах шаардлагатай бол хэрэг бүртгэлтийг сэргээх тухай прокурор тогтоол гаргана.<br>5.Хэрэг бүртгэлтийн хэргийг сэргээх тухай тогтоолд энэ хуулийн 31.14 дүгээр зүйлийн 6 дахь зүйлийг баримтална.".<br>15.Төсөлд "Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31.10, 31.11 дүгээр зүйл"-ийг тус тус хасах;<br>16.Төсөлд "Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг"-т дор дурдсан агуулгатай заалт нэмэх;<br>"1.4.яллагдагч Монгол Улсаас гарч явсан нь тогтоогдсон бол.".<br>17.Төсөлд "Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31.13 дугаар зүйл"- д дор дурдсан агуулгатай хэсэг нэмэх;<br>"7.Энэ хуулийн 32.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан хугацаа нь мөрдөн байцаалтын хугацаанд тооцогдохгүй.". | |
| 8. | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар<br>2024.11.04<br>01/2786 | Таны 2024 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 1/1332 тоот албан бичгээр ирүүлсэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, холбогдох материалтай танилцаад дараах саналтай байна. Үүнд:<br>1. Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.3-т "үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих" гэж заасан шаардлагад нийцүүлэн хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1/5.1 дүгээр зүйлийн 2.7 дахь заалтын "хуулбарлан" гэсний өмнө "нотлох баримт" гэж, 6/14.10 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн "гэмт хэрэг" гэсний өмнө "дахин" | Саналыг агуулгын хувьд тусгасан |

| | | | |
|---|---|---|---|
| | | гэж тус тус нэмэх. Мөн Төрийн болон албаны нууцын тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд нийцүүлэн хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 3/7.3 дугаар зүйлийн 5 дахь хэсэг болон 3 дугаар зүйлийн 2/7.5 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн "төр, байгууллага, хувь хүний нууцад" гэснийг "төрийн болон албаны нууц, хүний хувийн мэдээлэлд" гэж өөрчлөх.<br>2. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 8/14.13 дугаар зүйлийн 14 дэх хэсэгт эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч үед "тодорхой үйл ажиллагаа явуулах, албан үүргээ биелүүлэхийг түдгэлзүүлэх" таслан сэргийлэх арга хэмжээг авах, өөрчлөх, хүчингүй болгох, хүсэлт болон хугацааг сунгасан шүүхийн шийдвэрийг цахим мэдээллийн сүлжээгээр шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад даруй хүргүүлэх гэж шинээр тусгасан байна. Тус зохицуулалт нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.4 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт "Тодорхой үйл ажиллагаа явуулах, албан үүргээ биелүүлэхийг түдгэлзүүлэх таслан сэргийлэх арга хэмжээний хугацаа дууссан, эсхүл уг арга хэмжээг хүчингүй болгосон, өөрчилсөн шүүхийн шийдвэр гарсан бол прокурор, эсхүл мөрдөгч уг шийдвэрийг яллагдагч болон холбогдох байгууллага, хуулийн этгээдэд даруй хүргүүлнэ." гэж заасантай нийцэхгүй байна. Түүнчлэн, 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулиар тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.3-т "хязгаарлалт ТОГТООХ тухай шүүгчийн захирамж"-ийг хэрэгжүүлэхээр нэмэлт орсон бөгөөд 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө. Өөрөөр хэлбэл, эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг сэжигтнийг баривчлах, яллагдагчийг цагдан хорих, хязгаарлалт тогтоох тухай шүүгчийн захирамжийг үндэслэн гүйцэтгэхээр хуульчилсан ба харин тодорхой үйл ажиллагаа явуулах, албан үүргээ биелүүлэхийг түдгэлзүүлэх таслан сэргийлэх арга хэмжээг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хэрэгжүүлэх нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн үзэл баримтлалд нийцэхгүй байх тул Хууль тогтоомжийн 29 дүгээр зүйлийн 29.1-д заасан хууль тогтоомжийн төслийн агуулгад тавигдах шаардлагад нийцүүлэн хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 8/14.13 дугаар зүйлийн 14 дэх хэсгийн "1.2," гэснийг хасах.<br>3. Улсын Их Хурлын 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 153 дугаар зүйлийн 153.1 дэх хэсэгт "Хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн этгээд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад хүрэлцэн ирээгүй нь шүүхийн шийдвэрийг хүлээн авах, эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хэрэг үүсгэхэд саад болохгүй" гэж, 185 дугаар зүйлийн 185.1 дэх хэсэгт "Холбогдох этгээд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад хүрэлцэн ирээгүй нь албадлагын арга хэмжээ авсан шүүхийн шийтгэх тогтоолыг хүлээн авахад саад болохгүй" гэж тус тус нэмэлт оруулсан бөгөөд тус хуулийн дагуу шүүхээс ял, албадлагын арга хэмжээ авагдсан боловч оргон зайлсан, шийдвэрээ гардаж аваагүй, оршин суух хаяг нь тодорхойгүй 840 хүний материалыг хүлээн авч, эрүүгийн | |

| | | | |
|---|---|---|---|
| | | шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдаж байна. Гэтэл хуулийн төслийн 1 зүйлийн 17/34.9 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт шинээр тусгасан зохицуулалтад шүүгдэгч шүүхийн хэлэлцүүлэгт мэдүүлэг өгөх эсэх эрхээ эдэлсний дараа хүндэтгэн үзэх шалтгаангүй шүүх хуралдаанд оролцохоос санаатай зайлсхийсэн тохиолдолд түүнийг эзгүйд шүүх хуралдааныг үргэлжлүүлэн явуулж, шүүгдэгч гэм буруутай эсэхийг эцэслэн шийдвэрлэж болохоор тусгасан нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хүндрэл учруулах, ачаалал нэмэх тул дахин нягталж найруулах, эсхүл хасах. Түүнчлэн, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.9 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт "Шүүх хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй шүүгдэгчийг албадан ирүүлэх, түүнд энэ хуульд заасан таслан сэргийлэх арга хэмжээ авах, өөрчлөх шийдвэр гаргаж болно" гэж заасан байгааг анхаарах.<br>4. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 24/39.1 дүгээр зүйлийн 9 дэх хэсэгт шинээр тусгасан зохицуулалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1-д "... хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна" гэж, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 39.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт "Шүүх давж заалдсан гомдол, эсэргүүцэлд заасан асуудлаар хязгаарлахгүй ба ..." гэж тус тус заасантай зөрчилдөж байх тул хасах.<br>5. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 3 дугаар зүйлд "Баривчлах шийтгэл оногдуулсан шүүхийн шийдвэрийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд нийслэлд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, аймаг, суманд цагдаагийн байгууллага гүйцэтгэнэ. Цагдаагийн байгууллага баривчлах шийтгэл оногдуулсан шүүхийн шийдвэрийг биелүүлэх чиг үүргийг энэ зүйлд заасан хугацааны дотор үе шаттайгаар шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагад шилжүүлнэ." гэж заасныг хэрэгжүүлэхэд санхүүгийн асуудлыг шийдвэрлэх, бэлтгэл ажлыг хангах шаардлагатай байх тул "2025 оны" гэснийг "2027 оны" гэж өөрчлөх саналтай байгааг илтгэн танилцуулъя. | |
| 9. | Монголын хуульчдын холбоо<br>2024.10.28<br>1/971 | Танаас 1/1332 дугаартай албан бичгээр ирүүлсэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй танилцлаа. Тус хуулийн төсөлд хуульчдаас ирүүлсэн саналыг нэгтгэн хүргүүлж байна. Үүнд:<br>1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.1 дүгээр зүйлийн 12 дахь хэсэг буюу урьдчилсан хэлэлцүүлгээр энэ зүйлийн 6 дахь хэсгийн 6.13 дах заалтад заасан нотлох баримт цуглуулж, бэхжүүлэх талаар хуульд заасан журам зөрчигдсөн талаар, 6.14 дэх заалтад заасан хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад оролцогчийн эрхийг зөрчсөн, хууль бусаар хязгаарласан, 6.15 дах заалтад заасан мөрдөн шалгах ажиллагаа нэмж хийлгэх хүсэлтийг шийдвэрлэх боломжгүй бол хэлэлцэхгүй орхиж, анхан шатны шүүх хуралдаанаар уг асуудлыг шийдвэрлэнэ гэдэг заалтыг боловсронгуй болгож, энэ талаарх хүсэлт (цахимаар болон цаасаар) дээр талууд эсрэг байр суурьтай бол хүсэлтийг хэлэлцэхгүй орхих гэсэн өөрчлөлт оруулах; | Саналыг агуулгын хувьд тусгасан |

| | | | |
|---|---|---|---|
| | | 2. Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг хийгдэх болсон шалтгаан, үндэслэлийн талаар талуудад цахим хэлбэрээр урьдчилан мэдэгдэх, бэлтгэх боломжийг хангах, зохицуулалт нэмэх;<br>3. Шүүхээс прокурорт хэрэг буцаах зохицуулалтыг эргэн харж, байгаа нотлогдсон хэмжээнд хэргийг шийдвэрлэх үзэл санааг бататгах;<br>4. Урьдчилсан хэлэлцүүлгийн товыг прокурор, өмгөөлөгчийн цахим саналыг харгалзан тогтоож байх хуулийн заалтыг хэрэгжүүлэх, урьдчилсан хэлэлцүүлэг явуулах тухай өмгөөлөгч, оролцогчдын гомдол, хүсэлт, шүүгчийн захирамжийг прокурорт заавал цахим хэлбэрээр хүргүүлдэг байх, шүүх өөрийн санаачлагаар урьдчилсан хэлэлцүүлэг явуулах хууль зүйн үндэслэл тодорхойгүй байдгийг шийдвэрлэх;<br>5. ЭХХШТХ-д яллагдагчийг шүүхэд шилжүүлэх хэсэгт шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг явуулах талаар гомдол, хүсэлтэд тавигдах шаардлага, үндэслэлийг тодорхой болгох.<br>6. Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгт мэтгэлцэх зарчмыг бодитой хэрэгжүүлэх үүднээс оролцогч талуудаас гаргасан цахимаар болон бичгээр гаргасан хүсэлт болон шүүгч өөрийн санаачилгаар явагдах хэлэлцүүлгийн үндэслэл, шалтгаан, түүнтэй холбоотой баримт сэлтийг цахим хэлбэрээр харилцан танилцах боломжоор хангах зохицуулалтыг нэмж тусгах. Өөрөөр хэлбэл, шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгт бэлтгэх, оролцогчдын гаргасан гомдол, хүсэлт түүнтэй холбоотой үйл баримт, хууль зүйн фактгай цахим хэлбэрээр танилцах, хариу няцаалт бэлтгэх боломжийг агуулсан журмыг тусгах;<br>7. Шүүхийн өмнөх болон шүүхийн үе шатанд цахим хэлбэрээр хүсэлт гаргах, хариу өгөх, харилцах боломжоор хангах нь зүйтэй байна. Өнөөгийн байдлаар эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх бүх ажиллагааг цаасан хэлбэрээр явуулж байгаа бөгөөд мөрдөгч, прокурор, шүүгчийн ажлын ачааллын үндсэн шалтгаан болж байна. Иймээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэгчид шийдвэрээ цахим хэлбэрээр баталгаажуулах, хүргүүлэх хэрэгт хавсаргах талаар зохицуулалт нэмэх зэрэг болно. | |
| 10. | Монголын Өмгөөлөгчдийн Холбоо<br>2024.11.27<br>01/1225 | 1.5.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “хохирогч,” гэсний дараа “гэрч,” гэж нэмэх.<br>5.1 дүгээр зүйл.Өмгөөлөгчийн эрх, үүрэг<br>1.Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан, хохирогч, гэрч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, хууль зүйн туслалцаа авах эрхээр хангах зорилгоор эрүүгийн хянан хэрэг шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгчийг оролцуулна.<br><br>2.9.6 дугаар зүйлд 9 дэх хэсэг нэмэх.<br>9.6 дугаар зүйл. Гэрч.<br>9.Хүнийг гэмт хэрэгт сэжиглэх үндэслэл байгаа бол түүнийг гэрчээр дуудах, түүнээс гэрчийн мэдүүлэг авахыг хориглоно.<br><br>3.16.3 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт 4.7 дахь заалт нэмэх.<br>16.3 дугаар зүйл. Мэдүүлэг.<br>4. Дараах хүнээс гэрчийн мэдүүлэг авч болохгүй; | Саналыг тусгасан |

4.7.гэмт хэрэгт буруутгах илэрхий үндэслэл байгаа хүн.

4.16.3 дугаар зүйлд 10 дахь хэсэг нэмэх.
16.3 дугаар зүйл.Мэдүүлэг.
10.Гэрчийн мэдүүлэг авах үед түүнийг гэмт хэрэгт сэжиглэх үндэслэл илэрсэн бол мэдүүлэг авах ажиллагааг даруй зогсооно.

5.5.3 дугаар зүйлд 4 дэх хэсэг нэмэх.
5.3 дугаар зүйл.Өмгөөлөгч оролцуулах.
4.Сэжигтэн яллагдагч, шүүгдэгч өөрийгөө өмгөөлөх хүсэлт гаргаснаас бусад тохиолдолд мөрдөн шалгах ажиллагааг өмгөөлөгчийн оролцоотойгоор явуулна.

6.16.1 дүгээр зүйлийн 14 дэх хэсгийн "үндэслэл байвал" гэсний дараа ", эсхүл Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хууль зөрчиж цуглуулсан нь тогтоогдсон бол" гэж нэмэх.
16.1 дүгээр зүйл.Нотлох баримт
14.Нотлох баримтыг шинжлэн судлах явцад хэрэгт ач холбогдолтой, хамааралтай эсэхэд эргэлзэх үндэслэл байвал, эсхүл Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хууль зөрчиж цуглуулсан нь тогтоогдсон бол тухайн нотлох баримтыг шүүх, прокурорын шийдвэрийн үндэслэл болгохгүй.

7.5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт 1.7 дахь заалт нэмэх.
5.3 дугаар зүйл.Өмгөөлөгч оролцуулах
1.Дараахь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч оролцох эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг өмгөөлөгчгүйгээр явуулж болохгүй:
1.7.сэжигтнийг хойшлуулшгүйгээр баривчилсан.

8.1.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт 1.38 дахь заалт нэмэх.
1.4 дүгээр зүйл. Хуулийн нэр томьёоны тодорхойлолт
1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:
1.38."нотлох баримт хуулбарлаж, хувилж авах" гэж хуульд заасан үндэслэл, журмын дагуу төр, байгууллага, хувь хүний нууцад хамаарахаас бусад нотлох баримтыг хувилах, зураг авах боломжтой техник хэрэгсэл ашиглан хуулбарлаж, хувилж авахыг;

9.5.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.4 дэх заалтын "хууль зүйн туслалцаа үзүүлэхэд" гэснийг "хэргийн бодит байдлыг тогтооход" гэж өөрчлөх, Мөн заалтад "прокурор," гэсний дараа "шүүх" гэж, "тусгуулах," гэсний дараа "хэрэгт ач холбогдол бүхий бусад байдлыг шалгуулах," гэж тус тус нэмэх.
2.4.хэргийн бодит байдлыг тогтооход шаардлагатай эд зүйл, баримт бичиг, мэдээлэл, бусад баримтыг мөрдөгч, прокурор, шүүхэд гаргаж өгөх, түүнийг хавтаст хэрэгт бэхжүүлж тусгуулах,

хэрэгт ач холбогдол бүхий бусад байдлыг шалгуулах, мөрдөн шалгах ажиллагаа явуулах хүсэлт гаргах, энэ хуульд заасан журмын дагуу оролцох;

10.5.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.5 дахь заалтад "асуулт тавих," гэсний дараа "хариулт авах," гэж нэмэх.

2.5.өмгөөлж байгаа сэжигтэн, хохирогч, яллагдагч, шүүгдэгч, ялтны, эсхүл өөрийнхөө хүсэлтээр хийгдэж байгаа мөрдөн шалгах ажиллагаанд байлцаж, аль ч үед асуулт тавих, хариулт авах, хүсэлт гаргах;

Үндэслэл:

Хүнийг гэмт хэрэгт сэжиглэх үндэслэл байгаа бол түүнийг гэрчээр дуудах, эсхүл түүнээс гэрчийн мэдүүлэг авахгүй байх, гэрчийн мэдүүлэг авах үед түүнийг гэмт хэрэгт сэжиглэх үндэслэл илэрсэн бол гэрчийн мэдүүлэг авахыг даруй зогсоох зохицуулалтыг тусгах.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2020 оны 11 сарын 4-ний өдрийн "Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 9.6 дугаар зүйлийн зарим зүйл хэсэг Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай" 10 дугаартай дүгнэлтийн 3-т "Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажсан хүний эрхийг үндэслэлгүй хязгаарласан шинжгүй, хууль зүйн процессын суурь зарчмуудад нийцсэн байх ёстой. Энэ утгаараа хуульд гэмт хэрэгт сэрдэгдэж байгаа этгээдийн эрх зүйн байдлыг дээрх хуулиар нарийвчлан зохицуулж өгөөгүйн улмаас тухайн этгээдээс гэрчийн мэдүүлэг авч, түүний эрхийг хөндөх байдал гаргахаар байгааг хууль тогтоогч анхаарч, хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлага байна..." гэж дүгнэсэн.

Илтэд сэжиглэх үндэслэл бүрдсэн байтал түүнд худал мэдүүлбэл хүлээлгэх ял хариуцлагын талаар урьдчилан сануулж, мөн мэдүүлэг өгөхөөс татгалзах, зайлсхийсэн тохиолдолд Зөрчлийн хуулийн 15.7 дахь хэсэгт зааснаар хариуцлага хүлээх талаар мөрдөн шалгах ажиллагаанд урьдчилан сануулж мэдүүлэг авах, энэ нь гэрчийн мэдүүлгийн маягт загварт тусгагдсан байдаг нь хүн өөрийгөө өмгөөлөх, өөрийн эсрэг мэдүүлэг өгөхийг албадуулахгүй байх, мөн мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхэд шууд харшилж байгаа болно. Монгол Улсын нэгдэн орсон НҮБ-аас 1966 онд баталсан Иргэний болон улс төрийн эрхийн тухай пактын 14/3/ д-д "өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, гэм буруутан гэж хүлээхийг албадуулахгүй байх" эрхийг баталгаажуулсан ба 1969 онд батлагдсан Хүний эрхийн тухай Америкийн конвенцийн 8.2 /g/-д "хүн бүр өөрийнхөө эсрэг гэрчлэх буюу гэм буруутан гэж хүлээхийг албадуулахгүй байх эрхтэй" гэж заасан ба 8.3-т "Яллагдагч өөрийгөө гэм буруутан гэж хүлээх нь ямар нэг албадлага хэрэглээгүй тохиолдолд хүчин төгөлдөр байна" гэснээр улам баталгаажсан байна. Илт сэжиглэгдэх үндэслэл байсаар атал гэрчээр мэдүүлэг авах нь Үндсэн хуулиар баталгаажсан "өөрийгөө өмгөөлөх", "Өөрөө өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхийг шаардах, мэдүүлэг гаргуулахаар шахалт үзүүлэх, хүч хэрэглэхийг хориглоно" гэсэнд харшилсан шинжтэй байгаа тул хуульд өөрчлөлт оруулах замаар уг зөрчлийг арилгах нь зүйтэй. Хүний халдашгүй байх, өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах эрхийг хангах хүрээнд мөрдөн байцаалтыг өмгөөлөгчийг байлцуулахгүйгээр явуулахгүй байх, хэрвээ өмгөөлөгчийг байлцуулахгүйгээр

мөрдөн байцаалт явуулж нотлох баримт цуглуулсан, хэрэг хүлээлгэсэн тохиолдолд тухайн мэдүүлэг, нотлох баримтыг үнэлэхгүй байх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох.
Үндсэн хуульд заасан "хууль зүйн туслалцаа авах" эрхийг хангаж, мэргэжлийн туслалцаа үзүүлэх үүргийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүхий л үе шатанд тасралтгүй хэрэгжүүлэх нь хүний эрхийг хангах, хамгаалахад үр нөлөөтэй бөгөөд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хууль ёсны зарчмыг хэрэгжүүлэх гол нөхцөл болно. Практикт хойшлуулшгүй ажиллагааны хүрээнд мэдүүлэг авах ажиллагааг өмгөөлөгчгүйгээр явуулж, хууль бусаар хэрэг хүлээлгэх, өөрийнх нь эсрэг мэдүүлэг авах тохиолдлууд цөөнгүй гарч байгаатай холбоотойгоор сэжигтнийг хойшлуулшгүйгээр баривчилсан тохиолдолд өмгөөлөгч заавал оролцуулах асуудлыг хуулиар баталгаажуулах шаардлагатай болно. ОХУ-ын Эрүүгийн процессын хуулийн 51 дүгээр зүйлд өмгөөлөгч заавал оролцуулах тохиолдлуудыг зохицуулсан бөгөөд 51 дүгээр зүйл, 1 дэх хэсэг: Дараах Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгч заавал оролцоно: 1. Сэжигтэн, яллагдагч энэхүү хуулийн 52 дугаар зүйлд зааснаар өмгөөлөгчөөсөө татгалзаагүй бол; гэж зааснаас харахад аливаа хүн Эрүүгийн хэрэгт өмгөөлөгч сонгон авсан л бол бүхий л ажиллагаа өмгөөлөгчийн оролцоотой явагддаг байна. Өмгөөлөгч бүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох нь хянан шийдвэрлэх ажиллагаанд хүний эрхийг хангахад чухал үр нөлөөтэй болно.

11.5.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.6 дахь заалтын "өөрийн оролцсон" гэснийг хасах. Мөн заалтад "хийгдсэн" гэсний дараа "дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг," гэж "танилцаж," гэсний дараа "хуулбарлан авах, тэмдэглэлд" гэж тус тус нэмэх.
2.6. мөрдөн шалгах ажиллагаа, шүүхийн хэлэлцүүлэг, шүүх хуралдааны үед хийгдсэн дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг болон тэмдэглэлтэй танилцаж, хуулбарлан авах, тэмдэглэлд засвар оруулах тухай хүсэлт гаргах;

12.5.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.12 дахь заалтад "оролцох" гэснийг дараа ", холбогдох нотлох баримтуудтай танилцах, өөрийн зардлаар хуулбарлан авах" гэж нэмэх.
2.12 "сэжигтнийг баривчлах, яллагдагч, шүүгдэгчийг цагдан хорих, бусад таслан сэргийлэх арга хэмжээтэй холбоотой асуудлыг холбогдох шийдвэрлэхэд оролцох, нотлох баримтуудтай танилцах, өөрийн зардлаар хуулбарлан авах;

13.5.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт 2.15 гэсэн заалт нэмэх.
2.15. үйлчлүүлэгч болон бусад этгээдийн хууль бус шаардлагыг биелүүлэхээс татгалзах;

14.14.13 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "прокурор," гэсний дараа "яллагдагч, түүний хууль ёсны төлөөлөгч," гэж нэмэх.
14.13 дугаар зүйл. Яллагдагчид таслан сэргийлэх арга хэмжээ авах шүүхийн хэлэлцүүлэг.

| | | | |
|---|---|---|---|
| | | 2. Шүүх энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан санал, хүсэлтийг хүлээн авснаас хойш 24 цагийн дотор асуудлыг хэлэлцэх шүүхийн хэлэлцүүлгийн товыг прокурор, яллагдагч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчид мэдэгдэнэ.<br><br>15.14.13 дугаар зүйлд 13 дахь хэсэг нэмэх.<br>13.Таслан сэргийлэх арга хэмжээний талаар талуудаас шүүхэд гаргасан санал, хүсэлт, тэдгээртэй холбоотой нотлох баримтыг эрүүгийн хэрэгт хавсаргана.<br><br>16.1.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.20 дахь заалтад "гэж" дараа "шүүхийн хэлэлцүүлэг" гэж нэмэх. Мөн хэсэгт 1.39 дэх заалт нэмэх.<br>1.4 дүгээр зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт.<br>1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:<br>1.20."талууд" гэж шүүхийн хэлэлцүүлэг, шүүх хуралдааны мэтгэлцээнд тэгш эрхтэй оролцож, яллах, өмгөөлөх чиг үүргийг хэрэгжүүлэгчийг; 1.39. "эрүүгийн хариуцлагын талаархи тохиролцоо" гэж хэргээ хялбаршуулсан журмаар гаргасан шийдвэрлүүлэх хүсэлт яллагдагчид оногдуулах эрүүгийн хариуцлагын талаар талуудын хийсэн тохиролцоог;<br><br>17.33.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт 1.4 гэсэн заалт нэмэх.<br>33.3 дугаар зүйл. Хэргийг прокурорт буцаах.<br>1.Урьдчилсан хэлэлцүүлгийн үед дараахь үндэслэлээр шүүх өөрийн санаачилгаар, эсхүл хэргийг буцаах тухай прокурорын санал, яллагдагч, хохирогч, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн хүсэлтийг харгалзан хэргийг прокурорт буцаахаар шийдвэрлэнэ:<br>1.4.энэ хуулийн 32.1 дүгээр зүйлд заасан ажиллагааг бүрэн хийгээгүй.<br><br>**Үндэслэл:**<br>Өмгөөллийн тухай хуульд заасан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох өмгөөлөгчийн эрх, үүргийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмж тусгах.<br>Өмгөөллийн үйл ажиллагаанд эдлэх эрх, үүргийг холбогдох хэрэг хянан шийдвэрлэх хуулиудаас гадна өмгөөлөгчийн бүрэн эрхийн заалт Өмгөөллийн тухай Монгол Улсын хуульд тусгалаа олсон. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шууд хамаарах Өмгөөллийн тухай хуульд заагдсан зарим эрх процессын хуульд тодорхой тусгагдаагүйгээс мөрдөн шалгах ажиллагааг хэрэгжүүлэгчдийн зүгээс хуулийн зохицуулалтыг зөрүүтэй ойлгох, хэрэг хувилж хуулбарлан авахтай холбоотой эрх болон хууль зүйн туслалцаа үзүүлэх үүргээ хэрэгжүүлэхэд хүндрэл үүсэх, хэргийн бодит байдлыг тогтооход чухал ач холбогдол бүхий баримтыг шүүхэд гарган өгөх боломжгүй болох тохиолдлууд байна. Түүнчлэн хуулийн 2.4-т заасан эрхийг зөвхөн хууль зүйн туслалцаа үзүүлэхэд шаардлагатай гэж явцууруулсаныг хэргийн бодит байдлыг тогтоох зарчмыг хэрэгжүүлэх, нөхцөл байдлыг эргэлзээгүй тогтоох хүрээнд өргөжүүлэн авч үзэх нь зүйтэй. Түүнчлэн мөрдөн шалгах ажиллагааны үед хийгдсэн дууны, дүрсний, дуу дүрсний бичлэгийг өмгөөлөгч хуулбарлан авах боломжийг хуулиар нээх нь эрх тэгш | |

| | | | |
|---|---|---|---|
| | | мэтгэлцээний нөхцлийг хангах, мөн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хүний эрхийг зөрчихөөс урьдчилан сэргийлэх, хэргийн бодит байдлыг тогтоох, шүүн таслах ажиллагааг хуулийн дагуу цуглуулж бэхжүүлсэн нотлох баримтад үндэслэн явуулахад ач холбогдолтой гэж үзэж байна. Мэдүүлгийн тэмдэглэлүүд дууны болон дуу-дүрсний бичлэгээс зөрөх тохиолдлууд гарч байгаа бөгөөд бодит бус, мөн мэдүүлэг авахдаа оролцогчийн эрхийг зөрчиж авсан тохиолдлуудад шүүх хууль бус нотлох баримтад үндэслэн хэргийг шийдвэрлэх эрсдэлтэй болно. ЭХХШТХ-ийн 16.7 дугаар зүйлийн 2-т "Мөрдөн шалгах ажиллагаа, прокурорын хянан шалгах ажиллагаа, шүүх хуралдааны тэмдэглэлд тусгагдсан нөхцөл байдал нь дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгээс зөрсөн тохиолдолд шүүх, прокурор дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийг нотлох баримтаар тооцно" гэж заасан бөгөөд энэ заалтыг бодитойгоор хэрэгжүүлэх үүднээс өмгөөлөгч тухайн бичлэгийг хуулбарлан авах эрхтэй байхаар зохицуулах шаардлагатай болно.<br><br>18.Гучин дөрөвдүгээр бүлэгт $34.11^1$ дүгээр зүйл нэмэх.<br>$34.11^1$ дүгээр зүйл. Гэрч, шинжээч шүүх хуралдаанд оролцох.<br>1.Улсын яллагч, яллагдагч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч хүсэлт гаргасан бол анхан шатны журмаар хэргийг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд гэрч, шинжээчийг оролцуулна.<br>2. Шүүхээс дуудсан гэрч, шинжээч шүүх хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй нь хариуцлага хүлээлгэх үндэслэл болно.<br><br>19.34.13 дугаар зүйлд 2 дахь хэсэг нэмэх.<br>34.13 дугаар зүйл. Шүүх хуралдаанд хохирогч, гэрч, шинжээч хүрэлцэн ирээгүйн холбогдол.<br>2.Улсын яллагч, яллагдагч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч нь гэрч, шинжээч оролцуулах хүсэлтээсээ татгалзаагүй тохиолдолд шүүх хуралдааныг хойшлуулна.<br><br>20.39.1 дүгээр зүйлд 9 дэх хэсэг нэмэх.<br>39.1 дүгээр зүйл. Давж заалдах шатны шүүхийн эрх хэмжээ.<br>9.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэл нь иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагчийн гаргасан давж заалдах гомдлыг хянан шийдвэрлэхэд хамаарахгүй.<br><br>21.34.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Энэ нь өмгөөлөх талаас шүүхэд шинээр нотлох баримт гаргах эрхийг хязгаарлах үндэслэл болохгүй." гэсэн өгүүлбэр нэмэх.<br>34.14 дүгээр зүйл. Хэрэг шийдвэрлэх ажиллагааны хязгаар хянан хэмжээ.<br>1.Анхан шатны журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь тухайн шүүгдэгчийн хувьд прокуророос шүүхэд шилжүүлсэн эрүүгийн хэргийн хүрээнд явагдана. Энэ нь өмгөөлөх талаас шүүхэд шинээр нотлох баримт гаргах эрхийг хязгаарлах үндэслэл болохгүй.<br><br>Үндэслэл: | |

| | | | |
|---|---|---|---|
| | | Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа талуудын эрх тэгш мэтгэлцээний үндсэн дээр явагдах бөгөөд энэхүү нөхцөлийг шүүх хангахаар зохицуулагдсан.<br>Яллагдагчид таслан сэргийлэх арга хэмжээ авах шүүхийн хэлэлцүүлгийн товыг өмгөөлөгчид хэт тулгуу хугацаатай мэдэгддэг, өмгөөлөлд бэлтгэх хангалттай хугацаа олгодоггүй, тухайн таслан сэргийлэх арга хэмжээ авах үндэслэл болгож буй баримтуудтай танилцуулалгүйгээр тухайн асуудлыг шийдвэрлэж байгаа нь эрх тэгш мэтгэлцэх боломжийг хязгаарлаж байгаа явдал болно. Өмгөөлөгчид шүүхийн хэлэлцүүлэгт ямар баримт, нотолгооны эсрэг мэтгэлцэх нь тодорхойгүйгээр "таамаглаж" үндэслэл, байр сууриа илэрхийлэхэд хүрч байна. Иймд таслан сэргийлэх арга хэмжээтэй холбоотой хэлэлцүүлгийн товыг тодорхой хугацааны өмнө мэдэгдэх нь ИБУТЭТОУ-ын пактын 14-3 b-д зааснаар "өөрийн сонгож авсан өмгөөлөгчтэй уулзаж, өмгөөлүүлэхэд бэлтгэхэд хүрэлцэхүйц цаг хугацаа, бодит боломжтой байх" эрхийг хэрэгжүүлэх боломжийг хангах бөгөөд энэ нь шударгаар шүүлгэх болон талуудын эрх тэгш байдлын баталгаа болно. Энэ эрх нь ИБУТЭТОУ пактаас гадна Хүний эрхийн тухай Америкийн конвенцийн 8-2 c-д болон Хүний эрхийн тухай Европын конвенцийн 6-3 b-д дээрхтэй адил агуулгаар тусгагдсан байна. Пактын 14 дүгээр зүйлийн талаар гаргасан 13 дугаар Ерөнхий тайлбарт "хүрэлцэхүйц хугацаа" гэдгийг тухайн хэргийн нөхцөл байдлаас шалтгаална гээд "боломцоо" гэдгийг өмгөөлөхөд шаардлагатай баримт бичиг болон бусад нотлох баримттай танилцах болон өмгөөлөгчтэй холбоо барьж харилцах боломжийг олгоно гэж заажээ. Мөн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд, тэр тусмаа эрхийн хязгаарлалт тогтоож байгаа таслан сэргийлэх арга хэмжээ авах эсэх асуудлыг шийдвэрлэх шүүхийн хэлэлцүүлэгт яллагдагчийг аливаа хүсэлт гаргахгүйгээр оролцох боломжийг нээж ЭХХШТХ-ийн 14.13 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт өөрчлөлт оруулах шаардлагатай байна.<br><br>22.7.3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "танилцах" гэсний дараа", "хувийг авах" гэж нэмэх.<br>7.3 дугаар зүйл. Ямар хэрэгт яллагдаж байгаагаа мэдэх.<br>2.Яллагдагчаар татсан, таслан сэргийлэх арга хэмжээ авсан шийдвэртэй танилцах, хувийг авах эрхтэй.<br><br>23.7.3 дугаар зүйлд 5 дахь хэсэг нэмэх.<br>5.Хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан, мөрдөн байцаалт дууссан бол хэргийн бүх материалтай танилцаж, төр, байгууллага, хувь хүний нууцад хамаарахаас бусад нотлох баримтыг өөрийн зардлаар хуулбарлаж, хувилж авах эрхтэй.<br><br>24.31.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "танилцуулна." гэснийг "танилцуулж, хувийг гардуулан өгнө" гэж өөрчлөх, 31.3 дугаар зүйлд 6 дахь хэсэг нэмэх.<br>31.3 дугаар зүйл.Эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоол танилцуулах, гардуулан өгөх<br>1.Мөрдөгч эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолыг прокуророос хүлээн авсан даруй дуудан ирүүлсэн сэжигтэнд танилцуулж, хувийг гардуулан өгнө. | |

| | | | |
|---|---|---|---|
| | | 6.Сэжигтэн эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолтой танилцах, гардан авахаас татгалзсан нь мөрдөн шалгах ажиллагаа явуулахад саад болохгүй.<br><br>25.16.10 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт "Хэргийн оролцогчоос гаргасан хүсэлтийг бүрэн хангаагүй, эсхүл хангахаас татгалзсан үндэслэлээ шийдвэртээ тодорхой тусгана." гэсэн өгүүлбэр нэмэх.<br>16.10 дугаар зүйл.Нотлох баримт гаргаж өгөх, нотлох баримт шалгуулах, мөрдөн шалгах ажиллагаа явуулах хүсэлтийг шийдвэрлэх<br>4.Шүүх, прокурор, мөрдөгч энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан хүсэлт нь хэргийг тал бүрээс нь бүрэн бодитой тогтооход ач холбогдолтой бол бүрэн, эсхүл хэсэгчлэн хангах, эсхүл хангахаас татгалзах тухай шийдвэр гаргана. Хэргийн оролцогчоос гаргасан хүсэлтийг бүрэн хангаагүй, эсхүл хангахаас татгалзсан үндэслэлээ шийдвэртээ тодорхой тусгана.<br>26.34.16 дугаар зүйлд 6 дугаар хэсгийг нэмэх.<br>34.16 дугаар зүйл. Шүүх хуралдааныг хойшлуулах.<br>5.Шүүх хуралдааны явцад нотлох баримтаар тогтоогдсон хэргийн нөхцөл байдлыг үндэслэн шүүгдэгчид холбогдох хэргийн зүйлчлэлийг хүндрүүлэхээр бол, эсхүл энэ хуулийн 33.1 дүгээр зүйлийн 6.13, 6.14-т заасан гомдлыг шийдвэрлэх зорилгоор шүүх хэргийг хянан хэлэлцэхийг нэг удаа 60 хүртэл хоногоор хойшлуулна" гэснийг хэвээр үлдээх. Мөн зүйлийн 6 дахь хэсэгт оруулахаар төсөлд тусгагдсан заалтыг хасах.<br><br>27.32.10 дугаар зүйлийн 8 дахь хэсгийн Яллах дүгнэлт гардуулсны дараа хэргийн талаар гаргасан хүсэлт, гомдлыг гэсний дараа "прокурор энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу хянан шийдвэрлэсний дараа хэргийг" гэж нэмэх.<br>32.10 дугаар зүйлийн 8 дахь хэсэг "Яллах дүгнэлт гардуулсны дараа хэргийн талаар гаргасан хүсэлт, гомдлыг прокурор энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу хянан шийдвэрлэсний дараа хэргийг шүүхэд шилжүүлнэ."<br><br>Үндэслэл:<br>Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд яллах, өмгөөлөх талын эрх тэгш мэтгэлцэх зарчмыг хэрэгжүүлэхтэй холбогдсон зохицуулалтыг сайжруулах, хэргийн оролцогчийн эрхийг хангаснаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дараагийн шатанд хэрийг шилжүүлдэг зохицуулалтыг тусгах.<br>Хэргийн бодит байдлыг мэтгэлцээний үндсэн дээр явуулна. Мэтгэлцээн нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүхий л үе шатанд хэрэгжих тул шүүх хуралдаан болон мөрдөн шалгах ажиллагааны явц дахь шүүхийн хэлэлцүүлгүүдэд ч мөн хамаатай болно. Иймд ЭХХШТХ-ийн 1.4 дүгээр зүйлийн 1.20-д заасан "талууд" гэсэн нэр томъёоны тодорхойлолтод өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзэж байна. Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлүүлэх асуудлын хамгийн гол зүйл нь талуудын хийсэн тохиролцоо бөгөөд үүнийг хэрхэн ойлгох, ямар субъектүүдийн хооронд энэ нь хэрэгжихийг тодорхой болгох үүднээс нэр томъёоны тодорхойлолтод энэ ойлголтыг оруулан тайлбарлах нь зүйтэй. Мөн ИБУТЭТОУ-ын | |

пактын 14-3 b-д зааснаар "өөрийн сонгож авсан өмгөөлөгчтэй уулзаж, өмгөөлүүлэхэд бэлтгэхэд хүрэлцэхүйц цаг хугацаа, бодит боломжтой байх" эрхийг хэрэгжүүлэх боломжийг хангах үүднээс хэрэг танилцуулах боломжит хугацааг хуулиар тухайлан заах шаардлагатай бөгөөд бодит байдал дээр мөрдөн байцаалтыг дуусган, хэрэг танилцах хангалттай боломж хугацаа олгохгүйгээр дараагийн шатанд шилжүүлэх нь түгээмэл байна. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа бүхэлдээ прокурорын удирдлага, хяналтад явдаг, яллах өмгөөлөх талын эрх тэнцвэргүй, цагаатгах талын баримтуудыг цуглуулах, бэхжүүлэх ажиллагаа хангалттай хийгддэггүй, өмгөөлөгчийн зүгээс гаргадаг нэмэлт нотлох баримт цуглуулахтай холбоотой хүсэлтийг хангалттай шийдвэрлэдэггүй тул өмгөөлөх тал шүүхэд нэмэлт баримт гарган өгөх боломжийг нээх нь зүйтэй гэж үзэж байгаа болно. Үүнтэй холбоотойгоор 32.1 дүгээр зүйлийн 10 дах хэсгийн заалтыг хасах нь зүйтэй. Мөрдөн шалгах ажиллагааг бүрэн хийгээгүй, ажиллагаагаар хэргийн бодит байдлыг бүрэн нотолж чадаагүй гэж үзвэл прокуророос мөрдөн байцаалтад, мөн шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгээс прокурорт буцаах зохицуулалт шаардлагатай.

Шүүх хуралдаанд мөрдөн шалгах ажиллагаа нууцаар явуулахтай холбоотой ил болгохыг хориглосон мэдээллийг танилцуулахдаа холбогдох хуулийг баримтална гэсэн ЭХХШТХ-ийн 34.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн зохицуулалтын агуулгыг тодорхой болгох шаардлагатай бөгөөд аливаа хүн өөрийг нь буруутгаж байгаа баримттай бүрэн танилцахгүйгээр шийтгүүлэх, энэ боломжийг түүний өмгөөлөгч ч эдлэх боломжгүйгээр хэргээ шийдвэрлүүлэх үр дагавар байгаа тул хуулийн энэ зохицуулалтыг хүний эрхийг зөрчихгүй байдлаар, шударга шүүхээр шүүлгэх эрхийг бодитойгоор хэрэгжүүлэх боломжтой байдлаар найруулах саналтай.

Гэрч, шинжээч, хохирогчийг шүүх хуралдаанд дуудан ирүүлж, шүүх хуралдааны танхимд хэргийн нөхцөл байдлыг тодруулах нь бодитойгоор хэргийг шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой. Практикт мөрдөн шалгах ажиллагааны явцад бодит бус мэдүүлэг гаргаж, уг мэдүүлэгт үндэслэн яллагдагчаар татаж, буруутгах явдал байдаг. Тухайн мэдүүлэг авах ажиллагаанд яллагдагчийн өмгөөлөгч бараг оролцдоггүй тул мөрдөн байцаалтын ажиллагаа дуусахад л хэргийн материалтай танилцсанаар л энэ талаар мэдэх боломжтой. Тухайн хүний мэдүүлэгтэй холбоотой ажиллагаа хийгдэхгүй, уг мэдүүлгийг үгүйсгэх, няцаах боломж олгохгүйгээр шүүхэд шилжиж, шүүх хуралдаанд л дуудан ирүүлж нөхцөл байдлыг тодруулах боломж үлддэг. Шүүх хуралдаанд дуудагдсан гэрч, шинжээч хүрэлцэн ирэхгүй байгаа тохиолдолд шууд хуралдаанаар хэлэлцэх нь түгээмэл бөгөөд ингэснээр хангалттай мөн бодитой нотолгоо баримтгүйгээр, бодит бус мэдүүлэгт үндэслэн хүнийг буруутгах нөхцөл бүрддэг тул өмгөөлөгч хүсэлт гаргасан, түүнээсээ татгалзаагүй тохиолдолд тухайн гэрч шинжээч, хохирогчийг заавал хуралдаанд оролцуулах зохицуулалтыг хуульд тусгах нь зүйтэй. Хуульд иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч нь зөвхөн иргэний нэхэмжлэлд хамаарах асуудлаар гомдол гаргах эрхтэй байхаар зохицуулсан. Харин ийнхүү гаргасан гомдлоор давж заалдах шатны шүүх хэргийг хянахдаа иргэний нэхэмжлэлтэй холбоотой асуудлын тухайд хянахгүйгээр бүхэлд нь хянаж байгааг өөрчлөх шаардлагатай. Иргэний нэхэмжлэгч,

| | | | |
|---|---|---|---|
| | | хариуцагчийн тухайд гаргасан гомдлын хүрээнд буюу иргэний нэхэмжлэлтэй холбоотой асуудлаар л хянаж, шийдвэрлэх нь зөв гэж үзэж байгаа болно.<br><br>28.32.10 дугаар зүйлийн 8 дахь хэсгийн Яллах дүгнэлт гардуулсны дараа хэргийн талаар гаргасан хүсэлт, гомдлыг гэсний дараа "прокурор энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу хянан шийдвэрлэсний дараа хэргийг" гэж нэмэх.<br>32.10 дугаар зүйлийн 8 дахь хэсэг "Яллах дүгнэлт гардуулсны дараа хэргийн талаар гаргасан хүсэлт, гомдлыг прокурор энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу хянан шийдвэрлэсний дараа хэргийг шүүхэд шилжүүлнэ."<br>**Үндэслэл:**<br>Энэ өөрчлөлт нь урьдчилсан хэлэлцүүлгийн агуулга, ая холбогдлыг үгүйсгэж байгаа тул төслөөс хасах саналтай. Харин мөрдөн шалгах ажиллагааны явцад прокурорт болон дээд шатны прокурорт гаргасан хүсэлт гомдлыг шийдвэрлүүлсэний дараа хэргийг прокурорт шилжүүлэх санал гаргах талаар хуулийн 32.10 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт өөрчлөлт оруулах шаардлагатай.<br><br>29.9.6 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн "мэдүүлэг өгөхөөс татгалзаж, өмгөөлөгчтэй мэдүүлэг өгөх эрхтэй." гэснийг "мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхтэй." гэж өөрчлөн найруулах.<br>9.6 дугаар зүйл. Гэрч<br>6. Гэрч өөрийнх нь эсрэг, түүнийг гэмт хэрэг үйлдсэн, гэм буруутай байдлаар мэдүүлэг авч байна гэж үзвэл энэ тухай тэмдэглэлд тусгуулан мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхтэй.<br><br>30.14.13 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг өөрчлөн найруулах.<br>3.Шүүхийн хэлэлцүүлэгт прокурор, яллагдагч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийг оролцуулна.<br><br>31.14.13 дугаар зүйлийн 5 дахь хэсгийг өөрчлөн найруулах.<br>5.Прокурор, яллагдагч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч гаргасан санал, хүсэлтийн үндэслэл болгож байгаа нотлох баримтыг шүүх хэргийн оролцогчид танилцуулж, тэдгээрт тайлбар хийх, холбогдох нотлох баримтыг гаргаж өгөх боломжоор хангана. Талуудад танилцуулагдаагүй баримт нь шүүхийн шийдвэрийн үндэслэл болохгүй.<br><br>32.32.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг өөрчлөн найруулах.<br>32.1 дүгээр зүйл. Хавтаст хэргийн материал танилцуулах<br>3.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан оролцогч хэргийн материалтай 14 хоногийн хугацаанд танилцах ба мөрдөгч хэргийн материалтай танилцах боломж, нөхцөлийг бүрдүүлнэ. Хавтаст хэргийн тоо, хэргийн оролцогчдын тооноос хамааран хэргийн материалтай танилцах хугацааг мөрдөгч 14 хүртэл хоногоор сунгаж болно. | |

| | | | |
|---|---|---|---|
| | | 33.32.1 дүгээр зүйлийн 9 дэх хэсгийг өөрчлөн найруулах.<br>9.Нэмэлт мөрдөн байцаалт явуулсан бол нэмж хийсэн ажиллагааны материалыг энэ зүйлд заасан журмын дагуу оролцогчид танилцуулна.<br><br>34.32.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг өөрчлөн найруулах.<br>32.2 дугаар зүйл. Хэргийг прокурорт шилжүүлэх.<br>1.Энэ хуулийн 32.1 дүгээр зүйлд заасан ажиллагаа бүрэн хийгдэж дууссаны дараа мөрдөгч холбогдох саналыг хавтаст хэргийн хамт 3 хоногийн дотор прокурорт шилжүүлнэ.<br><br>35.32.9 дүгээр зүйлийг бүхэлд нь өөрчлөн найруулах.<br>32.9 дүгээр зүйл. Прокуророос хэргийг мөрдөн байцаалтад буцаах.<br>1.Прокурор дор дурдсан үндэслэлээр хэргийг мөрдөн байцаалтад буцаана:<br>1.1.хэрэгт нэмэлт мөрдөн шалгах нэмэлт ажиллагаа хийлгэх шаардлагатай бол;<br>1.2. яллагдагчийг буруутгаж байгаа Эрүүгийн хуулийн зүйл, хэсэг, заалтыг өөрчлөх, нэмэлт оруулсантай холбоотой нэмэлт ажиллагаа хийлгэх;<br>1.3.энэ хуулийн 32.1 дүгээр зүйлд заасан ажиллагааг бүрэн хийгээгүй.<br><br>36.34.8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг өөрчлөн найруулах.<br>34.8 дугаар зүйл. Хохирогч шүүх хуралдаанд оролцох<br>1.Хохирогч бичгээр хүсэлт гаргасан, эсхүл улсын яллагч, яллагдагч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч хүсэлт гаргасан бол анхан шатны журмаар хэргийг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд хохирогчийг оролцуулна.<br><br>37.34.8 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг өөрчлөн найруулах.<br>34.8 дугаар зүйл. Хохирогч шүүх хуралдаанд оролцох.<br>2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэлээр шүүх хуралдаанд оролцуулахаар шийдвэрлэсэн хохирогч ирээгүй нь шүүх хуралдааныг хойшлуулах үндэслэл болно.<br>38.5.3 дугаар зүйлийн 1.6 дахь заалтын "төлбөрийн чадваргүйн улмаас" гэснийг хасах.<br>5.3 дугаар зүйл. Өмгөөлөгч оролцуулах<br>1. Дараахь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч оролцох эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг өмгөөлөгчгүйгээр явуулж болохгүй.<br>1.6.өмгөөлөгч оролцуулах хүсэлт гаргасан.<br><br>39.5.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "2.15" гэснийг "2.16" гэж өөрчлөх, тус заалтын "энэ" гэснийг хасах.<br>2.16 хуульд заасан бусад эрх.<br><br>40.32.1 дүгээр зүйлийн 10 дахь хэсгийг хасах. | |

41.11.11 дүгээр зүйлийн 7 дахь хэсгийн "шалгах" гэсний дараа "эрх бүхий" гэдгийг хасах.

11.11 дүгээр зүйлийн 7 дахь хэсэг. Хавтаст хэргийг цахимжуулах, шүүх прокурор, мөрдөн шалгах байгууллагуудын нэгдсэн системд холбох журмыг Шүүхийн ерөнхий зөвлөл, Улсын ерөнхий прокурор, хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

Нэр томъёог жигдлэн мөрдөн шалгах байгууллага гэж тусгах. ЭХХШТХ-ийн 6.2, 31.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт тус тус "мөрдөн шалгах байгууллага" гэж тусгасан.

42.14.10 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн "Мөрдөн шалгах ажиллагааны явцад гэмт хэрэг үйлдэж, яллагдагчаар татагдан цагдан хоригдсон бол цагдан хорих хугацааг шинээр тоолно." гэснийг бүхэлд нь хасах.

Төслөөс хасах саналтай.

Үндэслэл:

Мөрдөн шалгах ажиллагааны явцад дахин гэмт хэрэг үйлдэж цагдан хоригдсон тохиолдолд цагдан хорих хугацааг тусад нь тоолох шаардлага огт байхгүй, үүнтэй холбоотой бодит хүндрэлүүд гардаггүй болно. Монгол Улсын нэгдэн орсон, НҮБ- аас 1966 онд баталсан Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 9-р зүйлийн 3-т "... Шүүхийн өмнөх шатанд байгаа хүнийг заавал цагдан хорьж байх нийтлэг журам байх албагүй бөгөөд шүүх хуралд оролцох, шүүн таслах ажиллагааны аль шатанд байлцах, шаардлагатай тохиолдолд, шүүхийн шийдвэр гүйцэтгэхэд байх баталгаа гаргаж өгсөн бол этгээдийг суллаж болно" гэж заасан. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.1 дүгээр зүйлд цагдан хорьж мөрдөхөөс гадна өөр төрлийн 5 арга хэмжээг дангаар нь болон давхардуулан авч, сонгон хэрэглэх боломжтойгоор нэрлэн заасан байдаг. Энэ арга хэмжээнүүдээс аль тохирохыг нь сонгон хэрэглэж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэх бүрэн боломжтой.

Цагдан хорьж дээд хугацааг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.10 дугаар зүйлд, харин өсвөр насны яллагдагчийн тухайд 18.8 дугаар зүйлд тодорхой зохицуулсан байдаг бөгөөд энэ зохицуулалтын хүрээнд хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг хэвийн явуулах бүрэн боломжтой. Түүнчлэн ЭХХШТХ-ийн 14.10 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт "Нэг хэрэгт дахин, эсхүл тусгаарласан, нэгтгэсэн хэрэгт шинээр цагдан хоригдсон бол өмнө нь цагдан хоригдсон хугацааг нийт цагдан хоригдсон хугацаанд оруулж тооцно" гэж заасан бөгөөд энэ нь манай улсын нэгдэн орсон олон улсын хүний эрхийн баримт бичгүүдэд бүрэн нийцэж байгаа бөгөөд хоригдсон этгээдийн эрх зүйн байдлыг дордуулахгүй байх талаасаа тохиромжтой зохицуулалт.

Харин ЭХХШТХ-ийн 14.10 дугаар зүйлийн 9-д заасан "Энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан яллагдагчийн цагдан хоригдсон хугацааг баривчилсан өдрөөс, эсхүл яллагдагчийг цагдан хорьсон өдрөөс эхлэн прокурор хэргийг шүүхэд шилжүүлэх хүртэл тоолно" гэсэн зохицуулалт нь яллагдагчийг шүүхийн шатанд хугацааны хязгаарлалтгүй хорих боломжийг бий болгож байгаа, хүний эрхийн талаасаа ухралт болсон зохицуулалт тул хүчингүй болгох зайлшгүй шаардлагатай юм. Учир нь олон улсын хүний эрхийн талаарх баримт бичгүүдэд цагдан

| | | | |
|---|---|---|---|
| | | хоригдсон "хүн"-ийг гэж нийтлэг ойлголтоор тусгаснаас бус сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг гэж ялган тодорхойлоогүйг харгалзан үзэх ёстой.<br><br>43.34.16 дахь хэсэгт 6 дугаар хэсгийг хасах.<br>34.16 дугаар зүйл. Шүүх хуралдааныг хойшлуулах.<br>5.Шүүх хуралдааны явцад нотлох баримтаар тогтоогдсон хэргийн нөхцөл байдлыг үндэслэн шүүгдэгчид холбогдох хэргийн зүйлчлэлийг хүндрүүлэхээр бол, эсхүл энэ хуулийн 33.1 дүгээр зүйлийн 6.13, 6.14-т заасан гомдлыг шийдвэрлэх зорилгоор шүүх хэргийг хянан хэлэлцэхийг нэг удаа 60 хүртэл хоногоор хойшлуулна" гэснийг хэвээр үлдээх<br>Мөн зүйлийн 6 дахь хэсэгт оруулахаар төсөлд тусгагдсан заалтыг хасах.<br>Үндэслэл:<br>Энэ заалтыг хасах саналтай. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа бүхэлдээ прокурорын хяналтад явагддаг бөгөөд тухайн хэргийг хангалттай нотлогдсон гэж үзэж хэргийг шүүхэд шилжүүлэх эсэхийг прокурор бие даан шийдвэрлэдэг. Хангалттай цаг хугацаагаар мөрдөн шалгах ажиллагаа явуулж, яллах үндэслэл бүрдсэн гэж шүүхэд шилжүүлсэн атлаа нэмэлт ажиллагаа шаардлагатай гэсэн үндэслэлээр 60 хоног шүүхээс олгож, шаардлагатай ажиллагааг гүйцэтгүүлж байгаа нь хангалттай хугацаа юм. Энэхүү төсөлд тусгагдсанаар шүүх хуралдааныг 30 хүртэл хоногоор сунгах боломжийг нээвэл мөрдөн шалгах ажиллагааг хэрэгжүүлдэг байгууллага дээр нотлох баримтыг цуглуулдаг, бэхжүүлдэг ажиллагаа нь шүүх рүү шилжих, дээр нь цаг хугацааны хязгаарлалтгүй, хэдэн удаа хойшлогдохыг тодорхой заагаагүй тул тухай бүр 30 хоногоор сунгагдах нөхцөл бүрджээ. Иймд энэ нэмэлтийг төслөөс хасах саналтай.<br><br>44.34.10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "төлөөлнө" гэдгийг төслөөс хасч, одоогийн зохицуулалтыг хэвээр үлдээх.<br>34.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэг<br>"Шүүгдэгчийг хэд хэдэн өмгөөлөгч өмгөөлж байгаа бол шүүх хуралдаанд тодорхой асуудлаар мэтгэлцэхэд нэг өмгөөлөгч бусдыгаа төлөөлж болно."<br>Үндэслэл:<br>Өмгөөллийн тухай хуулийн 18-д заасны дагуу өмгөөлөгчид өөр өөрийн гэсэн бие даасан байр суурьтай байж болохоор зохицуулсан ба үйлчлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөх эрхийг хязгаарлахыг хориглосон зохицуулалтууд Өмгөөллийн тухай хуульд тусгагдсан. Түүнчлэн тодорхой асуудлаар мэтгэлцэхэд гэдэг нь практик хэрэглээнд тодорхойгүй байдал бий болгох магадлалтай. Тухайлбал, олон зүйл хэсгээр буруутгагдаж байгаа шүүгдэгчийг хэд хэдэн өмгөөлөгч өмгөөлж, зүйл хэсэг бүрт няцаалт өгөх шаардлага үүсэхэд үүнийг энэ зохицуулалтаар хязгаарлах тохиолдол үүсч болно. Мөн өмгөөлөгчид өөр өөрийн байр сууринаас асуудалд хандан, цагаатгах, яллагааг няцаах чиг үүрэгтэйгээр оролцох боломжийг хязгаарлах, улмаар олон улсын хүний эрхийн баримт бичгүүдэд тусгагдсан эрхүүдийг хязгаарлах тул энэ өөрчлөлт шаардлагагүй. | |

| | | | |
|---|---|---|---|
| | | 45.34.12 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн "болох ба энэ талаарх мэдээллийг харьяалах прокурорын байгууллага, Монголын Өмгөөлөгчдийн холбоонд даруй хүргүүлнэ." гэдгийг хасч одоогийн зохицуулалтыг хэвээр үлдээх.<br>34.12 дугаар зүйлийн 3 дахь хэсэг "Улсын яллагч, өмгөөлөгч, иргэдийн төлөөлөгч шүүх хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй нь хариуцлага хүлээлгэх үндэслэл болно."<br>Энэ зохицуулалт шаардлагагүй. Шүүхэд зөрчлийн хууль хэрэглэн хариуцлага хүлээлгэх эрх байгаа тохиолдолд харьяалах байгууллагуудад мэдэгдэх, хариуцлага тооцуулах асуудлыг дахин хөндөх нь зохимжгүй.<br><br>46.34.16 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн "хоёр ба түүнээс дээш удаа давтагдаж" гэснийг, мөн зүйлийн 5 дахь хэсгийн "нэг удаа" гэснийг хэвээр үлдээх.<br>34.16 дугаар зүйлийн 3 дахь хэсэг.<br>3.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэл нь хоёр ба түүнээс дээш удаа давтагдаж эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд санаатай саад учруулаах нөхцөл болж байвал шүүх хуралдааныг хойшлуулахгүй байж болно.<br>34.16 дугаар зүйлийн 5 дахь хэсэг.<br>5.Шүүх хуралдааны явцад нотлох баримтаар тогтоогдсон хэргийн нөхцөл байдлыг үндэслэн шүүгдэгчид холбогдох хэргийн зүйлчлэлийг хүндрүүлэхээр бол, эсхүл энэ хуулийн 33.1 дүгээр зүйлийн 6.13, 6.14 -т заасан гомдлыг шийдвэрлэх зорилгоор шүүх хэргийг хянан хэлэлцэхийг нэг удаа 60 хүртэл хоногоор хойшлуулна" гэсэн зохицуулалтыг одоогийн зохицуулалтаар үлдээх.<br>Үндэслэл:<br>Энэ өөрчлөлтийг төслөөс хасах саналтай. "Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд санаатай саад учруулах нөхцөл болж байвал" гэдэг нь хэт ерөнхий, субъектив шинжтэй, шийдвэр гаргах албан тушаалтны хүсэл зоригоос шууд хамааралтай тул иргэний Үндсэн хуулиар хамгаалагдсан өмгөөлүүлэх эрх зөрчигдөх магадлалтай. Хэдийгээр императив шинжтэй бус, шүүх тухайн үеийн нөхцөл байдал, шалтгаан үндэслэлийг харгалзахаар зохицуулсан мэт боловч практикт шүүгдэгчийн эрхийг шууд хязгаарлах байдлаар хэрэгжих магадлалтай. Харин хүндэтгэн үзэх шалтгаан тогтоогдохгүй бол шүүх эрх хэмжээнийхээ хүрээнд хариуцлага тооцох эрхээ хэрэгжүүлэх боломжтой. | |

-----oOo-----

# Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Монгол Улсын Их Хурлын 2024 оны 18 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд/

**Нийтлэгдсэн огноо: 2024-10-29**

Хуулийн төсөлд санал өгөх

| Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл | Хавсралт файл |
|---|---|
| Төслийн файл | Харах |
| Танилцуулга | Харах |
| Үзэл баримтлал | Харах |
| Хэрэгжилтийн үр дагавар | Харах |
| Зардлын тооцоо | Харах |
| Үр нөлөөний үнэлгээ | Харах |

# Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Монгол Улсын Их Хурлын 2024 оны 18 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд/

**Нийтлэгдсэн огноо: 2024-10-29**

Хуулийн төсөлд санал өгөх

| Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл | Хавсралт файл |
|---|---|
| Төслийн файл | Харах |
| Танилцуулга | Харах |
| Үзэл баримтлал | Харах |
| Хэрэгжилтийн үр дагавар | Харах |
| Зардлын тооцоо | Харах |
| Үр нөлөөний үнэлгээ | Харах |

Share

Сэтгэгдэл бичих...

Нийтлэх

| Ажлын хэсгийн гишүүдийн нэрс | | |
|---|---|---|
| 1. | Нэргүйн Мягмар | Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга |
| 2. | Чагдаагийн Хосбаяр | Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн, хууль зүйн ухааны доктор (Ph.D) |
| 3. | Батаагийн Батцэрэн | Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын шүүгч |
| 4. | Максимын Чинбат | Улсын ерөнхий прокурорын орлогч, төрийн хууль цаазын шадар зөвлөх |
| 5. | Отгонбаярын Мөнхбаатар | Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийн дарга |
| 6. | Батзэвэгийн Энхболд | Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн, хууль зүйн ухааны доктор (Ph.D) |
| 7. | Халтарын Буянтүмэн | Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар |
| 8. | Дашийн Энхтөр | Тагнуулын ерөнхий газрын Мөрдөн шалгах газрын дарга, хурандаа |
| 9. | Баатарсүрэнгийн Батзориг | Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа |
| 10. | Батбаярын Цогтбаатар | Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийн захирал, хууль зүйн ухааны доктор (Ph.D), дэд профессор, цагдаагийн хурандаа |
| 11. | Хүрэлбаатрын Эрдэм-Ундрах | Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал, хууль зүйн ухааны доктор (Ph.D) |
| 12. | Бадмын Батзориг | Монголын криминологичдын холбооны удирдах зөвлөлийн дарга, хууль зүйн ухааны доктор (Ph.D), профессор |
| 13. | Лхагвын Данзанноров | Монголын өмгөөлөгчдийн холбооны ерөнхийлөгч, өмгөөлөгч |
| 14. | Нармандахын Жамъянхүү | Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга |
| 15. | Цэрэнсүрэнгийн Лхагвацэнд | Хууль зүй, дотоод хэргийн яамны Нийтийн эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн, хууль зүйн ухааны доктор (Ph.D) |